


***ЖИНХЭНЭ АЗ ЖАРГАЛ***



***ТАНЬХ Ч БОЛЖ БОЛНО!***

*Жинхэнэ аз жаргал*

*таных ч болж болно*

..... ээс

---

..... нд

---

*Холбоо барих хаяг, утас:*

---

---

---

---

---

Нэр: **Жинхэнэ аз жаргал**

Зохиогчийн эрх: DenSu Ministries International-д хадгалагдах ба хэвлэх эрхийг Илгээлт нөхөд байгууллагад өгөв.

<http://www.densu.com>

Хэвлэн нийтлэгч: Илгээлт нөхөд ТТБ

Эх бэлтгэл, хавтсыг: DenSu Ministries International

Хяналт эхийг: DenSu Ministries International

ISBN 981-05-3674-7

Printer: BCI

Огноо: 2006 он

Тараагч:

Илгээлт нөхөд ТББ

Шуудангийн хайрцаг 180

Улаанбаатар 211213

Монгол Улс

Электрон шуудан: [ehc@magicnet.mn](mailto:ehc@magicnet.mn)

Бурханы ивээлээр энэ ном таны гар дээр үнэгүй очиж байгаа юм. Та залбирч байгаад хэдэн ном тараахаа шийдээд бидэнд хандаарай.

# Гарчиг

Нэгдүгээр бүлэг	
Жинхэнэ аз жаргал таных ч болж болно .....	5
Хоёрдугаар бүлэг	
Жинхэнэ аз жаргал одоо таных боллоо .....	15
Гуравдугаар бүлэг	
Жинхэнэ аз жаргал бол Бурханы хүсэл .....	23
Дөрөвдүгээр бүлэг	
Жинхэнэ аз жаргал бол Есүс таны дотор .....	31
Тавдугаар бүлэг	
Жинхэнэ аз жаргал бол үр дүнтэй залбирал .....	41
Зуравдугаар бүлэг	
Жинхэнэ аз жаргал бол Сүнс доторх амьдрал .....	50
Долдугаар бүлэг	
Жинхэнэ аз жаргал бол Бурхантай хамтрах .....	62
Нэмэлт .....	75
Бурханы Үг .....	81
Захиалах хуудас .....	83
Бурханы Аварлын төлөвлөгөө .....	85

## *Жинхэнэ аз жаргал таных ч болж болно*

### **Нэгдүгээр бүлэг**

*Жинхэнэ аз жаргал гэдэг нь бид бүхний хүсэн эрэлхийлж байдаг зүйл юм. Бид бүгдээр яс үндэс, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн байр суурь, оюуны чадамж, итгэл бишрэл болон боловсрол зэргээс үл хамааран бид бүгд жинхэнэ аз жаргалыг амсахыг хүсдэг. Жинхэнэ аз жаргалыг олж авах гэсэн энэхүү нийтлэг хүсэл эрмэлзэл маань бидний өдөр тутмын амьдралын салшгүй нэгэн хэсэг байх ёстой бөгөөд хүн бүр өөр өөрийн арга замаар өөрсдийгөө зөвтгөн байж үүнийг эрэлхийлдэг.*

*Энэ ертөнц бидэнд жинхэнэ аз жаргалд хүргэх бүх зүйлсийг өгөх гэж хичээдэг боловч хэрэв бид шударга дүгнэлт гаргавал бидний амьдралд ямар нэгэн зүйл үргэлж үгүйлэгдэж, аз жаргалгүй байгаагаа хүлээн зөвшөөрөх биз ээ. .*

*Зохиогч бид энэ номыг уншсан хэн ч бай жинхэнэ аз жаргалтай амьдрах хувь тавилантай хүн болно гэдэгт гүнээ итгэдэг.*

***Жинхэнэ аз жаргал таных ч болж болно...***

Хамгийн эхэнд Бурхан тэнгэр, газрыг бүтээв. Бүх зүйл сайхан байлаа. Газар дэлхий гайхамшигтай сайхан байсан бөгөөд Бурхан өөрсдийн төрхөөр бүтээсэн хамгийн эхний эрэгтэй, эмэгтэй хүнийг тэнд амьдруулжээ.

Тэд өөрсдийн Бүтээгчтэйгээ хамт байсан тул үнэхээр сайхан ивээлтэй амьдарч байв. Бурхан тэдэнд газар дэлхий дээрх бүх бүтээлүүдийг захирах онцгой эрхийг өгсөн бөгөөд тэдэнд өсөн үржиж, дэлхийг эзэгнэн захир хэмээжээ. Бурхан тэдэнд бүх амьтдыг нэрлэхээс аваад бүгдийг захирах эрх олгожээ.

Тэдний орон гэр болох Еден цэцэрлэг жинхэнэ диваажин байлаа. Еден гэдэг нь баяр, баясал гэсэн утгатай ажээ. Тэд өөрсдийн Бүтээгч Бурхантайгаа байнгын харилцаатай байсан бөгөөд бүх бүтээлтэй нь уялдаатай амьдарч байв. Тэнд ямар ч гэм нүгэл, хүчирхийлэл, өвчин зовлон, үхэл хийгээд дутах зүйл нэгээхэн ч үгүй байлаа. Энэ бол хүн төрөлхтөнд зориулсан Бурханы төлөвлөгөө байсан бөгөөд одоо ч хэвээр юм.

Хамгийн анхны эрэгтэй хүн болох Адам, түүний эхнэр, Ева хоёр энэ дэлхий дээр хамгийн гайхамшигтай амьдралтай хүмүүс байсан ба тэдний үр удам ч мөн адил ажээ. Бурхан тэдний амьдралыг үнэхээр аз жаргалтай байхаар хэрэгтэй бүх зүйлсийг өгөөд, тэдний аз жаргалыг хамгаалахын тулд нэгэн хязгаарыг тогтоожээ.

**Тэгээд ЭЗЭН Бурхан тэр хүнд тушаан ийнхүү өгүүлэв.**

**-Чи энэ цэцэрлэгийн аль ч модны жимсийг дураараа идэж болно. Харин чи сайн мууг мэдүүлэгч модны жимснээс огт идэж болохгүй. Чи түүнээс идсэн тэр өдөртөө л зайлшгүй үхнэ! хэмээн айлдав.**

Бурхан Адам, Ева хоёрт сонгох эрхийг өгчээ. Тэр тэднийг робот юм уу эсвэл модон хүүхэлдэй шиг бүтээгээгүй юм. Харин тэдэнтэй харилцан итгэлцэж, дотны харилцаатай байхыг хүсчээ. Бурхан тэднийг үхүүлэхийг хүсээгүй учир тэдэнд нэгэн модноос жимс идэхийг хориглов. Харин тэд Бурханд итгээгүй учраас дараах байдлаар мэхлэгдэв...

**ЭЗЭН Бурханы бүтээсэн аливаа хээрийн зэрлэг амьтдын дотроос могой хамгийн илүү зальтай байжээ. Тэр могой, -Та нарт энэ цэцэрлэгт байгаа бүх модны жимснээс идэж болохгүй гэж Бурхан үнэхээр хэлсэн үү? хэмээн эмэгтэйгээс асуужээ. Тэр эмэгтэй могойд хандаж, -Бид энэ цэцэрлэг дэх модны жимснээс идэж болно. Харин цэцэрлэгийн голд байгаа модны жимсний тухайд Бурхан “Та нар түүнээс бүү ид, бас түүнд бүү хүр, тэгвэл та нар үхнэ” гэж айлдсан хэмээжээ.**

Тэр могой эмэгтэйд, -Та нар ерөөсөө үхэхгүй. Та нар түүнээс идсэн тэр өдөртөө л нүд чинь нээгдэн, Бурхан шиг болж, сайн мууг мэдэх болно гэдгийг Бурхан мэддэг билээ гэжээ. Тэгээд тэр модны жимс нь хүнс болоход шимтэй, нүд булаам, мэргэн ухаантай болгочихмоор, шунал хөдөлгөм сайхан харагдсан тул тэр эмэгтэй түүнээс авч иджээ. Тэр бас өөртэйгөө хамт байсан нөхөртөө өгч, тэр ч иджээ.

Тэгээд тэр хоёрын нүд нээгдэж, хоёулаа нүцгэн байгаагаа мэдээд, инжир модны навчсыг хооронд нь холбож, өөрсдөдөө бэлхэмж хийжээ. Сэрүү ороход ЭЗЭН Бурханы цэцэрлэг дундуур алхаж яваа чимээг сонсоод, эр хүн эхнэртэйгээ хоёул ЭЗЭН Бурханы оршихуйгаас цэцэрлэгийн модон дотор нуугджээ. Гэтэл ЭЗЭН Бурхан хүнийг дуудаж, -Чи хаа байна вэ? гэсэнд,

Тэрээр, -Би Таны дууг цэцэрлэг дотор сонсоод, нүцгэн байсан учир айж, өөрийгөө нуусан юм гэж хэлэв. Тэгтэл Тэр, -Чамайг нүцгэн байсныг хэн чамд хэлсэн бэ? Бүү ид гэж миний чамд тушаасан тэр модны жимснээс чи идсэн үү? гэж асуусанд хүн, -Надтай хамт байлгахаар Таны надад өгсөн тэр эмэгтэй надад тэр модны жимснээс өгсөн. Тэгээд би идсэн гэж хэлэв. ЭЗЭН Бурхан тэр эмэгтэйд, -Чи яаж байгаа чинь энэ вэ? гэсэнд тэр эмэгтэй, -Тэр могой намайг мэхэлснээс болоод би идсэн гэв.

Адам, Ева хоёрын Бүтээгчдээ итгэлгүй, Үгийг нь үл тоомсорлосны үр дагавар тухайн үеээс өнөөг хүртэл хүн төрөлхтөнд учруулсан хамгийн их гай гамшиг байлаа. Адам, Ева хоёрын үл итгэл, дуулгаваргүй байдал нь хүн төрөлхтөнд гэм нүгэл авчраад зогсоогүй Бүтээгч Бурханаас нь хагацахад хүргэсэн юм. Тэдний үл итгэл болон гэм нүглийг үхэл хийгээд өвчин зовлон, хувиа хичээлт болон бүх төрлийн муу муухай зүйлс дагалдав.

Хүн төрөлхтний өвөг болсон Адам, Ева хоёр өөрсдийн бүтээгч Бурхандаа итгэхийн оронд могой буюу буг болох Сатаны үгэнд итгэв. Үүний дүнд хүн төрөлхтөн гэм нүглээс болж Бурханаас салаад зогссонгүй, харин Сатан энэ ертөнцөд хүний дээр эрх мэдэлтэй болов. Бурхан Адам, Ева хоёрт энэ дэлхийн бүх амьтад, түүн дотор могойг захирах эрх мэдэл өгсөөр атал эрх мэдлээ ашиглан, Бүтээгч Бурхантайгаа хамт энэ дэлхийг захирхын оронд гэм нүгэл хийгээд Сатанд боолчлогдов.

Ингэснээр тэдэнд болон тэдний үр удам болох хүн төрөлхтөнд зориулсан Бурханы төлөвлөгөө нурав. Амьдрал Бурханы ивээл, хангалтаар дүүрэн байхын оронд амьд үлдэх тэмцэл болж хувирав. Гэм нүгэл энэ дэлхийд орж ирснээр хүн Бурханаас тусгаарлагдаж,

Сатаны үйл ажиллагаа ихэссэн нь яагаад өнөөдөр хүн төрөлхтөн ийм эмх замбараагүй самууралд байгаа болон, амьдралын доод түвшин, бүхий л хувиа хичээлт, өвчин эмгэг, ядуурал, егүүтгэл, аллага, бэлгийн харилцааны гажуудал, эрх мэдлийн эсрэг тэрслэлт, гэр бүл салалт, архи дарс ба хар тамхи, хүчирхийлэл, нийгмийн гаж үзэгдлүүд байгааг тайлбарлаж байгаа юм.

Ихэнхи хүмүүс мэдлэггүйгээсээ болж, мөн бугийн мэхлэлтээр өөрсдийн амьдрал, гэр бүл болон эх орондоо болж буй бүхий л эмх замбараагүй байдалд Бурханыг эсвэл “бурхдыг” буруутгаж байдаг. Хүн төрөлхтөн асуудлынхаа голыг нь ололгүй, амьдралд тэмцэлдэн, багагүй амжилтанд хүрч, зарим нь хэдий оргилд хүрсэн ч эцэст нь Бурхангүй мөнх амьдрал, шүүлт, үхэлтэй тулгарах юм.

Хүмүүс өөрсдийн амьдралд үгүйлэгдээд байгаа тэр хоосон орон зайг бүрэн бүтэн болгохын тулд өдөр шөнөгүй зүтгэх авч ямар ч үр дүнд хүрэхгүй юм. Зугаа цэнгэл, секс, хар тамхи, архи, спорт, амжилт, тэр ч бүү хэл шашин Бурханы үлдээсэн орон зайг эзэлж чадахгүй бөгөөд зөвхөн Бүтээгчтэйгээ харилцах харилцаа нь дүүргэж чадах билээ. Сатан болон түүний ертөнц цаг зуурын таашаал өгөөд эцэст нь хоосролд хүргэдэг байна.

Дүр төрхийнх нь дагуу бүтээгдсэн хүмүүс итгэлгүйгээсээ болж гэм нүгэл үйлдснээр Бурханаас тусгаарлагдсан хэдий ч Бурхан тэднийг хайрласаар байсан юм. Бурханы биднийг гэсэн хайр хэдий өөрчлөгдөөгүй ч, Тэрээр Өөрийн гаргасан хууль дүрмийг зөрчиж чадахгүй. Учир нь гэвэл Түүний Үгэнд хэн ч итгэх аргагүй болох юм. Тиймээс Тэр хүн төрлөхтний өмнө тулгараад байсан энэхүү асуудлыг шийдэж, анхных нь амар тайван, ивээл, хангалуун байдалд оруулснаар Бурханы Үг үнэн болохыг харуулж, урьдаас Бурханаас өгөгдсөн байсан эрх мэдлийг эргүүлэн өгөх зорилготой байв.

Бурханы шударга байдал хангагдахын тулд хүн гэм нүгэлдээ шийтгэл хүлээх ёстой байв. Тэрхүү шийтгэл нь энэ биеийн үхэл байгаад зогсохгүй мөн Бурханаас мөнх тусгаарлагдах сүнсний үхэл юм. Тийм учраас анхнаасаа буг болон чөтгөрүүдэд зориулагдан бүтээгдсэн тамд нүгэл дотроо үхсэн хүмүүс Бурханы оршихуйгаас мөнхөд тусгаарлагдан очих болсон юм.

Гэсэн хэдий ч Бурхан хүн төрлөхтнийг бүрэн устгахын оронд Тэр тэдэнд гэм нүглээс аврагдан, өөрсдийн Бүтээгчтэйгээ эвлэрч, Бурханы зохиосон тэрхүү сайхан харилцаатай амьдралыг олох арга замыг хангаж өгсөн билээ. Тэр бидний амьдралыг захирч байсан Сатаны гэм нүглийн боолчлолоос хөлсийг нь төлж, чөлөөлөх



арга замыг нээсэн юм. Бурхан үүнийг Өөрийн Хүү Есүс Христээр дамжуулан хийжээ.

**Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм.** Бурханы Хүү, Есүс, ер бусын байдлаар Израилийн Бэтлэхэм хотод төржээ. Марь гэдэг нэгэн онгон эмэгтэй Бурханы Хүү Есүсийг тээсэн юм. Бурханы Ариун Сүнс тэр эмэгтэйг хучин, хөл хүндтэй болгож, Бурханы Ариун Хүүхэд болох Есүс төрсөн билээ.

Есүсийн энэ дэлхий дээр ирэх болсон шалтгаан болон Түүний амьдралд биелэх олон үйл явдлыг хэдэн зууны өмнөөс урьдчилан хэлэгдсэн байжээ. Түүний талаар хэлэгдсэн бүх зөнгийн үгс нэг бүрчлэн биелэгдсэн юм. Тэрээр хүн ба Бурханы мэлмийд тааллыг олж, энэ дэлхийд 33 жил амьдарч, ирсэн зорилгоо биелүүлээд Тэнгэрт буй Бурхан Аав уруугаа буцсан юм.

Есүс бусад хүнээс огт өөр байлаа. Түүнд хүмүүн эцэг байгаагүй юм. Есүс Адамын цусан ургаас гараагүй, Тэр хэдийгээр тэдний адил Сатанд соригдсон хэдий ч, нэг ч гэм нүгэл үйлдээгүй билээ. Тэр бугийн бүх л заль мэх, урхийг эсэргүүцэж чадсан юм. Тэр үргэлж Бурханы хүслийг биелүүлэн, Тэнгэриг Аавдаа дуулгавартай амьдарсан юм.

Тиймд Есүс хүн төрлөхтнийг аврах Бурханы төлөвлөгөөг биелүүлж чадсан юм. Тэр бол бидний асуудлыг шийдэх Бурханы түлхүүр болсон юм. Бурхан бидний гэм нүглийг шийтгэхийн оронд Өөрийн Хүү Есүсийг шийтгэсэн юм. Энэ дэлхийд амьдарч байсан цорын ганц гэм нүгэлгүй хүн болох Есүс Христ Өөрийгөө та бид болон бүх хүн төрлөхтний төлөө өргөл болгон өргөжээ. Есүс 2000 гаруй жилийн тэртээ загалмай дээр цовдлогдон нас барахдаа Өөрийн ариун цусаа та бидний гэм нүглийн төлөөсөнд урсгаж, амьдралыг маань захирч байсан Сатаны эрх, гэм нүглийн үр дагавраас биднийг чөлөөлж өгсөн юм.

Есүс Христ тэр өгөр модон загалмай дээр биднийг төлөөлсөн юм. **Тэр нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө нүгэл болгосон юм. Тэгснээр бид Түүний дотор Бурханы хүртээх зөвт байдал болох юм.** Тэр биднийг орлосон юм. Ингэснээр бид Түүний адил болохын тулд Тэр бидний оронд үхсэн юм. Тэр загалмай дээр бидний гэм нүгэл, өвчин зовлонг Өөрийн биеэр эдэлж, оронд нь бидэнд Өөрийн зөвт байдал, эрүүл мэнд, бялхам амийг өгсөн юм. Тэр бидний ялагдлыг ялалт болгож, Бурханы төлөвлөсөн бялхам амийг өгөхийн тулд бидний оронд үхэв.

Есүс Христ урьдаас хэлэгдсэнчлэн бидний төлөө үхээд, оршуулагдан, Судрын дагуу гурав дахь өдөртөө амилуулагджээ. Тэрээр Кефт, дараа нь өнөөх арван хоёрт үзэгдэв. Үүний дараа Тэр таван зуу гаруй ах дүү нарт нэг мөчид үзэгдсэн байна. Удалгүй Есүс Өөрт нь итгэх сонголт гарган, Есүс Христийг өөрийн Аврагч Эзэн болгон хүлээн авсан хүн болгонд очих орон байр бэлдэхээр Тэнгэрийн улс өөд гарчээ. Нэгэн өдөр Есүс Өөрт нь итгэсэн бүх хүмүүсийг Тэнгэрийн улсад аваачихаар буцаж ирэх болно.

Есүс Христ гэм нүгэл, өвчин эмгэг, үхэл болон диаволын бүхий л ажлыг ялан дийлсэн билээ. Тэр амьд бөгөөд ялгуулсан амьдралаар мөнхөд байх болно. Тэр энэ бүхнийг та бидний төлөө хийсэн ба мөн Өөрт нь итгэл найдвараа өгөн, Есүс Христийн урсгасан цусанд итгэж, өөрийн Аврагч Эзэнээ болгохоор хүлээн авсан бүх хүний төлөө хийсэн юм. **Учир нь “Эзэний нэрээр дуудах хэн ч аврагдах болно”.**

Энэ номонд өгүүлж буй бүхэн Бурханы Үг болох Библи хэмээх номонд бичигдсэн Үнэн дээр үндэслэгдсэн юм. Библи бол Бурханы хүн төрөлхтөнд Өөрийгөө илчилсэн ном мөн. Бурхан Өөрийн Үгээ мянга мянган жилийн турш хамгаалсан явдал нь та бид юунд итгэж, хэрхэн гэм нүглээс аврагдах болон өөрсдийн Бурхан, Бүтээгч, Аврагч ба Андтайгаа хэрхэн харилцаатай байхыг зааж өгөхийн тулд билээ.

Та дөнгөж сая Есүс Христ таныг Бурхантай эвлэрүүлэн, нэгтгэхийн тулд хоёр мянгаад жилийн тэртээ таны өмнөөс загалмай дээр үхсэн тухай Сайн Мэдээг уншлаа. Та үхсэнийхээ дараа мөнхийн тамд шийтгэл амсахгүйн тулд Тэр таны оронд шийтгэл хүлээсэн юм. Та бидний гэм нүгэл дааж давахын аргагүй өр үүсгэсэн тул Тэр бидний өмнөөс бүгдийг нь төлсөн байна. Ингэхийн тулд Тэр Өөрийн амиа зориулсан нь та бидэнд ямар их хайртай болохоо харуулжээ. Та Бурханаар хайрлагдсан хүн шүү.

Бурхан таныг Өөртөө эргүүлэн авахын тулд цорын ганц хүү Есүс Христийг таны оронд өгсөн явдал нь Түүний хайрыг илэрхийлж байгаа тул та ямар хариу барих вэ? Танд мөнхийн амь өгөхийн тулд таны өмнөөс тэрхүү аймшигтай шийтгэлийг эдэлж, таны төлөө амиа зориулсан Есүсийн хайранд та хэрхэн хариу барих вэ? Яг одоо танд Есүс Христийг илчилж байгаа Ариун Сүнсэнд та яаж хандах гэж байна вэ? Танд хоёрхон сонголт байна.

Танд нэг бол Сайн Мэдээнд итгэх, эсвэл үл итгэн Есүс Христийн тухай энэхүү мэдээг үгүйсгэх гэсэн хоёр сонголт байна. Та нэг бол Бурханы Хүү Өөрийн халуун амиараа төлөөсийг нь төлсөн үнэлж баршгүй бэлгийг хүлээн авах, эсвэл ямар ч хариу барилгүй,

ингэснээрээ Түүний танд өгч буй зүйлийг үгүйсгэх сонголт танд байна. Та нэг бол Бурханы уучлалыг хүлээн аван, Түүнтэй эвлэрэх эсвэл өөрийн гэм нүгэлдээ мөнхөд үхсэн хэвээр байх болно. Танд Эзэний нэрийг дуудаж аврагдах эсвэл Бурхангүй, ямар ч итгэл найдваргүй гээгдсэн хэвээр үлдэх гэсэн сонголт байна.

Бурхан таныг Өөрт нь итгэж, Хүү Есүс Христийг нь бүхий л дагалдах сайн сайхан зүйлстэй нь хамт хүлээн аваасай гэж хүсдэг бол Сатан анхны хүмүүс болох Адам, Ева хоёрын адил түүний хяналтан дор хэвээр үлдэхийг хүсдэг. Сатан таныг хараагдсан байхыг хүсдэг бол Бурхан танд туслахыг хүсдэг. Сатан таныг зовоохыг хүсдэг байхад Бурхан таныг гэмийн үр дагавраас ангид чөлөөтэй байгаасай гэж хүсдэг. Бурхан таныг бялхсан амь, амьдралтай байхыг хүсдэг, харин Сатан таныг гачигдал хийгээд өвчин зовлонд баригдаасай гэдэг. Бурхан бол амийг тэтгэгч, Сатан бол үхлийг тэтгэгч мөн. Бурхан таныг Өөртэй нь Тэнгэрийн улсад мөнхөд амьдраасай гэж хүсдэг. Харин Сатан таныг өөртэй нь хамт мөнхөд тамд байгаасай гэдэг.

**Тэрээр диаволд дарлагдсан бүгдийг эдгээн, сайныг үйлдэж явсан тухай юм.** Тэр өвчтэй хүмүүсийг эдгээж, сохорыг хараатай, сонсголгүйг сонсголтой, хэлгүйг хэлтэй болгож байсан юм. Тэр бузар сүнснүүдийг хөөж, үхэгсдийг амилуулж, уяман өвчтэй хүмүүсийг эдгээж, доголонг хөлтэй болгож байжээ. Ямар ч өвчтэй байсан хамаагүй Өөрт нь итгэл өвөрлөн ирсэн хэнийг ч болов Тэр эдгээж байлаа. Түүнд итгэж найдаж байсан хэний ч нүглийг Тэр уучилж, цагаатгаж байсан юм. **Нүгэл үйлддэг нэгэн нь диаволынх юм. Диавол эхнээсээ нүгэл үйлдсэн. Диаволын үйлсийг устгахын тулд Бурханы Хүү энэ зорилгын төлөө үзэгджээ.**

**Есүс Христ очигдөр ч, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ байна.** Тэр 2000 гаруй жилийн тэртээд хийж байсан үйлсээ одоо ч хэвээр үйлдсээр байгаа билээ. Түүний хайр бодитой тул та Түүнд итгэж болно. **Учир нь Бурханы бүх амлалт Түүний дотор “За” гэдэг. Тиймд бид Бурханы алдрын тулд Түүгээр дамжуулан “Амен” гэдэг. Есүс -Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй гэж хэлэхдээ үнэхээр үүнийг л хэлсэн аж. Есүс Христэд итгэхээс өөр Бурханд хүрэх арга зам гэж үгүй юм. Есүс -Би бол амилалт ба амь мөн. Надад итгэдэг хүн үхэвч амьдарна гэх хэлсэн юм.**

**Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ.**

Таны хувьд амьдралынхаа хамгийн чухал шийдвэрийг гаргах сонголт тулгараад байна. Та энэ мөчид санамсаргүй тохиолдлоор ирээгүй харин Бурханы хайр таныг удирдан энд авчирсан юм. Ариун Сүнс таныг Түүн рүү дагуулан, танд аврал, амар тайван, баяр хөөр, аюулгүй байдал, аз жаргал хийгээд элбэг дэлбэг, сэтгэл хангалуун цоо шинэ амьдралтай болохын зэрэгцээ Тэнгэрийн улсад мөнх амьдрах эрх өгөх болно.

Танд урьдын адил Сатаны удирдлаган дор хэвээр үлдэх сонголт байгаа, тэгвэл та энэ бүлгийг дахин уншаад ухаалаг сонголт хийхийн төлөө залбираарай гэж хүсч байна. Хэрэв та өөрийн Бүтээгчтэйгээ эвлэрэн, таны амьдрал анхныхаа төлөвлөгдсөн голдрилдоо орохыг хүсч байвал дараах залбирлыг дагаад хэлээрэй:

*Бурхан минь ээ,*

*Та намайг Өөрийн дүр төрхөөр бүтээгээд, хэдий гэм нүгэлд унасан ч орхилгүй, өдий хүртэл халамжилж, хайрласаар Өөрийн цорын ганц хайртай Хүү Есүс Христийг миний өмнөөс загалмай дээр алуулан, Түүний урсгасан цусаар намайг Сатан болон гэм нүглийн хүлээнсээс золин авсанд баярлалаа.*

*Би яг одоо, энд Эзэн Есүс Христийн Нэрэнд итгэж, өөрийн зүрх сэтгэлийн үүд хаалгыг нээн Түүнийг өөрийн Аврагч, Эдгээгч, Чөлөөлөгч, Золигч ба Хангагч хэмээн хүлээн авч байна. Би өөрийн амаар Есүс Христийг Эзэн гэж тунхаглан, Та Түүнийг үхэсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэж байна. Есүс амьд бөгөөд очигдөр, өнөөдөр ба ирээдүйд мөнхөд хэвээр гэдэгт итгэж байна. Би яг одоо аврагдахын тулд Эзэн Есүс Христийн нэрийг дуудаж байна.*

*Та намайг аварч, миний бүх нүглийг уучлан, мартсанд баярлалаа. Би энэ цагаас эхлэн өөрийн бодол, санаагаа өөрчлөн, намайг гэсэн Таны хайрын улмаас Таныг болон бусдыг хайрлаж амьдрах шийдвэр гаргаж байна. Та бол цорын ганц Үнэн Бурхан гэдэгт итгэж байна. Та миний амьдралд хамгийн чухал байр эзэлж байгаа тул энэ мөчөөс эхлэн өөрөө өөрийн амьдралаа удирдаж байснаа орхин, Таныг болон Таны хүслийг мэдэхийг хүсч байна. Та болон Таны Үеийн эсрэг өөрийгөө өргөмжлөгч хэн бүхнийг, юм бүхнийг Сатаны хамт үгүйсгэн, эсэргүүцэж байна.*

*Намайг байгаагаар минь хүлээн авч, Өөрийн Хүүхэд болгон, намайг хэзээ ч гэм хийж байгаагүй мэт надад ивээл, ерөөлөөр дүүрэн цоо шинэ, бялхан амьдрал өгсөнд баярлалаа. Миний Тэнгэрлиг Аав болж, надад Мөнхийн Амийн бэлгийг үнэгүй өгсөнд баярлалаа. Таны хайр, уучлал, хүлээн авалтыг миний ухаан хэзээ ч ойлгож чадахгүй ч даруу, баяр*

талархал бүхий зүрхээр бүгдийг хүртэж, Таны хүүхэд болсныхоо хувьд Тантай харилцах харилцаандаа улам өснө гэдэгт итгэж байна.

Таны Үг ба Таны оршин байдагт дахин хэзээ ч эргэлзэхгүй. Та хэлсэн болгондоо хүрдэг, мөн Өөрийнхөө тухай хэлсэн болгонд тань би итгэнэ. Миний төлөө Таны хийсэн болгонд би итгэж байна. Би одоо Таны хэлснээр хэн нэгэн болсон, Таны надад байгаа гэж хэлсэн болгон надад байгаа болон мөн би бүхнийг хийж чадна гэж Таны хэлсэнд би итгэж байна.

Тиймд би Таны Хүүхэд болсны хувьд Таны гэр бүлд зохих ёсны байр сууриа эзэлж байна. Би шинэ амьдралынхаа төлөө талархан, хамгийн сайнаар амьдрахыг хүсч байна. Тэнгэрлиг Аав минь, Та Өөрийн Ариун Сүнсээ надад дүүргэн өгөөд, бүхий л үнэнд дагуулна гэж амласныхаа дагуу миний амьдралын бүхий л замыг удирдан, надад бүх зүйлийг заан, намайг дагуулаач. Таны таалалд нийцэх зүйлсийг мэдэж, тэдгээрийг хийх зүрх зоригийг өгөөч. Би үнэхээр Танд таалагдахыг хүсч байна.

Есүс ээ, Та Өөрийн биеээр миний бүхий л гэм нүгэл, өвчин эмгэг, зовлон зүдгүүр болон миний эдлэх ёстой байсан нүглийн бүхий л шийтгэлийг загалмай дээр үүрсэнд баярлалаа. Намайг гэсэн Таны хайр, миний төлөө Өөрийн ариун цусаа урсгасан болохоор би өөрийн бүхий л амьдралаараа Таныг хүндэтгэж, Танд зориулмаар байна. Та миний дотор байж, хэзээ ч намайг орхихгүй, надтай үргэлж байна гэдэгт би итгэж байна, Есүс ээ. АМЕН.

### Миний шийдвэрийн тэмдэглэл

Миний бие Есүс Христийг өөрийн Аврагч Эзэн болгон хүлээн авсан гэдэг нь тэнгэр газар хийгээд газрын гүнд илэрхий болтугай. Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэж, Түүнийг Эзэн гэж амаараа тунхаглаж байна.

Нэр: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

Цаг мөч: \_\_\_\_\_

Газар: \_\_\_\_\_

Та өөрийн гаргасан шийдвэрээ бидэнтэй хуваалцана уу. Бид таны баяр хөөрөөс хуваалцаж, таны төлөө залбирах хүсэлтэй байна.

Илгээлт нөхөд  
Шуудангийн хайрцаг 180  
Улаанбаатар 211213

## *Жинхэнэ аз жаргал таных ч болж болно*

### **Хоёрдугаар бүлэг**

*Жинхэнэ аз жаргал одоо таных боллоо. Хэрэв та нэгдүгээр бүлэгт дээрх залбирлыг чин сэтгэлээсээ залбирсан бол та өөрийн Бүтээгч Эзэнтэйгээ Түүний Хүү Есүс Христээр дамжуулан шинэ, амьд харилцаатай боллоо.*

*Бурханы танд бэлдсэн амьдрал ямар гайхамшигтай болохыг та одоо төсөөлж чадахгүй, гэхдээ хамгийн гоё нь тэр амьдрал нь хэзээ ч төгсөхгүй бөгөөд өдрөөс өдөрт энэ амьдралын туршид хийгээд бүр мөнхөд гайхамшигтай, яруу алдраар дүүрэх болно.*

*Энэ номын хоёрдугаар бүлэгт Есүстэй эхлүүлсэн шинэ амьдралд тань хэрэгтэй мэдээлэл бий. Таны амьдралын утга учир бүрмөсөн шинэчлэгдэнэ. Та өөрийгөө цоо шинэ хүн болсон байхыг нээж илрүүлнэ, хуучин нь өнгөрч, шинэ бүхэн нь Бурханаас ирэх болно.*

*Таны хувьд ялагдагч болсон Сатаныг хэрхэн ялан дийлж амьдрахад та суралцана. Есүс Христ энэ дэлхийд байхдаа Сатаныг хэрхэн ялан дийлж байсан ба Өөрийн үхэл, дахин амилалтаар түүнийг хэрхэн бүрмөсөн ялсныг та харах болно. Есүсийн харын хүчийг ноёрхсон тэрхүү эрх мэдэл нь одоо таных болсон юм.*

***Жинхэнэ аз жаргал одоо таных.....***

Есүс Христийн загалмай дээр урсгасан ариун цусанд итгэсэн итгэлээр өөрийн Бүтээгч рүүгээ эргэх шийдвэр гаргасанд тань дахин баяр хүргэе. Энэ бол таны амьдралдаа гаргасан хамгийн чухал шийдвэр мөн.

Та Эзэний Нэрийг дуудан Есүс Христийг өөрийн Аврагчаа болгож авсан тэр мөч, байр, он сар өдрөө тэмдэглэхээ мартуузай. Энэ бол танд болон таны дайсан болсон Сатан ба түүний чөтгөрүүдэд маш утга учир бүхий сануулга болно.

Та урьд нь хэзээ ч гэм нүгэл үйлдэж байгаагүй мэт таны Бурхантай харилцах харилцаа тань цоо шинэ болсон. Адам, Ева хоёрт гэм хийхээс өмнө байсан Сатаныг захирах эрх одоо танд байгаа, гэхдээ энэ нь Сатан таны Есүс Христээр дамжин Бурхан уруу эргэх шийдвэрт тань нөлөөлөхөө болино гэсэн үг биш.

Та Эзэнтэй харилцах харилцаандаа хичнээн их өсөн, өөрчлөгдсөн ч диавол хэзээ ч өөрчлөгдөхгүй. Тэр алж, хулгайлж, сүйтгэхээр ирсэн бөгөөд тэр айдас, худал хуурмаг, гүтгэлэг, мэхлэлт, дарамт болон буруутгалыг ашигладаг. Библид түүнийг “худал хуурмагийн эцэг” гэсэн байдаг. Түүнд таныг захирах хүч одоо байхгүй болсон ч, тэр худалч тул одоо хэр таныг захирах гэж оролдоно гэдгийг санаж яваарай.

Гэсэн хэдий ч, өөр хэзээ ч үл өөрчлөгдөх Нэгэн бол Бурхан, Түүний Үг ба Амьд Үг болох Түүний Хүү Есүс мөн. Та одоо диаволоос айх хэрэггүй болсон. Та бол Бурханы хүүхэд бөгөөд таны дотор амьд оршигч, Есүс, таны дайсан болох бугаас илүү хүчтэй.

Диаволын хамгийн эхний дайрах талбар бол таны Эзэн Есүс Христийг хүлээн авсан явдал юм. Тулааны талбар нь таны оюун ухаан байх бөгөөд тэр таны Бурхантай тогтоосон шинэ харилцаанд тань эргэлзээ төрүүлэхийг хичээх болно. Одоо тэр танаас айж байгаа.

Тэр Адам, Ева хоёрт тэрхүү эргэлзээг төрүүлж чадсан нь тэднийг дуулгаваргүй байдалд түлхэж, Бурханаас салахад хүргэсэн юм. Есүс цөлд соригдохдоо зөвхөн Бурханы Үгээр эсэргүүцсэний адил тэдэнд байсан эрх мэдлээр тэд ялан дийлэх ёстой байсан юм. Одоо Адам, Ева бус харин Есүс бидний үлгэр дууриал болсон. Бид Адам, Ева хоёрын соригдсон тухай үзсэн тул одоо Есүс Христийн сорилтоос суралцъя.

**Есүс Ариун Сүнсээр дүүрч Иорданаас буцаж цөлд Сүнсээр хөтлөгдөн, дөчин өдрийн турш диаволд соригджээ. Тэр үеийн турш Тэр юу ч идээгүй учир тэдгээр өдрүүдийг дууссаны дараа ихэд өлсжээ.**



Диавол Түүнд, -Хэрэв Чи Бурханы Хүү мөн юм бол энэ чулуунд талх бол гэж тушаал даа гэв.

Есүс, -"Хүн зөвхөн талхаар амьдардаггүй" гэж бичигдсэн байдаг гэлээ. Дараа нь тэр Түүнийг дээш аваачаад, хоромхон зуур дэлхийн бүх хаанчлалуудыг үзүүлэв.

Тэгээд диавол Түүнд, -Энэ бүх эзэмшил болон тэдгээрийн сүр хүчийг би Чамд өгье. Учир нь энэ бүгд надад өгөгдсөн юм. Би үүнийг хүссэн хүндээ өгч чадна. Тиймээс хэрэв Чи надад мөргөвөл, энэ бүгд Чинийх болно гэхэд,

Есүс түүнд, -"Чи өөрийн Бурхан Эзэндээ мөргөж, зөвхөн Түүнд үйлчил" гэж бичигдсэн байдаг гэв.

Тэр Түүнийг Иерусалим уруу аваачаад сүмийн орой дээр зогсоогоод, түүнд, -Хэрэв Чи Бурханы Хүү мөн юм бол эндээс доошоо үсэр. "Чамайг хамгаалах үүргийг Тэр тэнгэр элч нартаа өгнө"мөн "Тэд гар дээрээ Чамайг өргөөд авч явна.

Ингэснээр Чи хөлөө чулуунд цохихгүй юм" гэж бичигдсэн байдаг шүү дээ гэсэнд,

Есүс -"Чи өөрийн Бурхан Эзэнээ сорьж үл болно" гэж бас айлдсан байдаг гэлээ.

Диавол хамаг сорилтоо бараад, тохиромжтой цаг иртэл Түүнийг орхин оджээ. Есүс Сүнсний хүч дотор Галилд буцаж ирэв. Түүний тухай зар эргэн тойрон дахь газар тархсан байлаа. Тэр синагогуудад нь сургаал зааж эхэлсэн агаад бүгд Түүнийг магтан шагшицгааж байв.

Диавол Есүсийг Бурхантай харилцах харилцаандаа эргэлзэхийг хүссэн. Диавол Түүнд -Хэрэв Чи Бурханы Хүү мөн юм бол энэ чулуунд талх бол гэж тушаа л даа гэв. Харин Есүс -"Хүн зөвхөн талхаар амьдардаггүй" гэж бичигдсэн байдаг гэлээ.

Есүс Христ Сатаны тавьсан Тэнгэрлиг Аавдаа эргэлзэх эргэлзээг амжилттай ялан дийлсэн нь бидний хувьд диаволыг хэрхэн эсэргүүцэх тод үлгэр жишээ болсон юм. Бурханы Үгэнд тэрсэлсэн аливаа бодол санаа, мэдрэмж, үзэгдэх зүйлс эсвэл сонсогдох зүйлсийг Бурханы Үгээр эсэргүүцэх хэрэгтэй.

Бурхантай харилцаж буй хүн бүрийн харилцаа итгэл дээр суурилсан байх ёстой. Итгэлгүй байдал нь дуулгаваргүй байдалд хөтөлж, нүгэл үйлдэхэд хүргэн Бурханаас тусгаар болгосон юм. Тиймд Бурханы Үгэнд итгэж, найдах нь Түүн рүү хүрэх цорын ганц арга мөн.

Библид **Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурхан уруу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой** гэжээ. Бурханд итгэх итгэл гэж юу вэ? Энэ нь Бурхан Үнэн гэж хэлсэн болгон Үнэн, Хийнэ гэж хэлсэн болгоноо хийнэ гэдэгт итгэхийг хэлнэ.

Диавол бол худалч бөгөөд Үнэнийг үзэн яддаг. Тэр худал хэлж үл чадах Бурханыг болон Түүнд итгэсэн хэнийг ч болов үзэн яддаг. Тэр бол Бурханы болон Үнэний дайсан бөгөөд Үнэнээр амьдрагч бүхнийг үзэн яддаг юм.

Адам, Ева хоёр соригдохдоо Бурхан ба Түүний Үгэнд итгээгүй юм. Харин ч Бурханы Үгэнд найдахын оронд түүний үгийг сонсож, санааг нь дагаж, үйлдэл болгосон байна.

Энэ номын нэгдүгээр бүлэгт таны итгэл үндэслэгдсэн байх ёстой олон Үнэнийг та уншсан билээ. Та өөрийн ухаан, сэтгэл хөдлөл хийгээд мэдрэмжиндээ итгэж болохгүй. Та зөвхөн Түүний Үгэнд итгэж, хий гэсэн зүйлийг нь хийсэн учраас аврагдсан гэдгээ мэдэх ёстой.

Сатан таны аврал болон Бурхантай тогтоосон харилцаанд эргэлзээ суулгахын тулд ёстой бөмбөгдөх болно гэдгийг санаж яваарай. Бусад хүмүүс болон таны өөрийн сэтгэл хөдлөл тань таныг эргэлзүүлэх болно шүү.

Гэхдээ одоо таны дотор амьд байгаа Ариун Сүнс Бурханы Үг болон Түүний амлалтуудыг таны итгэлээр дамжуулан сануулж байх бөгөөд таны сүнсэнд Түүний хүүхэд болсон гэж гэрчлэх болно. Хэрэв та бусдын хэлэх үгс болон таны өөрийн сэтгэл хөдлөлөөс илүүд Бурханы Үгэнд итгэх сонголтыг гаргавал амар тайвны Бурхан тантай үргэлж хамт байх болно.

Бурханы танд өгсөн эрх мэдлийг хэрхэн ашиглахад суралцах нь маш чухал билээ. Хэрэв та ялагдсан бус, харин Христигэлт ялгуулсан амьдралаар амьдрахыг хүсч байвал Бурханы танд өгсөн сүнслэг зэвсгүүдийг ашиглах хэрэгтэй. Есүс таны өмнөөс ялалт байгуулсан тул Сатан таныг Бурханы Үгэнд эргэлзүүлэх гэсэн оролдлого бүрийг та ялах учиртай.

Бурханд итгэх итгэлдээ баттай зогсох дасгал хийцгээе. Та дараах байдлаар соригдоход доорхи хариултуудыг бариарай:

1. Та үнэндээ аврагдаагүй, аврагдахын тулд сайн үйлс хийх ёстой. Та зүгээр л Есүсийн Нэрийг дуудаад, итгэлээр аврагдах боломжгүй.

**Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр биш аж. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно** гэж бичигдсэн байдаг бөгөөд би үүнд итгэж байна.

**Учир нь “Эзэний нэрээр дуудах хэн ч аврагдах болно”** гэж бичигдсэн байдаг ба би Эзэний нэрийг дуудан аврагдсан.

**Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно** гэж бичигдсэн байдаг. Би Есүсийг Эзэн гэж амаараа тунхаглаж, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэсэн тул би аврагдсан юм.

2. Та үнэндээ Бурханы Хүүхэд болоогүй, та урьдын адил харын хүчинд захирагдсан хэвээр байна.

**Учир нь Тэр биднийг харанхуйн эрх мэдлээс авраад, Өөрийн хайрт Хүүгийнхээ хаанчлалд шилжүүлсэн юм. Хүүгийнх нь дотор бидэнд нүглийн уучлал болох золилт байна** гэж бичигдсэн байдагт би итгэж байна.

**Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв** гэж бичигдсэн байдаг бөгөөд би Түүний Нэрэнд итгэж, Есүсийг өөрийн Аврагч болгосон тул би Түүний хүүхэд болсон гэдэгт би итгэж байна.

**Бид Бурханы хүүхдүүд гэж нэрлэгдэх болгосон нь Бурханы хайр ямар агуу вэ. Бид үнэхээр Түүний хүүхдүүд билээ** гэж бичигдсэн байдаг тул би Түүний хүүхэд болсондоо Бурханы Хайр ба Түүний Үгэнд талархаж байна.

3. Чиний нүгэл уучлагдаагүй, учир нь чи дэндүү их муу юм хийсэн шүү дээ.

**Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй. Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ** гэж бичигдсэн байдаг бөгөөд би одоо Есүс Христийн дотор нүгэл ба үхлээс чөлөөлөгдсөн.

**Бяцхан хүүхдүүд ээ, нүгэл чинь Түүний нэрийн учир уучлагдсан тул би та нарт бичиж байна** гэж бичигдсэн байдаг бөгөөд миний нүглүүд Таны нэрээр уучлагдсанд баярлалаа.

Яагаад гэвэл Би тэдний гэм бурууд өршөөнгүй хандана. Би цаашид тэдний нүглүүдийг дурсахгүй гэж бичигдсэн байдаг бөгөөд миний нүглүүд дахин дурсагдахгүй тул баярлалаа, Эзэн минь ээ.

4. Чи аврагдсан ба мөнхийн амьтай болсон эсэхээ баттай мэдэж чадахгүй.

**Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм гэж бичигдсэн байдаг бөгөөд надад мөнхийн амьдрал өгөхийн тулд цорын ганц Хүүгээ өгсөнд баярлалаа, Бурхан минь ээ.**

**Би тэдэнд мөнх амийг өгнө. Тэд хэзээ ч мөхөхгүй бөгөөд тэднийг хэн ч Миний гараас булаахгүй гэж бичигдсэн байдаг тул Таны Үг Үнэн бөгөөд Мөнх амийн бэлгийг үнэгүй өгсөнд баярлалаа.**

**Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Христ Есүс доторх мөнх амь мөн гэж бичигдсэн байдагт би итгэдэг.**

**Тэр нь мэхэлдэггүй Бурханы мөнх цагаас өмнө амласан мөнх амийн найдварт үндэслэсэн юм гэж бичигдсэн байдаг ба Бурхан худал хэлж чаддаггүй гэдэгт би итгэж байна.**

**Энэ бол Тэр Өөрөө бидэнд амласан амлалт болох мөнх амь юм гэж бичигдсэн Мөнхийн Амьдралын амлалтанд тань баярлалаа.**

**Гэрчлэл нь энэ байна. Бурхан бидэнд мөнх амийг өгсөн бөгөөд энэхүү амь нь Түүний Хүүгийн дотор байна. Хүүтэй хүнд амь бий. Бурханы Хүү байхгүй хүнд амь байхгүй. Та нар мөнх амьтай гэдгээ мэдээсэй гэсэндээ би Бурханы Хүүгийн нэрд итгэдэг та нарт эдгээр зүйлийг бичсэн гэж бичигдсэн байдаг тул Бурханы Хүүг хүлээж авсан учраас надад Мөнхийн Амь бий. Бурхан минь, надад Мөнх Амийн баталгааг өгсөнд баярлалаа.**

5. Чиний амьдралд юу ч өөрчлөгдөөгүй, чи урьдын адил хэвээр байгаа тул ямар ч өөрчлөлт гараагүй, гарах ч үгүй.

**Тиймээс хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун, шинэ болсон байна гэж бичигдсэн байдаг бөгөөд би Есүс Христийн дотор байгаа тул шинэ бүтээл болсон. Миний хуучин бүхэн өнгөрч, шинэ болсонд баярлалаа. Тэгээд миний шинэ амьдрал Танаас ирсэн үнэгүй бэлэг тул талархаж байна.**

**Нэг л золиос гарган арун болсон тэднийг Тэр үүрд төгс болгосон** гэж бичигдсэн байдаг. Бурхан, Та намайг ариун болгоод төгс гэж хардагт тань баярлалаа.

**Шинэ хүнийг өмссөн. Энэ нь өөрийг нь бүтээсэн Түүний дүр төрхийн дагуу үнэн мэдлэгт шинэчлэгдсэн хүн юм** гэж бичигдсэн байдаг. Та намайг Өөрийн төрхөөр шинэчилж байдагт талархая.

Дээрх Бурханы Үгс нь Бурхантай тогтоосон таны шинэхэн харилцаанд эргэлзээ суулгах гэсэн хэн нэгэний эсвэл таны оюун санааны дайсны оролдлогыг эсэргүүцэн, дийлэхэд тус болно гэдэгт бид итгэж байна. Эргэлзээ төрсөн даруйд Бурханы Үгийг чангаар итгэлтэйгээр хэлбэл диавол болон түүний тавьсан бүхий л эргэлзээнүүд арилах болно.

Та нэгэнт аврагдаад, Бурханы хүүхэд болсон учраас Түүний Үг таны амьдралын гол хөдөлгүүр хүч болох ёстой. Үүнээс хойш та өөрийн бодол санаа, мэдрэмж, эсвэл сонсож байгаа болон харж байгаа зүйлсээрээ амьдралаа удирдуулах учиргүй. Бурханы Үг бол Үнэн бөгөөд тэрхүү Үнэн одоо таны амьдралын хэмжүүр мөн.

Бурханы Үг таныг аврагдсан гэж хэлсэн учраас та аврагдсан, Бурханы Үг таныг Түүний хүүхэд болсон гэж хэлсэн тул та Бурханы Хүүхэд мөн. Бурханы Үг танд Мөнх Амь бий гэж хэлсэн тул та мөнх амьтай. Бурханы Үг таны бүх нүгэл уучлагдсан гэсэн учраас таны бүх нүгэл уучлагдсан юм.

Хоёрдугаар бүлгээс сурсан Үнэнийг Бурханд элбирлаар өргөхөд доорх үгс танд тусална.

*Тэнгэрлиг Аав минь,*

*Та Өөрийгөө надад илчлэн, Өөрийн Хүү Есүс Христээр дамжуулан намайг Өөртэйгөө холбоотой болгосонд баярлалаа. Би одоо Таны Үгэн дээр үндсэлэн бүрэн итгэлтэйгээр Таны Хүүхэд, бас цоо шинэ амьдралтай шинэ хүн болсон ба гэм нүглийн хүч чадал, шийтгэлээс бүрэн чөлөөлөгдсөн бөгөөд миний нүглүүд дахин дурсагдахгүй болсонд баярлалаа.*

*Аав аа, би энэ дэлхийд бялхам, хангалуун амьдрал хийгээд ирээдүйд Мөнх Амьтай болсондоо талархая. Та энэ бүхнийг миний өмнөөс хийсэн, би ямар ч сайн үйлс хийх шаардлагагүй харин Таны Үг болох Библид буй Таны амлалтууд болон Танд итгэх итгэлээр авсандаа баярлаж байна. Энэ бүхнийг Та надад хайртай бөгөөд надтай харилцаатай байхын тулд үнэгүй өгсөн билээ.*

*Есүс ээ, миний төлөө хийсэн бүхэнд тань баярлалаа. Намайг гэсэн Таны хайрын илэрхийлэл миний оюун ухаан ба ойлголтоос давсан хэдий ч би итгэлээрээ хүлээн авч байна. Та намайг үнэхээр хайрласан тул миний өмнөөс загалмай дээр үхсэнд би талархаж байна.*

*Та загалмай дээр урсгасан цусаараа болон дөчин хоног цөлд соригдохдоо сорилтыг давсан Үгээрээ Сатаныг ялсанд би итгэж байна.*

*Есүс ээ, миний өмнөөс Сатаныг ялж, түүний заль мэх, уруу татлагыг Таны адил Бурханы Үгээр ялах боломжтой гэдгийг надад харуулсанд баярлалаа.*

*Би юу ч бодсон, сонссон болон мэдэрсэн ч Таны Үгэнд итгэх итгэлээр амьдрахад минь туслаач. Адам, Ева хоёрыг биш, харин Есүс Христ Таны дууриал болсны адил Эзэн таныг хаана ч дагаж явахад минь хөтлөөрэй. Миний шинэ амьдралын төлөвлөгөө болон Өөрийгөө өдөр ирэх тусам улам илүү илчлээрэй. Би Танд хайртай.*

*Есүсийн Нэрээр залбирч байна. Амен.*

## *Жинхэнэ аз жаргал бол танд зориулсан Бурханы хүсэл*

### **Гуравдугаар бүлэг**

*Жинхэнэ аз жаргал бол танд зориулсан Бурханы хүсэл! Бурхан бол сайн бөгөөд хайрын Бурхан тул танд зөвхөн сайныг хүсдэг юм. Бурханд итгэх итгэлийнхээ үндэс ба Бурханы Хүүхэд байхын эрхээ ойлгосон бол та одоо Бурхантай тогтоосон дотны харилцаагаа хөгжүүлэхийн тулд Бурхан хэн болохыг мэдэх хэрэгтэй.*

*Бурхан хэн болохыг мэдснээр та Түүнтэй дотны харилцаагаа хөгжүүлэх юм. Христитгэл бол ямар нэгэн шашин биш харин өөрийн Бүтээгчтэйгээ Түүний Хүү Есүс Христээр нь дамжуулан харилцах харилцаа мөн.*

*Энэ бүлэгт Бурханы хэн болохыг дэлхий, диавол болон шашны зүгээс бус жинхэнэ Бурхан хэн болохыг өгүүлнэ. Бурханы Сүнс танд Түүнийг илчлэх тусам Түүнийг гэсэн таны хайр, итгэл нь улам хүчтэй болж, та өдөр бүр Түүний ивээл, оршихуйг мэдрэх болно.*

*Бурханыг хувьчлан таних явдал нь Таны амьдралд зориулсан Түүний төгс төлөвлөгөө, зорилгыг мэдэхэд хөтлөнө.*

***Жинхэнэ аз жаргал бол  
танд зориулсан Бурханы хүсэл .....***

Үнэнээр амьдрах нь баяр хөөр болон Бурханы ивээлүүдийг Жинхэнэ Аз Жаргалын хамт өдөр бүр авчирдаг. Та хэдий нь хамгийн гайхамшигтай ивээл болох өөрийн Бүтээгч Эзэнтэйгээ Түүний Хүү Есүс Христээр нь дамжуулан амьд харилцаатай болсон явдал юм. Та хэзээ ч нүглийнхээ шийтгэлийг хүлээхгүй болсон бөгөөд харин ч Есүстэй хамт Тэнгэрийн улсад мөнхөд хамт байх болно.

Та одоо Эзэн Есүс Христтэй харилцаатай болсон тул цоо шинэ бүтээл болжээ. Энэ нь ямар утга учиртай болохыг та үлдсэн амьдралынхаа туршид болон мөнхийн мөнхөд суралцах болно. Бурхан таныг аврахдаа ямар нэгэн зүйл хийсэн бөгөөд үүнийг жирийн үгээр илэрхийлэх аргагүй ба хүний оюун ухаан шууд ойлгох боломжгүй юм.

Та дөнгөж сая Дахин Төрсөн тул Христийн дотор шинэхэн төрсөн хүүхэд адил ба Бурханы Үгээр хоолохын хирээр өсөж торних болно. Одоо таны дотор амьдарч буй Ариун Сүнс танд Бурханы Үгийг илчилж өгнө. Тэр таныг бүх Үнэнд хөтлөн дагуулах бөгөөд Бурханы таны төлөө хийсэн зүйлийг аажим аажмаар ойлгох болно.

Жишээ нь, Библид таныг Бурханы Хүүхэд болсноор Түүний өвийг Христтэй хамт залгамжлагч болсон гэдэг. Энэ нь тэнгэр газрыг Бүтээгч таны Тэнгэрлиг Аав бөгөөд Түүнд байгаа бүхэн мөн л таных гэсэн үг юм.

Та урьдын хүн байхаа больсон. Хуучин хүн нь өнгөрч, шинэ хүн болсон нь цөм Бурханаас ирсэн юм. Та магадгүй энэ бүхнийг авах зохисгүй гэж бодож байж болох ч, та өөрийнхөө тухай хуучнаар бодож болохгүй. Та бол Бурханы хувьд маш үнэ цэнэтэй гэдгийг ойлгох хэрэгтэй. Үнэ цэнэ нь гэвэл Тэр таныг Сатаны гэм нүглийн хүлээснээс чөлөөлөхийн тулд өндөр үнэ өртөг төлсөн явдал юм.

Та бол Бурханы хувьд маш их үнэ цэнэтэй. Тэр таныг бүтээсэн бөгөөд хүн төрлөхтнийг гэсэн Түүний Агуу Хайрын Төлөвлөгөөн дотор таны амьдралд зориулсан төлөвлөгөө Түүнд бий. Таны төлөө их өндөр үнэ өртөг төлсөн нь та Түүний хувьд их үнэ цэнэтэй болохыг харуулж байгаа юм. Тэр таны төлөө Өөрийн цорын ганц хайртай Хүүгийн цусыг урсгасан билээ. Тэр таны өмнөөс нүгэл, өвчин, зовлонг Есүст үүрүүлж, таныг Өөртөө авсан юм.

Энэ хайрыг бидний оюун ухаан ойлгохгүй. Диавол болон өөр хэнийг ч болов таныг үнэ цэнэгүй, хэрэггүй хүн гэж хандахыг бүү зөвшөөр. Таны Бүтээгч таны үнэ цэнийг хэдий нь тогтоосон аж. Та үнэ цэнэгүй мэт санагдах бүрдээ Есүсийг таны оронд загалмай дээр зовон тарчлан, Өөрийн ариун цусаа таны эдгэрлийн тулд



урсган байгааг харатгун. Бурхан таныг мөнхийн хувиршгүй хайраар хайрладаг бөгөөд та Түүний хувьд маш үнэ цэнэтэй билээ. Та одоо мөнхөд Түүний хүүхэд хэвээр. Энэ бол Үнэн.

Бурханы Үг болох Библид: **Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч болох Есүс уруу хараагаа чиглүүлье. Тэр Өөрийнх нь өмнө тавигдсан баяр баясгалангийн төлөө гутамшгийг эс тоомсорлон, загалмайг тэвчсэн бөгөөд Бурханы сэнтийн баруун гарт заларсан юм гэж бичигсэн байдаг. Есүс танд шинэ амьдрал өгсөн юм. Тэр хэлэхдээ,**

**-Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй гэжээ. Зөвхөн Есүс цорын ганц зам мөн.**

Та одоо Есүсийн дагалдагч боллоо. Таны бүхий л амьдрал бол Есүсийнх, та зөвхөн Есүст итгэх хэрэгтэй. Есүс Христ бол Бурханы төгс дүр мөн. Библид, **Үг нь махан бие болж бидний дунд оршин, бид Түүний алдрыг харцгаасан. Энэ нь Эцэгийн цорын ганц Хүүгийн алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн байсан юм гэжээ.** Есүс Христ Бурханы Амьд Үг мөн. Та Түүнтэй адил болох ёстой.

**Хүний Хүү алдагдсаныг хайж, аврахаар ирсэн** гэдэг нь бүх хүн төрлөхтөн бөгөөд та бид хоёр ч гэсэн үүнд хамаатай юм. Есүс ямар ч гэм нүгэлгүй байсан нь бид бүхний төлөө байсан юм. Тэр бидний төлөө зовлон, зүдгүүрийг үүрсэн билээ. Тэр бидний төлөө загалмай дээр цусаа урсгасан бөгөөд Түүний үхэл, оршуулга, там уруу буусан нь, дахин амилалт, алдар хийгээд Тэнгэр өөд гарсан нь бидний төлөө байсан юм.

Есүс Христэд бид нараас өөр энэ дэлхийд ирэх шалтгаан байхгүй. Түүнд хэнд ч гайхуулж, батлах зүйл байгаагүй. Түүнд үхэлд хүргэх ямар ч гэм нүгэл байгаагүй, Тэр загалмай дээр нас барахдаа Өөрийн амиа өгсөн, амь нь Түүнээс авагдаагүй, харин Тэнгэрлиг Хайрыг илэрхийлсэн сайн дурын үйлдэл болсон юм.

Есүс хэн болох бидний төлөө юу хийснийг ойлгохын тулд бид өөрсдийгөө Түүнтэй адилтгах ёстой. Тэр биднийг орлосон явдал нь бидний үргэлж тунгааж байх үнэний нэг мөн.

Өөрөө хэлбэл, Есүс Христ загалмай дээр нас барахад та тэр загалмай дээр шийтгэл авч, үхсэнтэй адил юм. Есүс оршуулагдахад та ч мөн оршуулагдсан хэрэг. Есүс Христ там уруу буухад та ч гэсэн тамд унаж, Тэр үхэгсдээс амилагдахад та ч гэсэн дахин амилж, Түүнийг Тэнгэр өөд гарахад та Түүнтэй хамт гарсан гэсэн утгатай.

Есүсийн хийсэн бүхэн та бидний төлөө байсан юм. **Үүнчлэн Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд ирсэн бөгөөд амиа олны төлөө золиос болгон өгөхөөр ирсэн билээ гэв.** Есүс Христ бидний төлөө загалмай дээр үхсэн явдал нь Аав ба Хүүгийн хайрын үйлдэл байсан юм.

Есүс Христ энэ дэлхийд бидний Тэнгэрлиг Аав болох энэ Ертөнцийн Бүтээгч Бурханыг харуулахаар ирсэн юм. Сатан Бурханы хэн болохыг энэ дэлхийд хууран мэхлэн харуулсан байлаа. Түүний худал хуурмаг нь Бурханыг Өөрийн хүүхдүүдийн төлөө зөвхөн сайн сайхныг хүсч байдаг Тэнгэрлиг Аав болох үнэнийг гуйвуулсан байв.

Энэхүү хууран мэхлэлтээс болон Бурханы биднийг гэсэн Агуу Хайрыг үл тоомсорлсноос болж хүн төрлөхтөн Бурханаас зуун зууны туршид дайжиж ирсэн юм. Бурхан Өөрийгөө хэн болохыг Хүү Есүс Христээрээ тодорхой харуулсан юм. Хүү нь Бурханд хүрэх цорын ганц зам бөгөөд бидэнд Бурхан Аавтайгаа өдөр тутмынхаа амьдралд эрхэн харилцаж байхыг заажээ.

Бид Бурханы хүүхдүүдийн хувьд хэзээ ч Түүнээс айх шаардлагагүй. Тэр бидний өмнөөс Есүсийг шийтгэсэн тул хэзээ ч биднийг шийтгэхгүй. **Бид Бурханы уур хилэнг амсахгүй, харин авралыг хүртэх хувьтай байжээ.** Бурханы хүүхдүүд хэзээ ч Түүнээс айж, зугатааж, нуугдах хэрэггүй. Харин ч Түүн рүү тэмүүлж, ойртох ёстой.

Бидний Тэнгэрлиг Аав, Бурханы дүр төрх хэзээ ч бидний хүмүүн аавын бидэнд хандаж байснаар тодорхойлогдож болохгүй. Бид Түүний дүрийг Бурханы бичигдсэн Үг, Библи болон Бурханы Амьд Үг, Есүсээс олж харах хэрэгтэй. Чингэвэл бид Түүнтэй зүй ёсоор харилцаж, Хүүхдийнх нь эдлэх ёстой бүхий л эрх ямбыг эдлэх учиртай.

Библиэс хэд хэдэн иш татвал:

**Сэтгэл минь ээ, ЭЗЭНийг магтагтун.**

**Дотор минь байгаа бүхэн ч Түүний ариун нэрийг магтагтун.**

**Сэтгэл минь ээ, ЭЗЭНийг магтаж,**

**Түүний ач тусын алийг нь ч бүү март.**

**Тэр чиний бүх гэм бурууг уучилж,**

**Чиний бүх өвчнийг илааршуулдаг.**

**Тэр чиний амийг мөхлөөс аварч,**

**Чамд хайр энэрэл болон өршөөлийн титмийг өмсгөдөг.**

Залуу нас чинь бүргэд мэт шинэчлэгдэхийн тулд  
Тэр чиний хүслийг сайн зүйлсээр хангадаг.  
ЭЗЭН дарлагдсан бүхний төлөө  
Зөв шударга үйлсийг болон шүүлтүүдийг үйлддэг.  
Тэр Өөрийн замыг Мосед,  
Өөрийн үйлсийг Израилийн хөвгүүдэд мэдүүлсэн.  
ЭЗЭН бол өрөвч, нигүүлсэнгүй,  
Уурлахдаа удаан болоод хайр энэрлээр элбэг баян.  
Тэр үргэлж тэмцэлдэхгүй,  
Уураа ч мөнхөд хадгалахгүй.  
Тэр бидний үйлдсэн нүглийн дагуу бидэнд хандаагүй,  
Бидний гэм буруугийн дагуу бидэнд хариу өгөөгүй.  
Учир нь тэнгэр газрын дээгүүр өндөрт байдаг шиг  
Түүнээс эмээгчдэд Түүний хайр энэрэл агуу их юм.  
Өрнө дорноос хол байдаг шиг  
Тэр бидний алдаа зөрчлийг биднээс тийн холдуулсан.  
Эцэг хүн үр хүүхдээ өрөвддөгийн адил  
ЭЗЭН Өөрөөс нь эмээгчдийг өрөвддөг.

Энд бидний Тэнгэрлиг Аавын сайхан дүр харагдаж байгаа биз дээ? Энэ бол Бурханы нигүүлсэл, өршөөл, хайр болон сайн сайхан чанарын өчүүхэн хэсэг шүү дээ. Дээрх нь Есүсийг төрөхөөс олон зуун жилийн өмнө бичигдсэн, харин одоо Тэр Өөрөө Бурханыг хамгийн сайнаар харуулна.

Библид ийнхүү бичигдсэн юм. Хүү нь Түүний алдрын туяа, Түүний мөн чанарын бодит илэрхийлэл бөгөөд Өөрийн хүчит үгээр бүхнийг барьдаг болой. Тэр нүглүүдийн ариусгалыг гүйцээгээд, дээр байгч Сүр жавхлантай Нэгэний баруун гарт залрав.

Мөн, Учир нь бидний төлөө хүүхэд төрж, бидэнд хүү өгөгдөнө.  
Засаглал Түүний мөрөн дээр байх болно.  
Түүний нэрийг Гайхамшигт Зөвлөгч, Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг,  
Энхийн Жонон гэж дуудна.

Есүс Өөрөө: “Намайг харсан хүн Эцэгийг харсан”. Бурхан бидэнд Өөрийгөө жинхэнэ дүрээрээ таниулахыг хүсдэг нь та бид Түүнтэй дотны хайрын харилцаатай байгаасай гэсэндээ билээ. Тэгвэл бид

Түүний бидэнд анхнаасаа төлөвлөсөн амьдралыг энэ яваа насандаа болон мөнхөд эдлэх болно.

Есүс мөн, **Харин Би та нарыг анд нөхөд хэмээн дуудав. Учир нь Би Эцэгээсээ сонссон бүхнээ та нарт мэдүүлсэн билээ.** Та одоо Есүсийн анд нөхөр болсон тул Түүний Тэнгэрлиг Ааваасаа суралцсан бүхнийг та ч сурах боломжтой боллоо.

Одоо та нарын дотор амьд оршигч Бурханы Сүнс танд Бурхан Аав, Хүү хоёртой дотны харилцаа үүсгэхэд хэрэгтэй бүхнийг илчилж өгөх болно. **Бурханыг хайрлагсад Бурхан ямар ч ухаанд төрөөгүй, ямар ч чих сонсоогүй, ямар ч нүд хараагүй зүйлсийг Өөрийн Сүнсээр харуулсан юм. Сүнс нь бүх зүйлсийг, Бурханы гүн гүнзгий зүйлсийг хайдаг. Бурханы бидэнд үнэгүй өгсөн зүйлийг ойлгохын тулд бид энэ дэлхийн сүнсийг бус харин Бурханы Сүнсийг хүлээн авсан билээ.**

Эндээс харахад бид Бурханы тухай мэдлэгийг өөрсдийн мэдлэг, боловсрол, ухаанаар олдоггүй, харин Бурханы Сүнсний илчлэлтээр авдаг байна. Бурхан биднийг Түүний үнэгүй өгсөн бүхий л сайн сайхан зүйлсийг аваасай гэж хүсч байдаг юм. Бурхан биднийг Өөрийг нь болоод Түүний бүхий л Ивээлүүдийг хүртээсэй гэж хүсдэг.

**Тэр Өөрийн Хүүгээ үл өршөөж, харин Түүнийг бид бүхний төлөө тушаасан юм. Тэгвэл Тэр яаж бүх юмыг Түүний хамт бидэнд сул өгөхгүй байх билээ? ЭЗЭН нигүүлсэл болон алдрыг өгдөг. Тэрээр шулуун шударгаар явагчдаас ямар ч сайн юмыг нуун дарагдуулдаггүй. Аливаа сайн соёрхол ба аливаа төгс бэлэг нь дээрээс, гэрлүүдийн Эцэгээс бууж ирдэг. Түүнд өөрчлөлт ч байхгүй, өөрчлөгдөх сүүдэр ч байхгүй гэжээ.**

Тэгэхээр Бурхан бидэнд зөвхөн сайн сайхныг хүсдэг болохыг харлаа. Есүс Христ биднийг бугийн дарангуйлал болон өвчин зовлон, эмгэг, гэм нүглээс чөлөөлөхийн тулд бидний оронд зовлон эдэлж, зодуулан үхсэн билээ. Бурхан Есүс Христийн ариун үнэт цусаар биднийг нүгэл болон нүглийн хараалаас зольж авсан тул бид Түүний бүхий л ивээл, сайн сайхан зүйлсийг амьдралдаа эдлээсэй гэж хүсдэг.

Бурханы хүсэл бол **таны сүнс хөгжихийн хирээр бие махбод тань эрүүл байж, амьдрал чинь өөдлөн дэвжих** гэдэгт та баттай итгэх хэрэгтэй. Үүнийг Библи тодорхой заадаг бөгөөд Есүс ч Өөрөө энэ дэлхийд байхдаа харуулсан юм. Энэ нь **Назарын Есүсийн тухай бөгөөд Бурхан хэрхэн Түүнийг Ариун Сүнс ба хүч чадлаар тосолсон хийгээд Тэрээр диаволд дарлагдсан бүгдийг эдгээн, сайныг үйлдэж явсан тухай юм. Учир нь Бурхан Түүнтэй хамт байсан.**

Есүс өвчтэй хүмүүсийг эдгээж, сохорыг хараатай, дүлийг сонсголттой, хэлгүйг нь хэлтэй болгож байжээ. Тэр бузар сүнснүүдийг хөөж, үхэгсдийг амилуулж, уяман өвчтэй хүмүүсийг эдгээн, доголонт хөлтэй болгож байсан. Ямар ч хүнд өвчтэй байсан Өөр дээр нь итгэл өвөрлөн ирсэн хүн бүрийг эдгээж байлаа. Өөрт нь итгэсэн бүхний нүглийг Тэр цагаатгаж байсан юм. **Есүс Христ энэ дэлхийд гэмтнүүдийг аварч, диаволын үйлсийг устгахын тулд иржээ.**

**Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ байна.** 2000 гаруй жилийн тэртээ үйлдэж байсан гайхамшгуудаа Тэр өнөөдөр ч үйлдсээр байна. Есүс Өөртэй нь уулзаж байсан бүх хүмүүсийн хэрэгцээг мэдэрч, уян зөөлөн сэтгэлээр хандаж байжээ. Хэрэгцээтэй үед нь мянга мянган хүмүүсийг хооллож байсан юм. Есүс шиг хүмүүсийн төлөө санаа тавигч хэзээ ч гарч ирэхгүй. Энэ бол Түүний бодит байдал мөн.

Бурханы хүүхдүүд Тэнгэрлиг Аавыгаа сайн мэдэж байх нь маш чухал. Тэр бидэнд үргэлж сайныг хүсч байдаг тухай **Энэ үеийн явдалд бүү нийцэгтүн. Харин зүрх сэтгэлээ шинэчилснээр өөрчлөгдөж Бурханы хүсэл юу болохыг, тухайлбал сайн, тааламжит, төгс төгөлдөр хүслийг батлагтун.** Бурханы хүсэл бол сайн, тааламжит, төгс төгөлдөр гэжээ.

Диавол болон өөр хэнд ч бай Бурханы тухай Түүний Үгээс өөр үг хэлэхийг танд бүү зөвшөөр. **Та өөрийн харааг** Өөрт нь итгэдэг хүн болгонд зөвхөн сайн сайхныг хүсдэг **Есүс дээр тогтоовол** шинэчлэгдэх болно. Есүс үргэлж Тэнгэр дахь Эцэгийнхээ хүслийг биелүүлдэг байв.

Тэгэхээр Бурхан таныг бугийн бүхий л муу ажлуудаас ангид, өршөөгдсөн, бүх талаараа хөгжин дэвшсэн, эрүүл энх, аз жаргалтай, ерөөгдсөн байхыг хүсдэг гэдгийг мэдэж авлаа. Яагаад гэвэл Бурханы Үг хэлж байгаа бөгөөд Есүс хүслийг нь энэ дэлхийд харуулсан юм.

Одоо гуравдугаарт бүлэгт суралцсан зүйлсээ дараах талархлын залбирлаар илэрхийлье.

*Тэнгэрлиг Бурхан Аав минь ээ,*

*Та миний амьдралд Жинхэнэ Аз жаргал хүсдэг, мөн хэзээ ч өөрчлөгдөхгүй хэвээр байдагт би итгэж найдаж болох бөгөөд миний амьдралд зөвхөн сайн сайхныг хүсдэг гайхамшигтай Бурхан танд баярлалаа.*

*Таны надад бэлдсэн бүхнийг, Есүсийн хамт илчлэн, бүхий л Үнэн үрүү хөтлөн дагуулж байдаг Арцун Сүнсний төлөө талархая.*

*Бурхан минь, Та надаас ямар ч зүйл нуудаггүй бөгөөд Та намайг Таны тухай бүхнийг мэдээсэй гэж хүсдэг тань баярлалаа.*

*Есүс ээ, Та намайг дотны анд найзаа гэж үздэг бөгөөд надтай хувьчлан, дотны хайрын харилцаатай байхын тулд бүхнийг надтай хуваалцаагт талархая.*

*Би одоо Христийн дотор балчир хэдий ч Есүсээс хараагаа үл салгавал Эзэний дотор хүчтэй болно гэж итгэж байгаа бөгөөд миний Христитгэлт амьдралд Таны бэлдсэн гайхамшигт зүйлсийг нээж илрүүлэх гэж байгаадаа баяртай байна.*

*Таны хувьд би ямар их үнэ цэнэтэй болохыг надад илчилж өгсөнд баярлалаа. Би хэнд ч Таны хүүхэд болсныхоо хувьд өв залгамжлагч гэдэгт минь эргэлзээ төрүүлэхийг зөвшөөрөхгүй. Миний бүхий л хэрэгцээ зөвхөн Танаас ирдэг билээ. Надад бүх зүйл өгөгдөх бөгөөд би оюун санаа болон эрүүл мэнд, ахуй амьдралдаа хөгжин дэвших болно. Таны хайрыг миний оюун ухаан ойлгож хүрэхгүй.*

*Эзэн Есүс минь, та миний төлөө болон над шиг гэмт хүмүүсийн төлөө энэ дэлхийд ирсэнд тань баярлалаа. Та үйлчлүүлэхийн тулд бус бидэнд үйлчлэхийн тулд ирсэн бөгөөд Бурхан Аавын зүрх хүнийг эдгээж, чөлөөлж, аврах хүсэлтэй байдгийг харуулсанд талархая. Энэ бүхнийг миний төлөө хийхэд бэлэн байгаад тань талархаж байна. Би Танд хайртай.*

*Есүсийн Нэрээр залбирч байна. Амен.*

## *Жинхэнэ аз жаргал бол Есүс таны дотор*

### **Дөрөвдүгээр бүлэг**

*Жинхэнэ аз жаргал бол Есүс таны дотор. Танд жинхэнэ аз жаргал авчрах Бүхэн одоо таны дотор амьдарч буй Эзэн Есүс Христ мөн.*

*Та Есүст өөрийн Аврагч ба Эзэн гэж итгэж найдсан бол одоо та амьдралынхаа бүхий л талбарт Түүнд хэрхэн найдахад суралцана.*

*Есүсийг бүрэн дүүрнээр нь таньж мэдэхэд хүний амьдрал хүрэлцэхгүй ч, энэ бүлэгт та Есүс Христийн үндсэн чанарууд болон өөрийнхөө Христ дотор бүтэн болсноо олж харах болно.*

*Бурханы дүүрэн байдал Есүсийн дотор илчлэгдсэн бөгөөд та Түүний дотор л бүтэн болсноо ойлгоно. Өөрөөр хэлбэл, та хэзээ ч гачигдахгүй ба танд хэрэгтэй болгоныг таны дотор буй Есүсээс олж чадна.*

*Энэ бол Бурханы Үгэнд буй хөдлөшгүй Үнэн мөн. Танд хэрэгтэй Бүхэн өдөр болгон таны дотор амьд байна гээд төсөөл дөө.*

***Жинхэнэ аз жаргал бол Есүс таны дотор ...***

Одоо Есүс Христ таны дотор, та Түүний дотор амьдарч байгаа билээ. Библид, Түүний дотор Бурханы дүр биеэр оршиж, та **Түүний дотор бүрэн болсон** гэжээ. Өөрөөр хэлбэл, танд дутуу зүйл гэж үгүй, та Бурханы бүтээсэн, бүрэн бүтэн болсон гэсэн утгатай.

Бүрэн бүтэн байдал нь Есүс дотор байдаг ба Тэр таны дотор, та Түүний дотор байгаа тул та юугаар ч дутахгүй. Таны хэрэгцээ болгон Христээр хангагдах болно. Таны доторх Христ алдрын найдвар мөн.

Та Библийн дараах ишлэлүүдийг уншаад тунгаан бодвол ямар их ивээгдсэн юм бэ гэдгийг олж харна.

**ЭЗЭН бол миний хоньчин,**

**Надад дутах зүйл нэг ч үгүй.**

**Тэр намайг ногоон бэлчээрт хэвтүүлж,**

**Дөлгөөн усны дэргэдүүр хөтөлдөг.**

**Тэр миний сэтгэлийг сэргээдэг.**

**Тэр Өөрийнхөө нэрийн төлөө**

**Зөвийн замаар намайг хөтөлдөг.**

**Үхлийн харанхуйн хөндийгөөр туулавч**

**Би хор хөнөөлөөс айхгүй,**

**Учир нь Та надтай хамт байна.**

**Таны саваа, Таны таяг намайг тайвшруулдаг.**

**Та миний дайснуудын өмнө надад ширээ засдаг.**

**Та миний толгойг тосоор тосолсон.**

**Аяга минь дүүрч бялхдаг.**

**Сайн сайхан хийгээд хайр энэрэл**

**Насан туршид минь намайг лавтай яа дагана.**

**Би ЭЗЭНий өргөөнд мөнхөд оршин суух болно.**

Энэ хэсэгт Есүс бол Хоньчин, та бол Түүний хоньдын нэг гэжээ. Өмнөх бүлэгт таныг Бурханы Хүүхэд болох талаар гарсан бол одоо таны Есүс Христтэй харилцах бусад талбаруудыг авч үзнэ.

Дээрх хэсгийг дахин дахин уншаад, танд жинхэнэ утгыг нь илчлэхийг Ариун Сүнсэнд даатгаарай. Бурхан Өөрийн Үгээр таны дотоод гүн рүү нэвтрэхийг хүсч байна. Тэр таныг бодож санаснаас тань илүү



ивээж, хайрлахыг хүсч байдаг тул Өөрийгөө таньд бодит болгохыг хүсч байдаг юм.

**Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог бөгөөд зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм.**

Таныг Бурханы Үг болон Хайр, Энэрлийг тунгаан бодох үед Бурханы Сүнс таныг гүнзгий хөндөж, өөрчлөн, таны зүрх ба сэтгэлийг томсгож, Христийн Хайрыг улам гүнзгий мэдрүүлэх болно.

Есүс бол таны Хоньчин. Тэр таныг хангаж, удирдан тайвшруулж, ивээх болно. Танд юу ч дутахгүй. Тэр бол таныг муу бүхнээс хамгаалж, амийн замаар хөтөлдөг Сайн Хоньчин мөн. Танд айх, санаа зовох шалтаг үгүй. Таны Хоньчин таны бүх хэрэгцээг хангаж, таныг хамгаалж, таныг амар тайван, баяр хөөрөөр ивээх болно.

**Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ. Өөрийн бүх замаараа Түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно. Өөртөө бүү итгэ. Хүний нүдэнд зөв мэт санагдавч эцэстээ үхэлд хүргэдэг зам бий. Есүсийг дага. Есүс, -Би бол зам, үнэн, амь мөн гэсэн. Тэр таныг буруу замаар дагуулахгүй.**

**Харин бид энэ бүхний дотор биднийг хайрладаг Түүгээр дамжуулан давуулан дийлдэг. Учир нь үхэл ч, амь ч, тэнгэр элч нар ч, эрх баригчид ч, өнөөгийн юмс ч, ирэх юмс ч, хүч ч, өндөр ч, гүн ч, өөр ямар ч бүтээл бидний Эзэн Христ Есүсийн доторх Бурханы хайраас биднийг салгаж чадахгүй гэж би бат итгэлтэй байна.**

Та Есүс дотор аюулгүй. Та дараах ишлэлүүдийг уншаад, тунгаан бодоорой.

**Хамгийн Дээд Нэгэний халхавчинд оршигч нэгэн**

**Төгс Хүчит Нэгэний сүүдэр дор амьдарна.**

**Би ЭЗЭНд хандан “Миний хоргодох газар, миний бат цайз,**

**Миний итгэдэг Бурхан минь” гэнэ.**

**Учир нь чамайг анчны урхинаас,**

**Бас үхлийн тахлаас авардаг нэгэн бол Тэр юм.**

**Тэр чамайг өдөөрөө хучих бөгөөд**

Түүний жигүүр дор чи хоргодох болно.

Түүний итгэлтэй байдал бол бамбай болон бэхлэлт юм.

Чи шөнийн аймшгаас ч,

Өдөр исгэрэх сумнаас ч айхгүй.

Мөн харанхуйд явагч тахлаас ч,

Уд дунд цөлжүүлэх мөхлөөс ч айхгүй.

Мянган хүн чиний дэргэд,

Түмэн хүн чиний баруун гар талд унавч,

Энэ нь чамд халдахгүй.

Чи зөвхөн нүдээрээ хараад л

Хорон муу хүнд өгөх хариуг үзэх болно.

Учир нь чи миний хоргодох газар болох ЭЗЭНийг буюу

Хамгийн Дээд Нэгэнийг орших газраа болгосон юм.

Ямар ч хор хөнөөл чамд учрахгүй,

Ямар ч гамшиг чиний майханд ойртохгүй.

Учир нь бүх замд чамайг хамгаалахын тулд

Тэр Өөрийн тэнгэр элч нарт чиний талаар тушаал өгнө.

Чамайг хөлөө чулуунд цохичих вий гэсэндээ

Тэд чамайг гар дээрээ өргөн явна.

Чи арслан, наж могойг гишгэж,

Залуу арслан, могойг хөлөөрөө дэвсэлнэ.

Тэр Намайг хайрласан учраас Би түүнийг аварна.

Тэр Миний нэрийг мэдсэн учраас Би түүнийг өргөмжилнө.

Тэр Намайг дуудах бөгөөд Би түүнд хариулна.

Саад бэрхшээлтэй үед Би түүнтэй хамт байна.

Би түүнийг аварч, хүндлэх болно.

Би түүнийг урт амьдралаар хангаж,

Түүнд Өөрийн авралыг үзүүлнэ.

Энэ бол Хүү Есүс Христээр нь дамжуулан Бүтээгчтэйгээ тогтоосон таны харилцааны гайхамшигтай илчлэлт мөн. Бурхан үнэхээр таны төлөө санаа тавьдаг билээ. Дээрх үгсийг дахин дахин уншаад, Бурханаас зөвхөн танд хандаж бичсэн мэт тунгаан бодоорой. Библи бол Өөрт нь итгэдэг бүх хүмүүст зориулсан Бурханы Хайрын захидал мөн.

Хэн ч таныг Есүс шиг хэзээ ч хайрлаж байгаагүй юм шүү. **Иймд би Эцэгийн өмнө өвдөг сөгдөж, тэнгэр болон газар дахь бүхэл гэр бүлийг нэрлэдэг Түүнд залбирч байна. Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай. Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж сууриалаад, бүх ариун хүмүүсийн хамт тэр хайрын ямар өргөн, урт, өндөр хийгээд гүн болохыг ойлгох болтугай. Мэдлэгийг давдаг Христийн хайрыг мэдсэнээр та нар Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай.**

Эдүгээ, бидний дотор ажилладаг хүчний дагуу гуйж, бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд 21 алдар нь чуулган дотор, Христ Есүс дотор бүх үеийнхэнд үеийн үед байх болтугай. Амен.

Таны оюун ухаанаас хол давсан Бурханы Хайр болон Түүний баялаг, нигүүлсэл, уучлалт, хүч чадал, амар тайвныг та хэзээ ч эдэлж дуусахгүй. Бурханд буй хязгааргүй, шавхагдашгүй нөөц баялаг нь одоо таных болсон.

Таны дотор буй Есүст Бурханд байгаа Бүх юмс болон Бурхан Өөрөө Бүхлээрээ оршидог. **Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ байна.** Хоёр мянгаад жилийн тэртээ Өөрт нь итгэж байсан хүмүүст хийсэн зүйлсээ Тэр өнөөдөр ч гэсэн таны төлөө хийж чадна.

Есүс энэ дэлхийд гэмтнүүдийг аврахаар ирсэн. **Тэрээр диаволд дарлагдсан бүгдийг эдгээн, сайныг үйлдэж явсан тухай юм. Учир нь Бурхан Түүнтэй хамт байсан.** Гэм нүглээс болж хүн төрлөхтний дээр буусан хараалыг тасалж, хүн ба Бурханы хооронд эвлэрэл, эдгэрлийг авчрахаар ирсэн юм. Тэр бидэнд Мөнхийн Амьдрал өгөхөөр ирсэн юм.

Мөнхийн Амьдрал нь зөвхөн мөнхөд амьдрах амьдрал биш, харин энэ дэлхийд одоо сайн сайхан амьдрахыг хэлж байгаа юм. Бурхан

биднийг Сатан болон гэм нүглийн ямар ч хүлээсэнд байгаад байгаасай гэж хүсээгүй. Өөрт нь итгэсэн хүмүүст хэрхэн хандаж байснаараа Есүс үүнийг тодорхой харуулсан. Тэр үүнийгээ өнөөдөр ч гэсэн таны төлөө хийхэд бэлэн байна.

Нэгэн удаа, Есүс Петрийн гэрт очиж, хадам эхийг нь халуунтай өвдөн хэвтэж байхыг харав. Есүс түүний гарт хүрэхэд халуун нь арилан, тэр босоод Түүнд үйлчлэв. Орой болоход тэд чөтгөр шүглэсэн олон хүнийг Түүн уруу авчрахад, Есүс сүнснүүдийг үгээр хөөн зайлуулж, өвдсөн бүгдийг эдгээжээ. Энэ нь эш үзүүлэгч Исаиагаар “Бидний сул дорой байдлыг Тэр Өөртөө авч, бидний өвчнийг үүрсэн” гэж хэлүүлсэн нь биелэхийн тулд байлаа.

Есүсийг төрөхөөс хэдэн зууны Түүний тухай ийнхүү бичигдсэн юм. Үнэхээр Тэр бидний өвчнийг Өөртөө тээж, бидний уй гашууг даав. Харин бид Түүнийг Бурханд яллагдаж, цохигдож, зовсон гэж бодов. Гэвч Тэр бидний нүглийн төлөө хатгагдан, бидний гэмийн төлөө бяцарчээ.

Бидний амар амгалангийн төлөө Түүн дээр гэсгээлт бууж, Түүний шархаар бид эдгэрсэн. Бид бүгдээрээ хонь мэт төөрч, хүн бүр өөрийн замаар явав. Харин ЭЗЭН бидний гэмийг бүгдийг нь Түүнд тохов.

Есүсийг загалмай дээр нас барсны дараа олон жилийн хойно мөн ийнхүү бичигджээ. Бид зөвт шударгын төлөө амьдарч, нүгэл үхсэн байхын тулд Тэр Өөрөө Өөрийн биеэр биднийг нүглийг загалмай дээр үүрсэн юм. Түүний шархаар та нар эдгэрсэн. Та нар төөрсөн хонь мэт байсан бөгөөд өөрсдийн сүнсний Хоньчин ба Харгалзагч уруу иржээ.

Есүс Христ таны өмнөөс загалмай дээр нас барахдаа таныг уучлагдан, эдгэрсэн байхын тулд бүхий л зовлон зүдгүүр, өвчин эмгэг болон гэм нүглийг тань авсан гэдгийг ойлгох нь маш чухал.

Мөн, Хайрт минь, сэтгэл тань амар тайван байгаагийн адил бүх зүйл тань сайн сайхан байж, эрүүл энх байгаасай хэмээн би залбирч байна.

Бурхан таны гэм нүглийг уучлаад, Есүс Христийн зовлон, үхэл ба дахин амилалтаар дамжуулан эдгэрлийг өгсөн юм. Есүсийн улмаас Таны бүх нүгэл уучлагдсны адил, та Сатан болон нүглийн дарангуйллаас ангид байх давуу эрхтэй.

Есүс танд бялхам амьдралыг өгөхөөр ирсэн юм. Таны Тэнгэрлиг Эцэг тань мөн танд сайн сайхан, бүрэн дүүрэн амьдралыг хүсдэг. Тэр

таныг хүний ухаанаас хол давсан Бурханы Хайр ба амар тайван дотор ялгуулсан, ариун, энх тунх, хөгжин дэвшсэн амьдралтай байгаасай гэж хүсдэг.

Сатан алж, хулгайлж, сүйтгэхээр ирсэн бөгөөд таны амьдралд зориулсан Бурханы Хүслээс хулгайлах бие болон сэгтгэл санааны тогтворгүй байдал, худал хуурмаг, шунал тачаал, үзэн ядалт, гачигдал, ядуурал, өвчин зовлон, үхэл хагацал, завхайрал, өвчин эмгэг, донтолт ба гэм нүглийн хүлээсэнд байлгахыг хүсдэг.

Бурханы Хүсэл бол танд зөвхөн сайн сайхныг хүсдэг тул та зөвхөн Түүний хүслийг амьдралдаа биелүүлнэ гэсэн хатуу шийдвэртэй байх ёстой. Бурханы таны амьдралд хүсч буй зүйлсийг та ч мөн амьдралдаа хүсэн тэмүүлж, Ариун Сүнсний оролцоотойгоор биелүүлэх хэрэгтэй.

Та мөн зүрх сэтгэлийнхээ гүнд Сатан болон түүний заль мэхийг Бурханы Үгээр ялан дийлж, түүний хүслийг Бурханы Хүслээс ялгах чадвартай болно гэсэн хүсэлтэй бай.

**Тиймээс Бурханд захирагдагтун. Диаволыг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна. Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно. Нүгэлт хүмүүс та нар гараа цэвэрлэ. Хоёр санаатай хүмүүс та нар зүрхээ ариусга гэж бичигдсэн байдаг юм.**

Бурхан таны амьдралын бүх талбарт юу хийх хүсэлтэй байгааг мэдээд, Тэр хийнэ гэсэн зүйлсээ Өөрийн хүүхдийн төлөө хийх болно гэдэгт итгэх хэрэгтэй. Таны бие ба сүнс их үнээр олдсон тул та Бурханы эрүүл байдлаас өөр зүйлийг бүү хар.

**Та нарын бие бол Бурханы та нарт өгсөн, та нарын дотор байдаг Ариун Сүнсний сүм мөн гэдгийг та нар мэддэггүй юм уу? Та нар өөрсдийнх биш гэдгээ мэддэггүй юм уу? Учир нь та нарыг үнээр худалдан авсан юм. Тиймээс биеэрээ Бурханыг алдаршуулагтун.**

Таны бие болон сүнсэнд Бурханы уучлал ба эдгээлт явагдахад Тэр алдаршдаг юм. Есүс гэмтнийг уучилж, өвчтэй хүнийг эдгээхэд Бурхан алдаршдаг. Сатан Бурханы Алдраас хулгайлж, хүмүүсийг гэм нүгэл, өвчин зовлон дотор хүлээтэй байлгахыг хүсдэг боловч тэр ялагдсан тул Бурханы уучлал ба агуу эдгээх хүч Түүний Үгэнд итгэдэг бүх хүнд бэлэн байдаг юм.

Эдгэрхийн тулд Бурхан таныг уучлагдаж, аврагдаасай гэж хүсдэгийн адил эдгэрээсэй гэж хүсч байгаад итгэх ёстой. Бурхан Өөрийн бүтээсэн хүнийг бүхэлд нь халамж тавьдаг. Өөрт нь итгэж, эдгэрхийг хүссэн хэнийг ч Есүс түлхээгүй билээ. Тэр хэзээ ч түлхэхгүй. Тэр үргэлж Өөрийнх нь уучлал, эдгээлтэнд итгэсэн бүх хүмүүсийг эдгээж байсан бөгөөд өнөөдөр ч гэсэн хэвээр.

2000 жилийн тэртээ Есүсийн энэ дэлхийд байхдаа үйлдэж байсан зүйлсийг харцгаая:

**Уяман өвчтэй хүн Түүн уруу ирээд, өмнө нь сөхрөн унаж -Хэрэв Та хүсвэл, намайг цэвэр болгож чадна шүү дээ гэж гүйсанд, Тэр өрөвдөн мутраа сунган, түүнд хүрч -Би хүсэж байна. Цэвэрш гэсэнд тэр даруй түүнээс уяман өвчин нь зайлж, тэр цэвэршжээ.**

Энэ хүн Есүс түүнийг эдгээх нь Бурханы хүсэл эсэхийг шууд асуусанд, Есүс **-Би хүсэж байна** гэжээ. Тэр энэ хариуг өнөөдөр ч гэсэн өгнө. Бурхан үргэлж эдгээхийг хүсч байдаг юм.

**Үүний дараа удалгүй Есүс Найн хэмээх хот уруу явжээ. Шавь нар нь, мөн үй олон хүн Түүнийг дагалдан явлаа. Түүнийг хотын хаалганд ойртон ирэх үед хүмүүс нэг үхсэн хүнийг аваад гарч явав. Тэр нь бэлэвсэн эмэгтэйн ганц хүү байсан бөгөөд хотынхноос нилээд олон хүн тэр эмэгтэйн хамт байв. Эзэн түүнийг хараад ихэд өрөвдөн түүнд -Бүү уйл гэв. Тэр очоод авсанд гараа хүргэтэл өргөөд явж байсан хүмүүс зогслоо. Тэгээд Есүс -Би чамд хэлж байна. Залуу минь, бос! гэхэд үхсэн хүн босоод ярьж эхлэв. Ингээд Есүс түүнийг эхэд нь эргүүлэн өгөв.**

Есүс бүр үхсэн хүнийг ч амилуулах хүч ба хүсэлтэй байжээ.

**Түүнийг завинд суухад шавь нар нь Түүнийг дагалаа. Үзэгтүн. Нуурт маш хүчтэй шуурга босож, завь давалгаанд автсан боловч Есүс унтаж байлаа. Тэд Түүн уруу ирж, Түүнийг сэрээгээд -Эзэн минь, авраач, бид сүйрлээ гэхэд нь, Есүс тэдэнд -Юунд айцгаана вэ, итгэл багатай хүмүүс ээ? гээд Тэр босож, салхи болоод нуурыг зэмлэжээ. Гэтэл нам гүм боллоо.**

Ус ба салхи хүртэл Түүний Үгэнд орж байв.

**Тэд Иериход ирэв. Есүс Өөрийн шавь нар болоод олон түмний хамт Иерихогоос гарч явтал Тимайн хүү Бартимай гэгч сохор гуйлгачин замын хажууд сууж байв. Назарын Есүс явж байгааг тэр дуулаад**

**-Давидын хүү Есүс ээ, намайг өршөөгөөч гэж хашхирч эхлэв. Олон хүн дуугүй бай хэмээн түүнд хатуу хэлсэн боловч тэр харин ч бүр -Давидын хүү, намайг өршөөгөөч гэж улам их хашхирсаар байв. Есүс зогсон -**

Түүнийг нааш дууд гэлээ. Тэд сохор эрийг дуудаж, түүнд -Зоригтой бай, бос. Тэр чамайг дуудаж байна гэв. Тэр гадуур хувцсаа тайлж хаяад үсрэн босож, Есүс уруу очив. Есүс түүнд -Чиний төлөө юу хийж өгөхийг чи Надаас хүсэж байна вэ? гэхэд, сохор эр Түүнд -Рабуни (Багш гэсэн утгатай), би дахин хараатай болмоор байна гэжээ. Есүс түүнд -Яв. Итгэл чинь чамайг эдгээлээ гэж айлдахад өнөөх хүн тэр даруй дахин хараа орж, замаар Есүсийг дагалаа.

Есүс энэ хүний итгэлийг үнэлсэн юм. Тэр итгээд эдгэрсэн байна. Тийм учраас бид Бурханы Үгэнд итгэх итгэлийг онцолдог юм. **Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм.** Энгийн үгээр хэлэхэд, итгэл гэдэг бол Бурхан хийнэ гэж амласан зүйлээ хийнэ гэдэгт итгэх явдал мөн. Бурханыг Үгээр нь олзлогыг хэлж байгаа юм. Энэ нь Бурханд тааламжтай байдаг юм.

Есүийг олон хүмүүс дагаж, Түүний шахаж байлаа. Арван хоёр жилийн турш цус алддаг өвчтэй байсан нэгэн эмэгтэй байв. Тэр эмэгтэй олон эмчийн гарт шаналж, өөртөө байсан бүгдийг зарцуулсан боловч ямар ч тус болсонгүй, харин ч бие нь улам мууджээ. Есүсийн тухай сонссоны дараа тэрээр хүмүүсийн дундуур явсаар Түүний ард очиж, гадуур хувцсанд нь хүрэв. Учир нь тэр -Хэрэв би зөвхөн Түүний хувцсанд нь хүрвэл эдгэрнэ гэж өөртөө хэлжээ. Тэр даруй түүний цус гоожих нь татарч, өвчнөөс салснаа биеэрээ мэдрэв. Есүс тэр даруй Өөрөөс нь хүч гарсныг мэдээд, олон түмэн уруу эргэн харж, -Хэн Миний хувцсанд хүрэв? гэж асуулаа. Шавь нар нь Түүнд -Хурсан олон Таныг шахаж байгааг Та хар л даа. Тэгтэл Та “Хэн Надад хүрэв?” гэх юм гэлээ. Есүс үүнийг үйлдсэн тэр эмэгтэйг харах гэж эргэн тойрноо ажиглав. Юу болсныг мэдсэн тэр эмэгтэй айж чичирсээр ирж, Есүсийн өмнө унав. Тэгээд бүх үнэнээ хэлжээ. Есүс түүнд -Охин минь, итгэл чинь чамайг эдгээлээ. Амар тайван явж, зовлонгоосоо ангижрагтун гэв.

Эмч нар энэ эмэгтэйн асуудалд тусалж чадаагүй байхад Есүс түүний итгэлд хариулж чадсан юм. Та ч гэсэн итгээд, эдгэж болно шүү.

**Есүсийн үйлдсэн өөр олон үйлс бий. Хэрэв тэдгээрийг нь нэг бүрчлэн бичсэн бол бичигдсэн номууд нь энэ ертөнцөд ч багтахгүй байх байсан гэж би боддог.**

Бурханы нүдээр харахад Аврал гэдэг бол хүнийг бүхэлд нь гэмийн үр нөлөөнөөс чөлөөлж, Бурханы анхны зорилгод багтаах явдал мөн.

Бурханыг бүү хязгаарла. Түүний бичигдсэн Үг болох Библи ба Бурханы Амьд Үг болсон Есүс Христэд итгэ. Бурханыг таньж мэдэж бүх ивээл, ерөөлийг нь хүрт. Таны төлөө хийсэн бүхэнд тань Түүнд таларха. Муу нэгэнд цаашид танаас хулгайлахыг бүү зөвшөөр. Тэр бол худалч!

Дараагийн бүлэг Бурхан танд Есүсээр дамжуулан үнэгүй өгсөн бүхий л эрх ямбыг хэрхэн өөрийн болгох талаар заах болно. Бурханы амлалтуудыг хэрхэн нээж, Түүнийг хувьчлан таньсны давуу талыг амьдралдаа амсаарай. За ингээд энэ бүлгээ төгсгөөд, сурсан зүйлсийнхээ төлөө талархлын залбирал өргөө:

*Тэнгэрлиг Аав аа,*

*Таны бүхий л зан чанар Есүсийн дотор бүрэн бодитоор байдагт талархья. Надад одоо Есүс байгаа тул би жинхэнэ аз жаргалыг авлаа. Би дахиад юугаар ч, хэнээр ч дутахгүй болсондоо баярлаж байна. Би Есүсийн дотор, Тэр миний дотор, надад Есүс, Түүнд би байгаа. Бид одоо Тантай нэг болсон билээ.*

*Эзэн минь, Та одоо миний хоньчин бол тул юугаар ч дутахгүй. Та надтай үргэлж хамт байж, хэзээ ч намайг орхихгүй тул баярлалаа. Та намайг үргэлж хамгаалж, халамжилж, хөтлөн миний хэрэгцээ бүрийг хангаж өгөх учраас талархаж байна. Та намайг зөвийн замаар дагуулах тул би дахин айж, санаа зовох шаардлагагүй болсондоо баярлаж байна.*

*Ямар ч бүтээл намайг Таны хайраас салгаж чадахгүй тул баярлалаа. Одоо би Таны хамгаалалтан дор байгаа тул юу ч надад хор учруулж чадахгүй бөгөөд та надад өнө удаан амьдралыг өгсөнд талархья.*

*Одоо өвчин зовлон намайг захирахгүй болсонд баярлалаа. Би диаволыг эсэргүүцдэгийн адил өвчин эмгэгийг эсэргүүцэн, Та намайг үргэлж Өөртөө татаж, Өөрийн Үгээр хамгаалах тул би Таны уучлал болон эдгэрлийг авах болно. Таны Үг амьд бөгөөд миний амьдралд оролцож байгаад баярлалаа.*

*Би Есүсийг харахдаа Таныг харах бөгөөд Тэр энэ дэлхийд байхдаа Өөрт нь итгэж байсан хүмүүсийн төлөө хийж байсан гайхамшгуудыг миний төлөө одоо ч хийнэ гэдэгт итгэж байна.*

*Эзэн минь, би Таныг амьдралдаа хязгаарлахгүй. Таныг байгаагаар тань мэдэхийг хүсч байна. Би юу ч харсан, сонссон эсвэл бодсон бай Таныг Таны Үгээр тань хүлээн авч, итгэх болно. Таны Үг Үнэн бөгөөд Та надад хэзээ ч ямар ч нөхцөлд худал ярихгүйд талархья.*

*Би урьд нь өмнө хэзээ ч хайрлагдаж байгаагүйгээр хайрлуулж байгаад баярлалаа. Би ч гэсэн Танд хайртай.*

*Есүсийн Нэрээр залбирч байна. Амен!*



## *Жинхэнэ аз жаргал бол үр дүнтэй залбирал*

### **Тавдугаар бүлэг**

*Жинхэнэ аз жаргал бол үр дүнтэй залбирхыг хэлнэ! Өдөр болгон дэлхий даяар сая сая хүмүүс залбирдаг боловч цөөнх нь хариултаа авдаг юм.*

*Залбирал гэдэг бол далдын хүч буюу бурхдын тааллыг олох гэсэн шашны зан үйл, ёс жаяг биш юм. Жинхэнэ залбирал бол Бүтээгчтэйгээ Хүү Есүс Христээр нь дамжуулан харилцахыг хэлнэ.*

*Бурханы Үгийн дагуу залбирч сурах нь Христитгэлээр өсөхөд нэн чухал билээ. Энэ бол Бурханы хүүхдүүдийн хувьд бидэнд байдаг эрх мөн.*

*Бид хаана ч, хэзээ ч, ямар ч нөхцөл байдалд залбирсан ч Бурхан Өөрийн Үгэнд амласны дагуу биднийг сонсож хариулна гэж ойлгох хэрэгтэй.*

*Энэ бүлэгт та хэрхэн Тэнгэрлиг Аавтайгаа залбирч, Түүнээс хэрэгтэй болгоноо авах талаар заах болно.*

***Жинхэнэ аз жаргал бол үр дүнтэй залбирал ...***

Үнэн залбирал нь хүн Бүтээгчтэйгээ Түүний Есүс Христээр дамжин харилцахыг хэлнэ. Нэгдүгээр бүлгийн эцэст залбирсан залбирал нь таныг Бурхантай харилцаагаа шинэчлэн тогтооход тусалсан юм. Та Түүний хүүхэд болж, Тэр таны Тэнгэрлиг Аав болсон. Энэ бол үнэхээр хамгийн чухал залбирал мөн.

Залбирал Бурханы Хүүхэд болсон таны амьдралд маш чухал ач холбогдолтой. Та өөрийн Тэнгэрлиг Аавыг сайн таньж мэдэхийн тулд Түүнтэй залбирах цаг гаргах ёстой. Түүнтэй тогтоосон харилцаагаа хөгжүүлэхийн тулд залбирал маш чухал.

Бурхан Өөрийнх нь хүүхдүүд Өөртэй нь харилцахыг хүсдэг бөгөөд хүмүүн аавыг бодвол Тэр хэзээ ч завгүй байдаггүй. Залбирал нь жаахан хүүхэд аавтайгаа ярьдаг шиг энгийн байж болох бөгөөд магтаал, талархал ба өөрийн болон бусдын хэрэгцээ ч үүнд орж болно.

Бүлгийн төгсгөлд байгаа залбирлууд нь ихэнхдээ талархал ба магтаалынх байгаа. Бурхан хүн төрлөхтний болон таны төлөө хийсэн бүхий л зүйлсийн төлөө та талархсан билээ. Магтаал бол Бурхан танд Өөрийгөө илчилснийг Түүнд хэлэхийг хэлж байгаа юм.

Талархал, магтаал гэдэг нь та Бурханд өөрийн бодлоо үгээр илэрхийлхийг хэлнэ. Та мөн эдгээрийг дуулж илэрхийлж болно. Үүнд таны сүнс, оюун ухаан, сэтгэл хөдлөл ба бие махбод гэхчлэн бүх бие оролцож болно. Та Бурханд магтаалыг хашхирч болно. Та Бурханы өмнө бүжиглэж болно. Та ямар ч хөгжмийн зэмсгээр магтаж болно. Та гараа дээш өргөн эсвэл чимээгүйхэн талархаж болно.

Талархал, магтаал нь таны зүрх сэтгэлийн гүнээс Бурхан руу урсан гарах ёстой. Түүнийг магтахад тодорхой тогтсон үг, арга зам гэж байдаггүй. Эдгээр нь Түүний хүүхдүүдийн тоогоор өөр байж болох бөгөөд Тэр үүнд дуртай байдаг юм.

**Библид хэлэхдээ: [Тиймд] Түүгээр дамжуулан Бурханд Түүний нэрийг хүлээн зөвшөөрдөг уруулын үр жимс буюу магтаалын тахилыг үргэлж өргөцгөө.**

**Мөн, Харин та нар бол сонгогдсон угсаа, хаант тахилч нар, ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн юм. Ингэснээр харанхуйгаас та нарыг Өөрийн гайхамшигт гэрэл уруу дуудсан Түүний давуу чанаруудыг та нар тунхаглах юм.**

**Бас өөр нэгэн газар: Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн.**

Танд Бурханд талархвал зохих зүйл олон бий. Та өөртөө баярласан талархсан хандлагыг хөгжүүлээрэй. Ингэснээр та зөвхөн Бурханд авах ёстой алдрыг нь өргөөд зогсохгүй, харин ч таны сүнс, оюун ухаан тань баяр хөөрөөр бялхах болно. Бурхан таны амьдралд онцгой зүйлсийг хийх болно.

Үнэн залбирал Бурханаас хүлээж авахыг хэлнэ. Түүний Өөрийн хүүхдүүдэд амласан олон олон амлалтуудыг бид хэдийн дурьдсан билээ. Яг л нүглийн уучлалын адил Түүний ивээлүүдийг итгэлийн залбирлаар авах ёстой.

Жишээ нь, Есүс бүх хүмүүсийн гэмийн төлөөсийг төлөхийн тулд үхсэн гэтэл бүх хүмүүс аврагдаагүй шүү дээ. Яагаад? Яагаад гэвэл тэд таны адил нүглээс аврагдхын тулд Түүний нэрээр гуйгаагүй юм. Хэдийгээр Мөнхийн Амь нь үнэгүй бэлэг боловч хүн итгэлээр хүлээн авах ёстой, гэхдээ бүгдээрээ авдаггүй.

Үүнийг адилаар Есүс бүх хүмүүсийн төлөө зовж, тэдний өвчин эмгэгийг үүрсэн боловч Эдгээгч Есүсийн нэрээр итгэлтэйгээр дууддаггүй тул бүх хүмүүс эдгэдэггүй.

Бидний Тэнгэрлиг Аав болсон Бурхан маань бидний бүх хэрэгцээг хангаж, биднийг ивээж, ерөөж, эдгээхийг хүсдэг боловч энэ нь өөрөө аяндаа биелдэггүй. Тийм учраас залбирлаар гуйх гэдэг ойлголт байдаг юм. Бурханы амласан амлалтуудыг итгэлийн залбирлаар л авч болдог.

Библид, Түүний Хүслийн дагуу гуйвал Тэр биднийг сонсоно гэдэг итгэл бидэнд байдаг тул бид Бурхан руу итгэл дүүрэн ойртдог юм гэжээ. Хэрэв Тэр биднийг сонсдог юм бол бид гуйсан зүйлсээ авах болно. Бурханы Хүслийн дагуу гуйна гэдэг нь Түүний амлалт бүхий Үгийн дагуу гуйна гэсэн үг юм.

Бурханы Үг болох Түүний хүслийн дагуу гуйвал Тэр Өөрийн Үгэндээ хариулах нь гарцаагүй. Тийм ч учраас бид гуйсан болгоноо хүлээж авнаа гэдгээ мэддэг юм. Бурхан Өөрийн хүүхдүүдийн залбиралд хариулах дуртай байдаг юм.

**Есүс: Гуй, тэгвэл та нарт өгнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ. Гуйдаг хүн бүр авна, эрж хайдаг хүн олно, тогшдог хүнд нээгдэнэ. Хүүгээ талх гуйхад чулуу өгдөг хүн та нарын дунд байна уу? Эсвэл, загас гуйхад нь түүнд могой өгөхгүй биз дээ? Хэрэв та нар бузар атлаа хүүхдүүддээ сайн бэлэг өгөхөө мэддэг бол тэнгэр дэх Эцэг тань Өөрөөс нь гуйдаг хүмүүст илүү сайныг өгөх нь дамжиггүй бус уу?**

Та хүүхдийнх нь хувьд Өөрийн Тэнгэрлиг Аав руугаа очих ёстой. Тэр танд хайртай бөгөөд танд сайн сайхныг хүсдэг. Тэр тантай харилцаатай байхын тулд Өөрийн цорын ганц хайртай Хүүгээ таны төлөө өгсөн гэдгийг санаж байгаа биз дээ. Мөн Бурханд таны бүх хэрэгцээг хангах хязгааргүй их нөөц байгаа гэдгийг мартаж болохгүй. Эзний хувьд хувьд юу ч хэцүү биш. Түүнд итгэж, Түүн рүү залбирал дотор ойрт.

Нэгэн удаа Есүс Христийн дагалдагч нар Түүнээс хэрхэн залбирхыг гуйжээ. Тэр хариуд нь: **Тиймээс тэдэн шиг байж болохгүй. Эцэг тань та нарт юу хэрэгтэй байгааг гуйхаас чинь өмнө мэддэг. Тиймд ийнхүү залбир. “Тэнгэрт байгаа бидний Эцэг минь, Таны нэр ариунаар дуурсагдаг. Таны хаанчлал ирэх болтугай. Хүсэл тань тэнгэрт шигээ газар дээр биелэгдэх болтугай. Өдөр тутмын минь талхыг энэ өдөр бидэнд өгөөч. Бид өртөнгүүдээ уучилсны адил бидний өрийг мөн уучлаач. Биднийг сорилгод бүү оруулаач, Харин бузар муугаас гэтэлгээч. Учир нь хаанчлал, хүч чадал, алдар сүр үүрд Таных. Амен”**

Биднийг гуйхаас өмнө Бурхан бүгдийг мэддэг гэдгийг бид Есүсээс сурсан билээ. Бид Бурханы Нэрийг хүндэлж, дээдэлж, бишрэх хэрэгтэй. Хэдийгээр Бурхан бидний Аав ба Анд боловч бид Түүнээс эмээж, Түүнийг хүндэтгэх ёстой билээ.

Есүс бидэнд Бурханы Хаанчлал ба Түүний Хүсэл Тэнгэрт биелэгддэг шиг газар дээр биелэгдэхийн төлөө залбир гэж заасан билээ. Түүний хаанчлал гэдэг нь Түүний Эзэн байх ба Түүний хүсэл нь бидний амьдралыг удирдахыг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, бидний Тэнгэрлиг Аавын удирдлага, Эзэн байх, хүсэл нь Тэнгэрт биелдэг шиг энэ дэлхийд бидний амьдралд биелхийг хэлж байгаа юм. Бидний төлөө Тэнгэрт болж буй бүхэн энэ газарт биднийх болоосой гэж бид залбирах ёстой.

Энэ бол Бурханы төгс, тааламжит, сайхан хүслийн дагуу хэрхэн залбирахад тус болох Үнэн юм. Бурхан одоо Тэнгэрт захирдаг шиг Түүний хаанчлал энэ дэлхийд бидний амьдралд биелэгдэхийн төлөө залбирхын зэрэгцээ Түүний хүсэл Тэнгэрт биелдэг шиг газар дээр биелхийн тулд залбирах хэрэгтэй.

Жишээ нь, хэрэв та өнөөдөр гуниг байгаа бол та баяр хөөр, урам зоригийн төлөө Тэнгэрлиг Ааваасаа гуйх хэрэгтэй, учир нь тэр нь таны төлөө Тэнгэр дахь Түүний хүсэл мөн. Уйтгар гуниг, урам хугаралт нь Тэнгэрт байдаггүй зүйлс билээ.

Мөн Тэнгэрт өвчин зовлон байхгүй учраас та өвчин тусвал Бурхан таныг эрүүл, өвчингүй байгаасай гэж хүсдэг үндсэн дээр та Бурхан таныг эдгээж, өвдөлтийг тань арилгана гэсэн бүрэн итгэлтэйгээр залбирах ёстой байна.

Бидний өдөр тутмын хэрэгцээ хангагдана, тийм ч учраас Бурхан Өөрийн алдар дахь баялгаар хангахын төлөө залбир гэж Есүс заасан билээ. Бидний хэрэгцээ ямар байхаас үл хамааран Бурхан өдөр болгон хангана гэж залбирах ёстой. **ЭЗЭН бол миний хоньчин, Надад дутах зүйл нэг ч үгүй** гэж бичигдсэнийг санаж байгаа биз дээ.

Хэрэв бид нүгэл үйлдвэл уучлалын төлөө залбирах хэрэгтэй гэж заалгасан нь **Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ** гэдэг бичээсийн дагуу билээ. Бид хэдий аврагдаад, Түүний хүүхэд болсон ч заримдаа нүгэл хийчихдэг юм.

Мөн бидний эсрэг гэм хийсэн хүмүүсийг уучилж, тэдний төлөө бид залбирах ёстойг заалгасан юм. Бурханы эсрэг үйлдсэн бидний гэмийг Бурхан уучилсан тул бид тийнхүү уучлах ёстой билээ.

Есүс биднийг муу нэгэнээс гэтэлгэж, уруу татлагаас хамгаалж өгөөч гэж залбирхыг заасан байна. Бид бүгдээр гэм нүгэлд уруу татагддаг. Сатан бол уруу татагч, гэхдээ ихэнх тохиолдолд бид өөрсдийн зүрхний хүслээс болж уруу татагддаг билээ. Уруу татлага бол гэм биш. Уруу татагдах үедээ бид гэм нүглийг эсэргүүцэж, муу нэгэнээс гэтэлгэж өгөхийг залбирч чадна.

Есүс Өөрийн дагалдагч нартаа: **Уруу татлаганд орохгүйн тулд эсрэмжтэй байж, залбир. Сүнс хүсэвч, махбод нь сул дорой гэжээ.**

Мөн, **Учир нь бидэнд байгаа нь бидний мөхөс байдлыг хуваалцаж чаддаггүй тэргүүн тахилч бус, харин нүгэлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон Нэгэн билээ. Тиймд бид хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олон, өршөөлийг хүлээн авахын тулд нигүүлслийн хаан ширээнд итгэлтэйгээр ойртон очицгооё.**

Тийм учраас бид уруу татагдах үедээ уруу татагч болон уруу татлагыг ялан дийлсэн Есүстэй өөрсдийгөө адилтгаж, бидний Тэнгэрлиг Аав маань хэрэгцээтэй цагт бидэнд ивээл, нигүүлслийг үзүүлнэ гэдэгт бүрэн итгэлтэйгээр хаан ширээ рүү ойртож чадна.

Есүс залбирлын тухай Өөрийн сургаалаа Тэнгэрлиг Аавын хаанчлал, хүч чадал, алдарт итгэж найдахаар төгсгөсөн байна. Бурханы хаанчлал, хүч чадал, алдар нь бидний залбиралд хариулахад мөнхөд бэлэн байх

юм. Бурхан Өөрийн хүүхдүүдэд амласнаа биелүүлнэ гэдэгт итгэлтэй залбирвал Түүний Тэнгэр дахь нөөц баялаг нь үргэлж бидний газар дахь хэрэгцээг хангах болно.

**Тийм учир Би та нарт хэлье. Та нар юуны төлөө залбирч, гуйж байна, түүнийгээ авсан гэдэгтээ итгэгтүн. Тэгвэл тэр чинь ёсоор болно гэж Есүс хэлжээ. Үүнийг ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэх нь маш чухал. Залбирахдаа өөрийн гуйсан зүйлээ авсан гэдэгтээ итгэрээрэй. Гуйсан зүйлээ харах гэж бүү хүлээ харин Бурхан хариулсан хэмээн итгэлээрээ хүлээж ав, тэгвэл та харах болно.**

Харах нь итгэл биш, харин итгэвэл харна! Есүс нэгэн удаа Өөрийн дагалдагч Томаст хандан, **-Чи Намайг харсан учраас итгэв үү? Хараагүй атлаа итгэсэн хүмүүс нь ерөөлтэй еэ!** гэжээ. Бид Тэнгэрлиг Аавынхаа Үгэнд итгэдэг учраас итгэхийн тулд харах шаардлагагүй. Ийм л итгэл Бурханд таалагддаг юм. **Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм.**

Бурхантай харилцах бидний харилцаа нь Бурханы Үг Үнэн гэдэгт итгэх бидний итгэлээс шууд хамаарна гэдгийг санаарай. Бурхан Өөрийн Үг болох Библид ямар нэгэн зүйлийг бидэнд илчилж, хэлэх үед бид өөрсдийн нөхцөл байдал, бодож санаж байгаа болон харж, мэдэрч байгаагаас үл хамааран итгэж, үйлдэх хэрэгтэй. Бид Бурханыг Үгээр нь хүлээн авч, биднийг залбирахад Тэр амласнаа биелүүлнэ гэдэгт итгэдэг.

Есүс залбирлын тухай **Үнэнээр Би та нарт хэлье. Та нар газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдох бөгөөд газар дээр юуг тайлна, тэр нь тэнгэрт мөн тайлагдах болно. Би та нарт дахин хэлье. Хэрэв та нараас хоёр чинь ямар нэгэн зүйлийг гуйх талаар газар дээр санаа нийлбэл, тэнгэр дэх Миний Эцэг үүнийг чинь тэдний төлөө биелүүлэх болно. Учир нь хоёр буюу гурван хүн Миний нэрээр хаана цуглана, тэнд Би тэдний дунд байна гэж айлдав.**

**Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Надад итгэдэг хүн Миний хийдэг ажлуудыг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно. Яагаад гэвэл Би Эцэгтээ очно. Та нар Миний нэрээр юуг ч гуйсан, Эцэг Хүүгээрээ алдаршуулагдахын тулд Би түүнийг хийнэ. Хэрэв та нар Миний нэрээр юуг ч Надаас гуйвал, Би түүнийг чинь хийнэ.**

**Та нар Намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон. Та нарыг явж, жимс ургуулж, та нарын үр жимс үүрд байгаасай гэсэндээ Би та нарыг томилсон. Ингэснээр Миний нэрээр та нар Эцэгээс юуг ч гуйсан Тэр та нарт өгөх юм.**

Тэр өдөр та нар Надаас юуны ч тухай асуухгүй. Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Миний нэрээр Эцэгээс минь юу ч гуйвал Тэр түүнийг чинь өгнө. Одоо болтол та нар Миний нэрээр юу ч гуйгаагүй. Гуйгтун. Та нарын баяр баясгалан дүүрэн болгогдохын тулд та нар хүлээн авна.

Есүс байгаа учраас бид Тэнгэрлиг Аавтайгаа харилцаатай байдаг, Есүс байгаа учраас Бурхан бидний гуйлтыг сонсож, хариулдаг. Есүс Христ бидний бүх юм, Түүнгүйгээр бид хэн ч биш билээ. Тийм учраас бид Тэнгэрлиг Аавтайгаа Есүс Христийн Нэрээр залбирдаг юм. Бид Есүсийн нэрээр гуйхад Есүс Христ бидний өмнөөс гуйж байгаа гэсэн үг юм.

Есүсийн Өөрийнх нь хэлсэн үгнээс харахад бид бүрэн итгэлтэйгээр Тэнгэрлиг Аавдаа ойртоход Тэр бидний залбиралд хариулна. Есүсийн нэрээр гуйхад бид гуйснаасаа илүүг авах болно. Бидний харж буй бүхнийг өргүй хоосноос бүтээсэн орчлон ертөнцийн Бүтээгч Бурханаас гуйж байгаа гэдгээ санаж яваарай. Тэр үг хэлэхэд бүх зүйл бий болсон!

**Бидний дотор ажиллаж буй Өөрийн хүчний дагуу бидний гуйсан болон бодож санаснаас илүү ихийг хийх чадалтай Түүнд алдрыг өргөө.**

Та юуны ч төлөө санаа зовох хэрэггүй, учир нь: **Юунд ч бүү санаа зов, харин бүхий л зүйлд талархалтайгаар залбирал ба гуйлтаараа өөрсдийн хэрэгцээг Бурхан өргө. Бүх ухааныг давуулагч амар тайвны Бурхан Есүс Христ дотор та нарын оюун ухаан ба зүрхийг хамгаалах болно.** Бурханы амар тайван дутагдах үед өөрийн санаа зоволтоо Эзэнд даатгаж, гуйлтаа талархалтайгаар өргөвөл Түүний амар тайван таных болно.

Таны итгэлийн амьдралд юу хийхээ ч мэдэхгүй үе гарахад: **Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно. Харин тэр ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйг. Учир нь эргэлзэгч нэгэн нь салхиар туугдан давалгаалах тэнгисийн долгио мэт ажээ. Тийм хүн Эзэнээс юм авна гэж бүү найдаг. Тэр хүн хоёр санаа өвөрлөгч бөгөөд бүх үйлдээ тогтворгүй байдаг юм.** Та Бурханаас мэргэн ухаан гуйж байгаа бол Түүнийг танд мэргэн ухаан өгнө гэдэгт итгээрэй.

Залбирал бол таны амин судас гэж хэлж болно. Библид, **Өөрсдийгөө залбиралд зориулж, сонор сэрэмжтэй бөгөөд талархалтай бай. Учир нь Бурханы нүд шударга хүмүүсийг хайж, чих нь тэдний залбирлыг анхааран сонсдог** гэж байдаг юм. Өдөр болгон хэд хэдэн удаа залбирах чимээгүй газар олоод Эзэнтэй цаг гаргаарай.

Доор Есүсийн залбирч байсныг Бурханы Үгээс иш татсан байна.

**Цугласан олныг явуулаад Тэр ганцаар уул өөд залбирхаар явав. Үдэш болоход Тэр тэнд байсаар байлаа.**

**Өглөө эрт харанхуй байхад, Тэр босоод гадагш гарч зэлүүд газарт очин, тэндээ залбирч байв.**

**Тэр өдрүүдэд Есүс уул өөд гарч, тэндээ шөнөжин залбирч хонов.**

**Олон тохиолдолд Есүс ганцаар зайдуу гарч залбирдаг байжээ.**

Есүс Бурхантай залбирах цагийг их чухалд үздэг байсан юм. Бид ч гэсэн Түүнтэй тогтоосон харилцаагаа авч явахын тулд тийнхүү өдөр болгон залбирах ёстой.

Яг одоо Бурханд залбирлаар талархал өргөө:

*Тэнгэрлиг Аав минь ээ,*

*Таныг Хэн болохын тань төлөө талархан, магтаж байна. Та үнэхээр гайхамшигтай, Таны Алдар хийгээд Сайныг хараад би биширч байна. Есүс Христийн Нэрээр Танруу ойртон очих болсондоо гүнээ талархаж байна. Та Өөрийн Хайрыг надад илчилсэнд Танд магтаалыг өргөө.*

*Хэрэгцээтэй үедээ Таны нигүүлслийн хаан ширээнд ивээлийг тань хүртэхийн тулд зоригтойгоор очих урилгыг Үгээрээ өгсөнд баярлалаа. Миний залбирлыг сонсох хүсэлтэй байдаг ба хариулахад бэлэн байдагт талархая. Есүс Христийн Нэрээр бүрэн итгэлтэйгээр Таны өмнө очих болсондоо талархаж байна.*

*Та Өөрийн хүүхдүүдэд сайн сайхныг хүсдэг бөгөөд биднийг гуйхаас өмнө мэддэгт баярлалаа. Та Өөрийн Үгэндээ Хүслээ илэрхийлснээр би Таны Хүслийн дагуу гуйж, хариугаа авах болсондоо талархаж байна.*

*Таны Хүсэл Тэнгэрт биелдэг шиг миний амьдралд биелэх болсонд баярлалаа. Таны хаанчлал яг одоо миний амьдралд орж ирээч гэж гуйж байна. Миний бүх нүглийг уучилсанд баярлалаа, би миний эсрэг муу юм хийсэн хүмүүсийг уучлах шийдвэр гаргаж байна.*

*Та Өөрийн алдар дахь баялгаар Есүс Христээр дамжуулан миний бүх хэрэгцээг хангаж өгөөч гэж гуйж байна. Таны Үгийн дагуу миний сүнс хөгжихийн хирээр бие минь эрүүл болж, амжилттай байхын*



*төлөө залбирч байна. Надад бүх зүйлийг өгч, миний бүх зүйл болж, би юугаар ч дутахгүй болсондоо талархаж байна.*

*Өнөөдөр Есүс Христийн дотор миний зүрх ба оюун ухааныг хамгаалж байдаг бүх ухааныг давагч Таны амар тайвны төлөө талархаж байна. Гэм, өвчин, гачигдал намайг хүлэх чадалгүй болсон бөгөөд би миний Эзэн, Аврагч, Эдгээгч Есүс Христээр давуулан дийлэгч болсондоо талархаж байна.*

*Таны Алдар, Хүндэтгэлийн тулд хайр ба итгэлийн амьдралаар амьдрах мэргэн ухааныг өгөөч гэж гуйж байна. Өнөөдөр намайг бүх Үнэнд дагуулах Ариун Сүнсний төлөө талархаж байна. Үргэлж Таны хүссэн хүн байж, Таны Хүслийг биелүүлэн, Танд тааламжтай амьдрах хүчийг өгөөч. Миний залбирлыг сонссонд баярлалаа.*

*Есүсийн Нэрээр залбирч байна. Амен!*

## *Жинхэнэ аз жаргал бол Сүнс доторх амьдрал*

### **Зуравдугаар бүлэг**

*Жинхэнэ аз жаргал бол Сүнс доторх амьдрал! Есүс Христийг өөрийн Аврагч, Эзэнээр хүлээн авах үед Ариун Сүнс таны амьдралд гайхамшигтай зүйлийг хийсэн юм.*

*Та Сүнсээр гэгээрч, Сүнсээр дахин төрсөн юм. Харин Тэр одоо таны дотор амьдарч байгаа бөгөөд таны амьдралыг бүх талаар удирдахыг хүсч байна.*

*Одоо Ариун Сүнс таны дотор амьдарч байгаа учраас та өөрийн амьдралдаа төрөлхийн зөн болон ухаанаас хол давна. Та Христийн дотор амьд болсон тул танд хязгааргүй боломж нээгдсэн билээ.*

*Ариун Сүнс таны амьдралыг хэзээ ч мөрөөдөж байгаагүйгээр чинь удирдан чиглүүлэх болно. Бурханы Сүнс таны сүнстэй хамт таныг Түүний Хүүхэд болсныг гэрчилж, Тэр таныг бүхий л зүйлд удирдан дагуулах болно.*

***Жинхэнэ аз жаргал бол Сүнс доторх амьдрал ...***

Есүс Христ удахгүй Тэнгэрлиг Аавруугаа буцахын тулд хүн төрлөхтний төлөө амиа өгөхөө мэдэж байсан тул дараах үгсийг Өөрт нь итгэж байсан дагалдагч нартаа хэлсэн юм.

**Би Эцэгээсээ гуйхад, Тэр та нарт өөр Туслагчийг өгнө. Тэр нь та нартай үүрд хамт байна. Тэр бол үнэний Сүнс мөн бөгөөд Түүнийг харахгүй, мэдэхгүйгээсээ болж, ертөнц Түүнийг хүлээж авч чадахгүй. Харин та нар Түүнийг мэднэ. Яагаад гэвэл Тэр та нартай хамт үргэлж байх бөгөөд та нарын дотор байна. Би та нарыг өнчрүүлж орхихгүй. Би та нар уруу ирнэ.**

**Би Эцэгээсээ та нар уруу Туслагчийг илгээнэ. Тэр бол Эцэгээс гарах үнэний Сүнс мөн. Тэр ирэхдээ Миний тухай гэрчилнэ. Та нар эхнээсээ Надтай хамт байсан тул бас гэрчилнэ. Та нарыг бүдрэхээс хамгаалахын тулд эдгээр зүйлийг Би та нарт хэллээ.**

**Би та нартай хамт байхдаа энэ бүгдийг хэллээ. Харин Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн минь илгээх Ариун Сүнс та нарт бүх зүйлийг заах бөгөөд Миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно. Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай.**

**Харин Би та нарт үнэнийг хэлж байна. Миний явах нь та нарт хэрэгтэй. Хэрэв Би явахгүй бол Туслагч та нар уруу ирэхгүй. Харин Би явбал Өөрөө Түүнийг та нар уруу илгээнэ. Тэр ирэхдээ нүгэл, зөвт байдал хийгээд шүүлтийн талаар ертөнцийг зэмлэнэ.**

**Тэр Намайг алдаршуулна. Яагаад гэвэл Тэр Минийхийг авч, түүнийгээ та нарт мэдүүлнэ. Эцэгт байгаа бүх юм Минийх. Тиймээс “Тэр Минийхийг авч, түүнийгээ та нарт мэдүүлнэ” гэж Би хэлсэн билээ.**

Есүс Христ энэ дэлхийд хүний биеэр байхдаа Өөрийн дагалдагч нартайгаа гурван жил гаруй хамт байсан. Тэд Түүнээс шууд суралцаж, тэдний бүх хэрэгцээг нь хангаж байжээ. Тийм учраас Тэр Тэнгэрт буй Аав руугаа явсан ч, Бурхан урьдын адил тэдэнтэй байна гэдгийг хэлж, тэднийг тайвшруулж, зоригжуулхыг хүсчээ.

Бурханы Үг, Библи бидэнд цорын ганц Үнэн Бурхан Эцэг, Хүү ба Ариун Сүнс гэсэн Гурвалаар оршидог гэж заадаг. Тиймд Бурханы Үгийн дагуу бид тэдгээрийг тус бүрд нь сайн таньж, зөв харилцаа хөгжүүлэх нь чухал билээ.

Та анх Бүтээгчтэйгээ эвлэрэх хэрэгтэй гэж бодож эхэлсэн цагаас Ариун Сүнс танд нөлөөлж эхэлжээ. Таныг нүгэл дотор үхмэл хэвээр байхад Тэр таны нүдийг сүнслэг зүйлсийг харуулхын тулд нээсэн байна. Бурханд хүрэх цорын ганц зам бол Аврагч Есүсээс өөр зам үгүй гэдгийг Тэр илчилсэн юм.

Та Есүс Христийг өөрийн Аврагч, Эзэн хэмээн хүлээж авахдаа Сүнснээс Сүнсээр дахин төрсөн юм. Та Бурханаас тэнгэрлиг мөн чанарыг авч, Түүнтэй харилцаж эхэлсэн. Харин одоо та цоо шинэ амьдрал ба сүнслэг Үнэнийг харах боллоо.

Тухайн үл үзэгдэх, сүнслэг Хаанчлал нь Тэнгэрийнх бөгөөд энэ дэлхийнх биш, зөвхөн Бурханы Сүнсээр дахин төрсөн хүмүүст Ариун Сүнсээр илчлэгддэг. Нэгэн удаа Есүс их шашинлаг хүнд хандан:

**-Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн дээрээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалыг үзэж чадахгүй гэхэд Никодем Түүнд**

**-Настай болсон атлаа хүн хэрхэн төрөх билээ? Хүн эхийн хэвлийд хоёр дахиа орж, төрж чадна гэж үү? гэлээ. Есүс**

**-Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй. Махан биеэс төрсөн нь махан бие, Сүнснээс төрсөн нь сүнс болой. “Чи дээрээс төрөх ёстой” гэж Би чамд хэлсэнд бүү гайх. Салхи дуртай газраараа үлээдэг. Чи дууг нь сонсовч, салхийг хаанаас ирж, хааш оддогийг мэддэггүй. Сүнснээс төрсөн хүн бүр үүнтэй адил байдаг гэж айлдав.**

Өнөөдөр ч гэсэн энэ дэлхийд сүнсний Үнэнийг ойлгодоггүй түмэн шашинлаг хүмүүс бий. Тэд Бурханы Хаанчлалыг ойлгож, орж чадахгүй. Тэдний шашинлаг зан үйл, ёс жаяг, сайн үйлс дэмий хоосон юм. Тэд зөвхөн Есүс Христийг Аврагч, Эзэн хэмээн хүлээж авбал Бурханы Сүнсээр дахин төрж чадна.

Есүс Өөрийн тухай: **-Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй гэж үргэлж санаж яваарай.**

Шашинлаг хүмүүс таны шинэ амьдрал, амьдралын хэв маягийг ойлгоход бэрхшээлтэй тулгарна. Учир нь Библид: **Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Учир нь тийм хүнд эдгээр нь мунхаг явдал бөгөөд эдгээрийг ойлгож чадахгүй. Яагаад гэвэл эдгээр нь сүнслэгээр үзэгддэг. Харин сүнслэг хүн бүхнийг олж хардаг байхад, түүнийг хэн ч олж хардаггүй. “Учир нь Эзэний оюун ухааныг хэн мэдсэн бэ? Хэн Түүнд заавар өгөх вэ?”. Харин бидэнд Христийн оюун ухаан бий.**

Тиймд Есүс Христийг өөрийн Аврагч, Эзэн гэж хүлээн авч, Сүнсээр дахин төрөөгүй хэн ч таны адил бодож, сэтгэж, үйлдэхгүй гэдгийг ойлгоорой. Таны амьдралын хэв маяг тэдэнд тэнэг мэт санагдах болно.

Мөн тэдний бодож сэтгэж байгаа болон амьдралыг үзэх үзэл бодолд бүү автаарай. Танд одоо Христийн оюун ухаан байгаа бөгөөд Ариун Сүнс танд Бурханы хаанчлалын дагуу амьдрахад хэрэгтэй бүхий зүйлсийг зааж, туслах болно.

**Есүс энэ талаар: Ариун Сүнс та нарыг бүх үнэн рүү дагуулна. Бурханы Сүнснээс өөр хэн ч Бурханы бодлуудыг мэдэхгүй. Бурханы бидэнд үнэгүй өгсөн юмсыг мэдэхийн тулд бид ертөнцийн сүнсийг бус, харин Бурханаас ирсэн Сүнсийг хүлээн авсан юм.**

Бурханы Үгэнд итгэгч нар Үнэнд суралцахдаа хүмүүст бус Ариун Сүнсэнд найдах хэрэгтэй гэж хэлсэн байдаг. **Та нарыг мэхлэхийг оролдож буй хүмүүсийн талаар эдгээрийг би та нарт бичсэн. 27Та нарын Түүнээс авсан тосолгоо нь та нарын дотор байдаг бөгөөд өөрсдөд чинь заах хэн нэгэн та нарт хэрэггүй. Харин Түүний тосолгоо нь та нарт бүхнийг заадаг бөгөөд тэрхүү тосолгоо нь худал биш, үнэн. Та нарт заасан ёсоор та нар Түүний дотор байгтун.**

Ариун Сүнс бидэнд Үнэнийг болон дайсны худал хуурмагаас хэрхэн ялгаж салгахыг зааж, зааварчилдаг билээ. Та өөрийн болон Бурханы Сүнсгүй хүмүүсийн ухаанд найдаж болохгүй, завхан Бурханы Ариун Сүнсэнд найдах хэрэгтэй.

Ариун Сүнс Бурханы Үг Библийг удирдан бичүүлсэн болохоор Бурханы бодлуудыг мэддэг юм. Есүс Христэд бид өөрдийн мөнхийн тавилангаа итгэж даатгасны адил хэрэв бид Ариун Сүнсийг хүндэлж, Түүнд амьдралынхаа бүхий л талбарыг өргөвөл Тэр бидний оюун ухааныг Үнэн рүү дагуулна.

Бид Ариун Сүнстэй харилцах харилцаагаа мэдлэг, сэтгэл хөдлөл эсвэл махбодын утгаар бус харин Түүний Үгийг уншиж, судалж, тунгаан бодох замаар хөгжүүлэх ёстой. Ариун Сүнстэй харилцах харилцааны гол түлхүүр нь Бурханы Үг байх хэрэгтэй.

Та нарын Сатан бол хууран мэхлэгч бөгөөд дүрээ хувиргаж чадна гэдгийг битгий мартаарай. Тэр өөрийн худлыг Үнэн мэт харагдуулж чаддаг тул түүнийг нь ялгах цорын ганц арга бол Үнэнийг өөрөө мэдэх явдал юм. Ариун Сүнсний онгодоор бичигдсэн Бурханы Үг болох Үнэнийг мэдсэн тохиолдолд диаволын үнэнтэй харьцуулан ялгаж чадна.

Тиймд Бурхан бидэнтэй Ариун Сүнсээрээ ярьж байгаа эсэхийг мэдэхэд Бурханы Үг чухал юм. Ариун Сүнс Христийн гэсэн болгоныг бидэнд илчилж өгдөг. Ариун Сүнс бидний сүнстэй харилцахдаа Библиетэй нийцэх Бурханы бодлуудыг ярих болно. Түүний Бичигдсэн ба Хэлэгдсэн Үгс нь нэг юм.

Хэрэв Ариун Сүнс биднийг Бурханы Үгийн эсрэг хөтлөн дагуулж байвал энэ нь Бурханаас биш юм. Энэ нь нэг бол диавол биднийг хууран мэхлэх гэж байгаа эсвэл бидний өөрсдийн ухаан, сэтгэл хөдлөл, төрөлхийн зан чанар маань хүссэнээ гүйцэлдүүлхийг хичээж байгаа хэрэг.

**Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог бөгөөд зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай гэж бичигдсэн байдаг.**

Бурханы Үг биднийг харгалзагч. **Таны үг бол миний хөл дэх дэнлүү, Миний зам дахь гэрэл юм.** Бурханы Үг үргэлж бидэнд Түүний ухааныг болон Түүний төгс, сайн, тааламжит Хүслийг илчилдэг. Түүний Үг бидний зүрх, сэтгэл, хүсэлд буй төрөлхийн зүйлсийг сүнслэг зүйлсээс ялгаж өгдөг.

Гэхдээ өдөр болгон Ариун Сүнсний удирлага болон Бурханы чиглүүлгийг авахын тулд бид өөрсдийн хүслийг Түүний Хүсэлд нийцүүлэх ёстой. Бидний амьдралд Бурханы хүсч буй зүйлсийг бид мөн амьдралдаа хүсч, мөн Түүний хүсч буй шалтгааны адил байх ёстой. Тэгснээр Ариун Сүнс бидэнтэй харилцаж, Бурханы төгс, сайн, тааламжит хүслийг хэрэгжүүлэх болно.

Бурханы бидэнд бэлдсэн амьдралыг амсахаас өөр аз жаргал гэж үгүй. Танд зориулсан Бурханы хүсэл болох Бүтээгчтэйгээ төгс уялдаатай амьдрах нь хамгийн амар тайван бөгөөд баяр хөөртэй амьдрал мөн. Та Ариун Сүнснийг алхам алхмаар дагахдаа Бурханы оршихуй, амар тайван болон Түүний Эцэгийн хайрыг мэдрэх болно.

**Учир нь махан биеийн дагуу байгчид нь махан биеийн юмсыг боддог. Харин Сүнсний дагуу байгчид нь Сүнсний юмсыг боддог. Махан биеийн бодол санаа бол үхэл, Сүнсний бодол санаа бол амь ба амар тайван болой. Мөн, Бурханы Сүнсээр удирдуулж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд юм.**

Бид өөрсдийн оюун ухааныг Ариун Сүнснийхтэй нийцүүлж, Түүгээр удирдуулхыг зөвшөөрвөл бид бүх зүйл дээр Түүнийг дагах болно. Бид өөрсдийн амьдрал дахь Бурханы Хүслийг хэлж чадахгүй. Бид

өөрсдийн хүслээ хаяж, Түүнд бүрэн бууж өгөх хэрэгтэй.

Дараа нь бид дагахад бэлэн байх ёстой. Бид дагахгүй л бол Бурхан бидний замыг гэрэлтүүлж, чиглүүлэхгүй. Бид дагахгүй бол Түүнд дуулгаваргүй байна гэсэн үг. Түүний Хүсэл ямар байхаас үл хамааран бид дагахын тулд Бурханы Хүслийг мэдэх гэж тэмүүлэх ёстой.

Хэрэв бид Бурханы илэрхийлэгдсэн хүслийг өөрсдийн сонголтоор дагавал Түүний дуу хоолой болон Ариун Сүнсний удирдлаганд саад учруулна. Бурханы Алдар болон өөрсдийн сайн сайхны төлөө бид ямар ч нөхцөлд Ариун Сүнсний удирдлагыг дагах хэрэгтэй. Ингэснээр бид өөрсдийн үйлсээр Бурханд бүрэн найдаж байгаагаа харуулна.

Ариун Сүнсний удирдамжинд найдах хэрэгтэй. Тэр бидэнтэй хамт байдаг бөгөөд удирддаг гэдэгт итгэх ёстой. Бид бүх зүрхээрээ Түүнд найдаж, Түүний царайг эрэлхийлэх нь зүйтэй. Библид: **Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ. Өөрийн бүх замаараа Түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно. Тэрээр урсгал усны дэргэд тарьсан мод адил билээ. Тэр мод цагтаа үр жимсээ ургуулдаг бөгөөд Навчис нь ч хатдаггүй. Тэр хүний үйлс бүхэн нь өлзийтэй.**

Ариун Сүнс биднийг бидэнд сайнгүй газар хөтлөн дагуулах болов уу гэж хэзээ ч санаа зовох шаардлагагүй. Тэр Бурханы бодлуудыг эхнээс нь төгсгөл хүртэл мэддэг бөгөөд хэзээ ч алдаа хийдэггүй, мөн бидэнд зөвхөн сайныг л хүсдэг юм. Түүнд бүрэн итгэж сур. Үүнд бид суралцдаг тул Бурхан ойлгож, тэвчээртэй ханддаг юм.

Бид Эзэний замаар явж байхдаа бүдрэх боловч хэрэв бид Түүний хүсэл, арга замуудыг мэдэж, Түүнд алдрыг өргөх гэсэн чин хүсэлтэй байхад Тэр хэзээ ч бидний унагаж орхихгүй. Ирээдүйд Түүний дуу хоолой, удирдамжийг ялгаж сурахын тулд Бурхан бидэнд алдаанаас сурах боломж өгнө.

Бид махбодийн адил сүнсний хувьд балчир хүүхэд байдаг. Хүүхдэд мөлхөж, зогсож, алхаж сурахад хугацаа хэрэгтэй байдгийн адил Сүнс дотор алхаж сурахад багагүй хугацаа хэрэгтэй.

Сүнс дотор алхана гэдэг нь Бурханд таалагдахыг хэлнэ. Түүний хүүхдүүдийн хувьд бид Тэнгэрлиг Аавдаа алдрыг авчирч, Есүс Христийг бусдад таниулахын тулд хичээдэг. Үүнийг зөвхөн Сүнс дотор алхаж биелүүлнэ.

Библид, **Харин Сүнсээр яв, тэгвэл та нар махан биеийн хүслээ гүйцэлдүүлэхгүй гэж би та нарт хэлнэ. Христ биднийг хайрлаж,**

**Өөрийгөө Бурханд өргөл ба анхилуун үнэрт тахил болгосон шиг Түүний хайрт хүүхдүүдийн адил Бурханыг дууриагчид бай.**

Бид урьдын гэм нүгэл болон бугийн хүлээсэнд байсан шиг амьрахгүй. **Христ биднийг эрх чөлөөтэй болгохын тулд чөлөөлсөн юм. Иймд бат зогс, дахиж боолчлолын буулганд бүү орогтун.** Бид нүгэлд боолчлогдсон байсан, гэхдээ одоо Бурханы зорилгын дагуу амьдарна. Бид Есүс Христийн адил хэрхэн амьдрахад Ариун Сүнс тусалж, хүч чадлыг өгөх болно.

Библид: **Христ Есүст хамаатай хүмүүс өөрсдийн махан биеэ бузар хүсэл, тачаалынх нь хамт загалмайд цовдолсон ажээ. Хэрэв бид Сүнс дотор амьд байгаа юм бол, мөн Сүнс дотор явцгаая.** Бид махан биеийн хүслийн дагуу амьдрахаа больсон. Хэрэв бид Ариун Сүнстэй хөл нийлүүлэн алхвал Тэр бидэнд Есүсийн амьдралыг харуулах юм.

Сүнс дотор алхах ба Ариун Сүнстэй хөл нийлүүлэх гэдэг нь өдөр болгон гаргадаг шийдвэр мөн. Ариун Сүнс үргэлж Есүсийн амьдралыг бид нараар дамжуулан гаргахыг хичээдэг. Есүсийн амьдрал бол хайрын амьдрал мөн. Бурхан бол хайр бөгөөд Есүсийн амьдралыг энэ үгээс өөр сайн илэрхийлэх үг байхгүй.

**Учир нь Хүний Хүү хүртэл үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд, мөн Өөрийн амийг олны төлөө золиос болгон өгөхийн тулд ирсэн юм гэж айлдлаа.** Үүний адилаар бид Ариун Сүнсний удирдлагаар өөрсдийн амьдралаа Бурханы хайрын амьдрал болгох хэрэгтэй.

Бүхий л хуулийг Есүс **-Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла, мөн хөршөө өөрийн адил хайрла. Та нар хүмүүсийг өөрсдөдөө хэрхэн хандаасай гэж хүснэ, тэдэнд мөн түүнчлэн ханд гэдэг өгүүлбрээр илэрхийлсэн юм.**

**Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал.** Хэрэв та Ариун Сүнсэнд дуулгавартай байж, Түүнийг дагавал Тэр эдгээр үр жимсийг таны амьдралд гаргана.

**Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй, зохисгүй авирладаггүй, өөрийнхийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй, зөвт бус байдалд баярладаггүй, харин үнэнд баярладаг, бүгдийг далдалдаг, бүгдэд итгэдэг, бүгдэд найддаг, бүгдийг тэсвэрлэдэг. Хайр хэзээ ч дуусдаггүй. Харин эш үзүүлж байгаа бол, тэдгээр нь үгүй болно. Хэрэв олон янзын хэлүүд байгаа бол тэд болих болно. Хэрэв мэдлэг байгаа бол энэ ч үгүй болно.**



**Найдвар нь урам хугалдаггүй. Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжуулан Бурханы хайр бидний зүрхэнд цутгагдсан байдаг тул бид өөрсдийгөө хайрладгийн адил Бурхан болон бусдыг хайрлаж чадна. Өөрөөр хэлбэл, Ариун Сүнс бидэнд Есүсийн хийх байсан зүйлийг илэрхийлэхэд өөрсдийн махан бие болон хүслээс үл хамааран дагахыг хэлж байгаа юм.**

Бусдын хувьд гэвэл та тухайн нөхцөлд тэр хүмүүсийн танд яаж хандаасай гэж хүснэ түүний адил тэдэнд хандана гэсэн үг. Та өөртөө хэрхэн хандаж байна, түүний адил бусдад хандах ёстой.

Та урьдын адил өөрийгөө бүх зүйлд хамгийн түрүүнд байлгах гэж хичээх хэрэггүй, яагаад гэвэл Христ таныг бүтэн болгосон юм. Та одоо Бурханыг болон бусдыг бүхний түрүүнд тавьж чадна. Та дараах Үгсийг уншаад, тунгаан бодож, дагаарай:

**Тиймээс хэрэв Христ дотор ямар нэгэн дэмжлэг байгаа бол, хэрэв хайрын тайвшрал байгаа бол, хэрэв Сүнсний нөхөрлөл байгаа бол, энэрэнгүй болоод өрөвчхөн сэтгэл байгаа бол, адил сэтгэж, адил хайртай байж, сэтгэлээрээ нэгдэн, нэгэн бодолтой байж, намайг гүйцэд баярлуул. Юуг ч өрсөлдөх сэтгэлээр, эсвэл бардам зангаар бүү хий. Харин даруугаар бие биеэ өөрөөсөө дээр гэж үзэж, хүн бүр зөвхөн хувийн ашиг сонирхлыг бус, харин бусдын ашиг сонирхлыг хар. Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай. Тэрээр хэдийгээр Бурханы мөн чанараар оршин байсан боловч, Бурхантай тэгш байх явдлыг Өөртөө хадгалах зүйл гэж үзсэнгүй, харин Өөрийгөө хоосолж, боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ. Хүн төрхийг олсон Тэрээр үхэлд ч төдийгүй загалмайн үхэлд ч хүртэл дуулгавартай байснаараа Өөрийгөө даруу болгов. Тиймээс ч Бурхан Түүнийг үлэмжийн дээдээр өргөмжилсөн бөгөөд аливаа нэрээс дээд нэрийг Түүнд соёрхов. Энэ нь Есүсийн нэрд тэнгэрт байгаа, газар дээр байгаа, газрын доор байгаа бүх юмс өвдөг сөгдөж, мөн бүх хэл Бурхан Эцэгийн алдрын төлөө Есүс Христ бол Эзэн гэж хүлээн зөвшөөрөх ёстойн учир ажээ.**

Та Есүсийн хэлсэн дараах үгсийг дагавал ерөөгдөнө:

**Харин Би та нарт хэлье, хар санаатай хүнийг бүү эсэргүүц. Харин хэн баруун хацрыг чинь алгадна, түүнд нөгөө хацраа бас тавьж өг. Хэрэв хэн нэг хүн чамтай заалдаж, цамцыг чинь авахыг хүсвэл дээлээ бас түүнд өг. Хэн нэг хүн чамайг нэг бээр газар явахыг хүчилбэл түүнтэй хамт хоёр бээр яв. Чамаас гуйсан хүнд өг, чамаас зээлэхийг хүссэн хүнээс бүү зайлхий. “Хөршөө хайрла, дайснаа үзэн яд” гэж хэлснийг та нар сонссон. Харин Би та нарт хэлье. Дайснуудаа хайрла, та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир.**

Хэрэв та нар өөрсдийг чинь хайрладаг хүмүүсийг хайрлавал, та нарт ямар шагнал байх вэ? Татвар хураагчид ч хүртэл үүнтэй адилыг хийдэг бус уу? Хэрэв та нар зөвхөн ах дүүстэйгээ мэндэлбэл, бусдаас илүү юу хийж байгаа юм бэ? Харь үндэстнүүд ч хүртэл мөн ингэдэг бус уу? Тиймээс тэнгэрлэг Эцэг тань төгс байдаг шиг та нар мөн төгс бай.

Шүүгдэхгүйн тулд бусдыг бүү шүү. Яллагдахгүйн тулд бусдыг бүү ялла. Уучлагтун, тэгвэл та нар ч мөн уучлагдана. Өгөгтүн, тэгвэл чамд өгөгдөх болно. Тэгэхдээ шахагдсан, чигжсэн мөн бялхсан хэмжээтэйгээр хормой дээр чинь асгарах болно. Учир нь өөрсдийнхөө хэмжүүрийн жишгээр та нар хариуд нь хэмжигдэх болно гэлээ.

Ариун Сүнс бидэнд өдөр болгон Есүсийг дууриаж, Түүний сургаалыг дагахыг сануулж, удирдах болно. Ариун Сүнснийг дага, тэгвэл та Тэнгэрлиг Аав, Есүс Христ болон Ариун Сүнсний дотны харилцаатай болтлоо Түүний оршихуйг өдөр тутмынхаа амьдралд харах болно.

Ариун Сүнс нь танд харагдахгүй, Тэнгэрлиг Нэгэн мөн. Хэдий та Түүнийг харахгүй ч хэнээс ч илүү бодитой болохыг мэднэ. Тэр хэзээ ч таныг хүчлэхгүй. Харин та Түүний оршихуйд мэдрэмжтэй байж, Есүсийг танд илчлэхийг зөвшөөрөх хэрэгтэй.

Бурханы Хүүхдийн хувьд та хэрхэн амьдрах нь маш чухал. Дараах Бурханы Үгс танд Ариун Сүнснийг бөхөөхгүй байх заавар өгнө.

Та нарын амнаас ямар ч ялзарсан үг бүү гараг. Харин хэрэгтэй үед нь бусдыг босгон байгуулахын тулд зөвхөн тустай үг хэл. Тэгвэл энэ нь сонсож буй хүнд нигүүлслийг өгнө. Бурханы Ариун Сүнснийг бүү гомдоо. Золилтын өдрийн төлөө та нар Түүгээр тамгалуулсан билээ. Аливаа хорсол, уур, хилэн, шуугиан, гүтгэлэг нь бүх бузар муугийн хамт та нараас зайлаг. Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биеэ уучлан, нэг нэгнээ энэрэн уян зөөлөн сэтгэлээр ханд.

Тиймээс хайрлагдсан хүүхдүүд адил Бурханыг дуурайгчид болцгоо. Христ та нарыг хайрласан бөгөөд Өөрийгөө бидний төлөө Бурханд анхилуун үнэрт өргөл ба тахил болгон өргөсний адил хайр дотор яв. Харин ариун хүмүүст үл нийцэх садар самуун, аливаа бузар булай, шунал нь та нарын дунд бүү дурсагдаг. Бузар булай болон мунхаг яриа, эсвэл тоглоом тохуу нь зохимжгүй. Харин оронд нь талархлаа өргө. Садар самуун, бузар булайг үйлдэгч, шүтээнийг шүтэгч шунахай ямар ч хүнд Христийн болон Бурханы хаанчлалд өв байхгүй гэдгийг та нар ойлго.

Хэн ч та нарыг хоосон үгсээрээ бүү мэхлэг. Яагаад гэвэл эдгээрээс болж Бурханы уур хилэн дуулгаваргүй хөвгүүд дээр буудаг юм. 7Иймд тэдний хамсаатан байж болохгүй. Учир нь та нар урьд нь харанхуй байсан. Харин одоо та нар Эзэн дотор гэрэл ажээ. Гэрлийн хүүхдүүд шиг яв. Учир нь алив сайн, зөвт байдал ба үнэн дотор гэрлийн үр жимс байна. Ингэхдээ Эзэнд таалагдах юманд суралц. Харанхуй, үр жимсгүй ажлуудад бүү оролц, харин ч тэдгээрийг илчлэгтүн.

Та нар нэгэнт харанхуй байсан бол одоо энэ хорвоогийн гэрэл болсон. Гэрлийн хүүхдүүд шиг амьдарч, Эзэнд таалагдах зүйлийг ол. Ямар нэг үр жимсгүй харанхуйн үйлстэй бүү холбогд, харин ч тэднийг илчил.

Энэ бүлэгт та Ариун Сүнстэй хэрхэн харилцаагаа хөгжүүлж, Жинхэнэ аз жаргалыг амсах талаар сурлаа. Дараагийн бүлэгт та Ариун Сүнсний үйлчлэлийн бусад талбаруудыг мэдэх болно. Залбирхаасаа өмнө Есүсийн хэлсэн үгсийг уншаарай.

**Би та нарт хэлье. Гуй, тэгвэл та нарт өгөгдөнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ. Учир нь гуйдаг хүн бүр авна, эрж хайдаг хүн олно, тогшдог хүнд нээгдэнэ. Эцгүүд та нарын нэгээс чинь хүү нь загас гуйвал оронд нь могой өгөхгүй нь лавтай. Тийм биш гэж үү? Эсвэл хүү нь өндөг гуйвал, эцэг нь хилэнцэт хорхой өгөхгүй биз дээ? Хэрэв та нар бузар атлаа хүүхдүүддээ хэрхэн сайн бэлэг өгөхөө мэддэг юм бол, тэгэх тусмаа тэнгэрлэг Эцэг тань Өөрөөс нь гуйдаг хүмүүст Ариун Сүнс өгөх нь дамжиггүй гэв.**

Дараах залбирал таны Ариун Сүнстэй харилцах харилцаанд тус нэмэр болно.

*Тэнгэрлиг Аав минь ээ,*

*Ариун Сүнсээр дамжуулан намайг Өөртөө ойртуулж, сүнслэг дахин төрөлтөөр надад Мөнхийн Амийг өгсөнд Танд талархаж байна. Гуйсан хүн бүрт Ариун Сүнсээ өгнө гэсэн амлалтанд баярлалаа. Тиймд яг одоо миний амьдралд Ариун Сүнсээ дүүргэн өгч, Есүсийг илчлэн, Түүний төлөө хэрхэн амьдрахыг минь зааж, алхам бүрийг минь удирдан чиглүүлж, амьдралын минь бүх талбарыг захираач гэж гуйж байна.*

*Та үргэлж амлалтандаа хүрдэг бөгөөд Есүс Христийг улам илүү таниулхын тулд надад Ариун Сүнсээ өгсөнд баярлалаа. Ариун Сүнсэнд мэдрэмтгий байж, Түүнийг ямарваа нэгэн байдлаар гомдоохгүй байхад минь туслаарай. Ариун Сүнс намайг бүхий л Үнэнд хөтөлж, амьдралын минь туршид Есүсийг улам их таниулж, илчлэх болсонд Тандаа талархая.*

*Бурхан минь, надад Үнэний Сүнсийг, худал Үнэнийг ялгах чадвартай Христийн ухааны хамт өгсөнд баярлалаа. Та намайг удирдаж байна уу, эсвэл өөр сүнс намайг төөрөгдүүлж байгаа эсэхийг шалгах Бурханы Үгийг өгсөнд талархая. Би үргэлж Таны хүслийг мэдэж, дагахыг хүсч байна.*

*Аав аа, Та Өөрийн хайрыг Ариун Сүнсээр миний зүрх сэтгэлд цутган өгснөөр би Таныг болон бусдыг хайрлах хүчтэй болсондоо баярлаж байна. Би одоо Христийн дотор бүтэн болсон тул Таныг болон бусдыг өөрөөсөө дээгүүр тавьж чадна.*

*Та миний дотор болон надаар дамжин алдаршиж, бусдад гэрчлэлтэй байхын тулд би Ариун Сүнсэнд дуулгавартай байж, Түүний үр жимсийг амьдралдаа арвинаар гаргахыг хүсч байна.*

*Эзэн, Та намайг Өөрийн хүссэнээр ашиглахын тулд намайг өөрчлөөч. Би Танд ашиглагдхыг хүсч байна. Би одоо Таных болсондоо маш их баярлаж байна.*

*Есүсийн Нэрээр залбирч байна. Амен!*

## *Жинхэнэ аз жаргал бол Бурхантай хамтрах*

### *Долдугаар бүлэг*

*Жинхэнэ аз жаргал бол Бурхантай хамтрах юм! Бурхантай хамтрах нь хамгийн үр дүнтэй амьдрал мөн. Чингэвэл Бурханы хүүхдүүд хамгийн өндөр оргилд хүрч, бүх нөөц бололцоогоо ашиглах болно.*

*Бурхантай хамтран амьдрахаас илүү сайхан зүйл гэж үгүй. Бидний болон ойр дотны хүмүүсийн амьдралд Бурханы зорилго, төлөвлөгөөг Түүнтэй хамтран биелүүлэх нь Жинхэнэ аз жаргал авчирдаг.*

*Бурхантай ямар ч хамааралгүй, харилцаагүй байхад бидний амьдрал хоосон, утга учиргүй байсан билээ. Харин Есүст итгэн, дахин төрснөөр бид Бурханы хамтрагчид болдог. Та Түүнтэй мөр зэрэгцэн, Ариун Сүнсний тусламжтайгаар ер бусын амьдралд бэлэн боллоо.*

*Дагалдагч нар нь газар сайгүй явж, Түүнийг гэрчлэхэд Эзэн тэдэнтэй хамт байж, үйлсийг нь тэмдгүүдээр ерөөж, Үгээрээ баталж байв. Эзэн тийнхүү тантай хамтран ажиллахыг хүсч байна.*

***Жинхэнэ аз жаргал бол Бурхантай хамтрах ...***

Түрүүчийн бүлэгт бид таны амьдралд Ариун Сүнс хэрхэн энэ ертөнц, махбод болон диаволыг дийлэхэд нэн чухал болохыг дурьдсан билээ. Харин одоо бид христигэлт амьдралын нэн чухал хэсэг болох Ариун Сүнсний хүч чадлаар Бурхантай хөл нийлүүлэн амьдрах тухай үзэх болно.

Бурхан анхнаасаа ямар санаатай байсныг санаж байгаа биз дээ. Бурхан хүнтэй хамтран энэ дэлхий дээр Өөрийн зорилгыг биелүүлхийг хүссэн юм.

Нэгдүгээр бүлэгт:

“Тэд өөрсдийн Бүтээгчтэйгээ хамт байсан тул үнэхээр сайхан ивээлтэй амьдарч байжээ. Бурхан тэдэнд газар дэлхий дээрх бүх бүтээлүүдийг захирах онцгой эрхийг өгсөн бөгөөд тэдэнд өсөн үржиж, дэлхийг эзэгнэн захир хэмээжээ. Бурхан тэдэнд бүх амьтдыг нэрлэхээс аваад бүгдийг захирах эрх олгожээ”.

Бурханы хүүхдүүдийн хувьд бидэнд одоо илүү эрхэм зорилго бий. Нэгэнт Есүс Христ бидний нүглийг Өөрийн Ариун Үнэт цусаараа худалдан авсан тул бид одоо өөрсдийн эзэн биш харин бусад хүмүүсийг ч бас Христ дээр авчрах ариун эрхэм зорилготой хүмүүс билээ.

Бурхан хэрхэн Өөрийн амьдралаа энэ дэлхийд Христээр дамжуулан илчилсний адил бид үүнийг Түүнд зөвшөөрснөөр хийж чадна. Бурханыг хүмүүст таниулах нь зөвхөн Ариун Сүнсний оролцоотой хийж биелэх ер бусын ажил мөн. Есүс Христийн дотор ажиллаж байсан тэр л Ариун Сүнс одоо бид нараар дамжуулан Бурханыг бүх хүмүүст харуулахыг хүсч байна.

Есүс Тэнгэр Бурхан Аав руугаа буцсаныхаа дараа Өөрийн дагалдагч нартаа, та бид нарт ч мөн адил Сайн Мэдээг дэлхийн бүх хүмүүст тарааж, бидний адил аврагдаасай гэсэн тушаал өгсөн юм.

**Библид: Учир нь “Эзэний нэрээр дуудах хэн ч аврагдах болно”. Тэгвэл Түүнд итгээгүй тэд яаж Түүнийг дуудах вэ? Түүнийг сонсоогүй тэд яаж Түүнд итгэх вэ? Тэд номлогчгүйгээр яаж сонсох вэ?**

Есүсийг бусдад мэдүүлэх гэсэн Бурханы төлөвлөгөөнд та чухал үүрэгтэй шүү. Бурхан тантай хамтарч, Есүсийн Сайн Мэдээг таны эргэн тойронд буй хүмүүст хүргэхийг хүсч байна. Та одоо аврагдаад, Христийг мэддэг болсон тул Түүний тухай бусдад ярих эрхэм зорилготой боллоо.

Таны хувьд ганцаараа Бурханы ивээлүүдийг хүртээд, бусад хүмүүстэй хуваалцахгүй байвал эрүүл бус үзэгдэл болно. Есүс Христ бүгдийн нүглийн төлөө үхсэн тул тэд бүгдээрээ Түүнийг мэдэх хувьтай. Та өөрийн адил Есүс Христийг хүлээж авах боломжийг хүмүүст олголгүй тэднийг нүгэл дотроо нас барж, мөнхийн тамд унахыг харж чадах уу.

Хайрын илрэл болгож хүний хийж чадах хамгийн агуу зүйл бол Есүс Христийн тухай Сайн Мэдээг хүнд ярьснаар тэр хүн итгэж, Эзэний нэрээр аврагдах явдал мөн. Гэхдээ тэд өөрсдийнх нь нүглийн төлөөст амиа өгсөн, Бүтээгч Бурханд хүрэх цорын ганц зам болсон Есүсийн тухай сонсохгүй бол хэрхэн Түүний нэрээр дуудаж, аврагдах вэ?

Бурхан таныг яг одоо Тэнгэрт авалгүй, энд дэлхийд байлгаж байгаагийн тэргүүн шалтгаан нь та Есүсийг бусдад таниулахад оршидог юм. Бурхан хэн нэгэнийг ашиглаж танд Сайн Мэдээг хүргэсний адил одоо танаар дамжуулан бусдад хүрэхийг хүсч байна.

Бурханы энэхүү төлөвлөгөөний талаар Түүний Үг болох Библиэс харцгаая: **Тиймээс хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун, шинэ болсон байна. Бүх юмс Бурханаас байгаа юм. Тэр Христээр биднийг Өөртэйгөө эвлэрүүлж, бидэнд эвлэрлийн үйлчлэлийг өгсөн байна. Яагаад гэвэл Бурхан дэлхийг Христ дотор Өөртэйгөө эвлэрүүлж, хүмүүсийн гэм бурууг үл харгалзсан бөгөөд эвлэрлийн үгийг бидэнд даалгасан билээ. Иймээс бид Христийн төлөөх элчин сайд нар юм. Бурхан биднээр дамжуулж ятгаж байгаагчлан бид Христийн төлөө та нараас гуйя. Бурхантай эвлэрцгээ. Тэр нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө нүгэл болгосон юм. Тэгснээр бид Түүний дотор Бурханы хүртээх зөвт байдал болох юм.**

Эдгээр үгс таныг шинэ бүтээл болсныг сануулж эхэлж байна. Таны хуучин нь өнгөрсөн. Танд одоо Бурханаас ирсэн цоо шинэ амьдрал бий. Тэр таныг Өөртэйгээ эвлэрүүлсэн юм. Тэр зөвхөн таныг Өөртөө аваад зогсохгүй, тантай хамтран, харилцаатай байхын тулд таныг өөрчилсөн юм.

Тэр таныг зөвхөн Өөртэйгээ эвлэрүүлээд зогссонгүй, мөн бусад итгэгч нарын хамт танд эвлэрүүллийн үйлчлэлийг өгсөн юм. Энэ бол бусдын сайн сайхны төлөө болон Христийн алдрын төлөө, Түүний өмнөөс хийж болох таны үлчлэл мөн.

Та бол одоо Бурханы элчин сайд буюу Түүний төлөөлөгч мөн. Энэ бол Бурханаас танд олгосон ер бусын хүч чадал ба аз завшаан юм. Та хаа ч явсан мөхөж буй хүмүүст амь, амар тайван ба итгэлийг тунхаглах боллоо. Христийг төлөөлж байгаагийн хувьд танд эвлэрүүллийн

үйлчлэлд хэрэгтэй бүхэн өгөгдсөн. Таны Есүсийн Нэрээр явж байхад Бурхан гайхамшигтай байдлаар Христийг бусдад таниулах болно. Түүний эрх мэдэл одоо таных болсон.

Тэр танд зөвхөн эвлэрүүллийн үйлчлэлийг өгөөд зогсоогүй танд өөрт тань хандан эвлэрүүллийн мэдээг даалгасан юм. **Яагаад гэвэл Бурхан дэлхийг Христ дотор Өөртэйгөө эвлэрүүлж, хүмүүсийн гэм бурууг үл харгалзсан бөгөөд эвлэрлийн үгийг бидэнд даалгасан билээ.**

Бусад хүмүүс Бурханы Хайр ба тэдний төлөө Хүү Есүс Христ нь юу хийснийг та хэлэх үүрэгтэй. Хүмүүс энэхүү Сайн Мэдээг сонсож байж л Бүтээгч рүүгээ эргэх болно.

Ихэнх хүмүүс өөрсдийгөө гэмтэй гэдгээ мэддэг тул Бурханаас байнга зугатааж явдаг. Тэд Бурхан тэдний нүглийг Христээр дамжуулан цагаатгаж, тооцоо хийхгүй болсныг мэдээгүй байдаг. Хүмүүс энэ сайхан мэдээг сонсоод өөрсдийн эрхгүй Бурхан руу эргэж, Түүний хүүхэд болохыг хүснэ.

Гэхдээ тэд эхлээд сонсох ёстой. Үүний тулд та тэдэнд Есүс Христ тэдний нүглийн төлөөсийг Загалмай дээр төлсөн гэдэг Сайн Мэдээг хэл. Есүсийн ариун цус тэдний нүглийн төлөөсөнд урсаж, тэднийг гэмийн боолчлолоос чөлөөлсөн гэдгийг тэд танаас сонсох ёстой. Тэд сонсохоос нааш хэрхэн Түүнд итгэх вэ?

**Бурхан дэлхийг Христ дотор Өөртэйгөө эвлэрүүлж, хүмүүсийн гэм бурууг үл харгалзсан гэдгийг танаас сонсох хэрэгтэй.**

Тэр нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө нүгэл болгосон юм. Тэгснээр бид Түүний дотор Бурханы хүртээх зөвт байдал болох юм гэдгийг танаас л сонсох ёстой.

Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм гэдгийг танаас сонсох учиртай.

Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Христ Есүс доторх мөнх амь мөн гэдгийг танаас сонсохгүй өөр хэнээс сонсох вэ.

Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр биш аж. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно гэдгийг танаас л сонсох ёстой.

**Хүүтэй хүнд амь бий. Бурханы Хүү байхгүй хүнд амь байхгүй.**



Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно.

Учир нь “Эзэний нэрээр дуудах хэн ч аврагдах болно”.

Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв. Тэд цусаар биш, махан биеийн хүслээр ч биш, хүний хүслээр ч биш, харин Бурханаар төрөгсөд билээ.

Тиймээс итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг гэдгийг санаж байгаа биз дээ.

Тийм учраас та өдөр тутам учирч буй хүмүүстээ Бурханы Үгэнд буй Үнэнийг хуваалцах хэрэгтэй. Тэд энэ бүхнийг сонсоод өөрсдийн гэм нүглээс болон диаволын хууран мэхлэлтээс болж Бурханаас нуугдан, зугатахын оронд Түүнрүү эргэж, Мөнхийн Амьдралын бэлгийг авах боломжтой болно.

**-Бурхан бол нүүр тал хардаггүй.** Тэр энэ бүхнийг таны төлөө хийсэн бөгөөд танаар дамжуулан бусдын төлөө хийхийг хүсч байна. Таныг авраад энэ дэлхийд үлдээсэн шалтгаан гэвэл Тэр таныг Есүс Христийн тухай Сайн Мэдээг Бурхантай хамтран тараалгахад байсан юм. Үнэгүйгээр авснаа үнэгүйгээр өг. Бидний Эзэн Есүс Христийн Эцэг ба Бурхан магтагдах болтугай. Тэр бол өршөөлийн Эцэг, мөн бүх тайвшралын Бурхан мөн. Бурхан биднийг тайвшруулсан тэрхүү тайвшралаар бид аливаа зовлонд орогсдыг тайвшруулах чадвартай байхын тулд Тэр биднийг бүх зовлон дотор маань тайвшруулдаг юм.

Та өөртөө авсан ивээл, нигүүлсэл, амар тайван, тайвшрал, уучлалыг одоо бусдад өгөх цаг боллоо. Бурханы танд өгсөн бүхнийг бусдад дамжуулах нь танд зориулсан Бурханы төлөвлөгөө мөн. Та бусдад Жинхэнэ Аз Жаргалыг түгээх зэмсэг болсноор энэ нь таны амьдралд биеллээ олох болно.

Хамгийн эхэнд Бурхан тэднийг адислаж, тэдэнд -Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэн, газрыг эзэмш!

Есүс Христ: Та нар Намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон. Та нарыг явж, жимс ургуулж, та нарын үр жимс үүрд байгаасай гэсэндээ Би та нарыг томилсон. Ингэснээр Миний нэрээр та нар Эцэгээс юуг ч гуйсан Тэр та нарт өгөх юм.

Бурханы төлөвлөгөө бол хүүхдүүд нь авсан зүйлсээ бусдад дамжуулахад оршидог. Бурхан Есүсээр дамжуулан хийсэн бүхнээ

танаар дамжуулан хийхийг хүсдэг. Та өөрийн итгэж буй Сайн Мэдээг бусдад тунхагласнаар тэд итгэж, Есүс Христийг өөрсдийн Аврагч, Эзэн болгоосой гэж хүсдэг.

**Есүс Христ: Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Надад итгэдэг хүн Миний хийдэг ажлуудыг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно. Яагаад гэвэл Би Эцэгтээ очно. Та нар Миний нэрээр юуг ч гуйсан, Эцэг Хүүгээрээ алдаршуулагдахын тулд Би түүнийг хийнэ. Хэрэв та нар Миний нэрээр юуг ч Надаас гуйвал, Би түүнийг чинь хийнэ.**

**Мөн, Миний дотор байгун. Би ч та нарын дотор байна. Усан үзмийн модонд холбогдохгүй юм бол мөчир өөрөөсөө жимс ургуулж чадахгүйн адил хэрэв та нар Миний дотор байхгүй бол тийм байх болно. Би бол усан үзмийн мод, та нар бол мөчрүүд. Хүн Миний дотор байж, Би мөн түүний дотор байвал, тэр хүн их жимс ургуулна. Учир нь Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй.**

**Бидэнд хэрэгтэй бүх хүч, хайр ба зориг нь Христийн дотор байж, Есүс Христ бид нараар Өөрийн амьдралаа харуулна гэж Ариун Сүнсэнд итгэх итгэлээр ирнэ. Бид Есүсийн хийж байсан зүйлсийг өөрсдийн хүч чадлаар хийж чадахгүй. Бид Түүнгүйгээр юу ч хийж чадахгүй. Бид Түүний дотор байх ёстой.**

**Есүс өөрийн дагалдагч нартаа: -Бүх дэлхийгээр явж, сайн мэдээг бүх бүтээлд тунхаглагун. Хэн итгэж баптисм хүртэнэ, тэр аврагдах болно. Харин итгээгүй хүн нь яллагдах болно.**

**Итгэгчдэд энэ тэмдгүүд дагалдана. Миний нэрээр тэд чөтгөрүүдийг зайлуулж, шинэ хэлээр ярина. Тэд могойг барина. Тэд үхүүлэх ямар ч юм уусан, тэр нь тэдэнд хор болохгүй. Өвчтэй хүн дээр тэд гараа тавивал эдгэнэ гэж айлдлаа.**

**Ингээд Эзэн Есүс тэдэнд айлдсаны дараа тэнгэр өөд авагдаж, Бурханы баруун гарт залрав. Тэд явж, газар сайгүй тунхаглажээ. Эзэн тэдэнтэй хамт ажиллаж, үгийг дагалдах тэмдгүүдээр баталж өгчээ.**

Есүс дагалдагч нартаа газар сайгүй явж, тунхагла гэж тушаагаад Тэнгэрээс тэдэнтэй хамтран ажиллаж, Өөрийн Үгээ гайхамшигт тэмдгүүдээр баталж байгаа нь үнэхээр гайхалтай. Дараах ишлэлүүд эдгээр үйлс болон бид нарын Христийн төлөөлөгч байх амьдралд Ариун Сүнсний оролцоо ямар чухал болохыг харуулна.

**Тэгээд элч нарыг нэг дор цуглуулан Иерусалимыг орхилгүйгээр Эцэгийн амласныг, Түүний “Та нар Надаас сонссоны дагуу, Иохан усаар баптисм**

хүртээдэг байсан бол харин та нар ойрын өдрүүдэд Ариун Сүнсээр баптисм хүртэх болно” гэснийг хүлээхийг тэдэнд тушаасан ажгуу. Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай энэ дэлхийн хязгаар хүртэл Намайг гэрчлэх болно гэв.

Есүс Христийн анхны дагалдагчид Түүний тушаалын үгчлэн биелүүлж байв. Тэд хэлсэн ёсоор залбираад хүлээж байтал Эзэн амласнаа биелүүлсэн тухай харцгаая.

Пентекостын өдөр болоход тэд цөмөөрөө нэг газарт цугласан байлаа. Гэнэт тэнгэрээс хүчит хуй салхи мэт дуу чимээ гаран, тэдний сууцгааж байсан байр бүхэлдээ тэрхүү дуунд автагджээ. Тэгтэл гал хаялах мэт хэлүүд бий болон хүн нэг бүрийн дээр тогтохыг тэд харлаа. Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв.

Тэр цагт тэнгэрийн доорх үндэстэн бүрээс сүсэгт иудейчүүд Иерусалимд амьдарч байв. Энэхүү дуу чимээнээр үй олон хүмүүс цугларч, өөрсдийнх нь төрөлх хэлээр тэдний ярихыг сонсоод ихэд гайхжээ.

Гайхаж алмайрсан тэд -Энэ ярьж байгаа хүмүүс чинь галилчууд биш үү? Гэтэл бид бүгдээрээ өөрсдийн төрөлх хэлээрээ тэдний ярихыг сонсож байх нь юу вэ? Партчүүд, медечүүд, еламчууд, Месопотами, Иудей, Каппадок, Понт, Ази, Фруг, Памфул, Египет болон Курений хавийн Ливийн хэсэгт суугчид болон Ромоос ирэгсэд болох иудейчүүд болон шинэ сүсэгтнүүд, кретийнхэн, арабууд болох бид Бурханы агуу үйлсийн тухай тэдний яриаг өөрсдийн төрөлх хэл дээр сонсоцгоолоо гэв.

Жирийн хүмүүс Есүс Христийн Сайн Мэдээг Ариун Сүнсний хүчээр дэлхийн бүх хүмүүст тунхаглав. Есүсийг гэрчлэн, тунхаглаж байхад юу болсон талаар Бурханы Үгээс уншицгаая.

Израиль эрчүүд ээ, эдгээр үгсийг сонсоцгоо. Бурхан Назарын Есүсээр дамжуулан та нарын дунд хүчит үйлс, гайхамшиг, тэмдгүүдийг бүтээж, энэ хүнийг та нарт үзүүлсэн. Та нар өөрсдөө ч мэднэ. Бурханы урьдаас мэдэх мэдлэг болон урьдаас тогтоосон төлөвлөгөөний дагуу тушаагдсан энэ Хүнийг та нар бурхангүй хүмүүсийн гараар загалмайд хадуулж, алсан. Гэтэл Бурхан үхлийн зовлонг эцэс болгон Түүнийг амилуулав. Учир нь Түүний хувьд үхлийн хүчинд автагдах нь боломжгүй юм.

Энэ Есүсийг Бурхан амилуулсан бөгөөд бид бүгдээрээ үүний гэрч нар мөн. Тиймээс Бурханы баруун гарт өргөмжлөгдөж, Эцэгээс амласан Ариун Сүнснийг аваад, Тэр та нарын үзэж, сонсоцгоож байгааг цутгасан юм. Тиймээс Бурхан та нарын цовдолсон тэр Есүсийг Эзэн, бас Христ

**болгосныг Израилийн айл бүхэн баттай мэдэгтүн гэв.**

**Сонссон зүйл нь тэдний зүрхийг хөндсөнд, Петр болон бусад элч нараас -Ах дүү нар аа, бид одоо яах вэ? гэж асууцгаав. Петр тэдэнд**

**-Гэмшигтүн, хүн бүр өөрсдийн нүглийн уучлалын төлөө Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Та нар ч Ариун Сүнсний бэлгийг авах болно. Учир нь уг амлалт нь та нар болон та нарын хүүхдүүдийнх төдийгүй бас алсад суугч бүрийнх бөгөөд манай Бурхан Эзэнээр дуудагдсан болгоных билээ гэв. Тэр өөр олон үгээр гэрчлэн**

**-Энэхүү завхруулагч үеийнхнээс аврагдагтун гэж тэднийг сэнхрүүлж байлаа. Ийнхүү түүний үгийг хүлээн авсан хүмүүс баптисм хүртэцгээв. Тэр өдөр гурван мянга орчим хүн нэмэгджээ.**

**Тэд байнга элч нарын сургаалыг сонсож, бас нөхөрлөж, талх хувааж, залбирцгааж байлаа. Хүн бүрд айдас байлаа. Элч нар Иерусалимд олон гайхамшиг, тэмдгийг үзүүлж байв. Бүгдийн дээр үлэмжийн айдас байлаа. Итгэсэн бүгд хамтаараа байцгаан, байгаа бүхнээ нийтээрээ хэрэглэж байв. Тэд эзэмшил, өмч хөрөнгөө худалдаж, түүнийгээ хүн бүрийн хэрэгцээг харгалзан бүгдэд түгээдэг байлаа. Өдөр бүр тэд нэг сэтгэлээр сүмд цуглаж, талхаа айлуудад хувааж, баяр хөөртэйгөөр, чин сэтгэлээсээ хооллоцгоон Бурханыг магтаж, бүх ардын хайр хүндэтгэлийг олж байв. Эзэн тэдэн дээр аврагдагсдын тоог өдрөөс өдөрт нэмэгдүүлж байлаа.**

Христийнхний үүсэл гарлын тухай Библи ийнхүү өгүүлж байна. Мянга мянган хүмүүс Есүс Христэд итгэж, усан баталгаа хийлгээд Сүмд нэмэгдэж байлаа. (Та усан баталгаа болон сүмийн талаар энэ номын нэмэлт хэсгээс уншаарай.) Хүмүүсийн амьдрал бүрмөсөн өөрчлөгдөж байв. Гайхамшиг, тэмдгүүд нь Есүсийн нэрээр хийгдэж, бүх хүмүүс Бурханас эмээж байсан юм. Ариун Сүнс Есүсээр дамжуулан хийлгэж байсан зүйлсээ одоо Түүний дагалдагч нараар хийлгэж байгаа бөгөөд хийлгэсээр байна.

**Петр, Иохан нар залбирлын цаг болох есдүгээр цагт сүм уруу явж байв. Төрөлхийн хазгар нэгэн хүнийг хүмүүс авчран сүмийн Үзэсгэлэнт хэмээх дааман хаалганы дэргэд суулгаж, тэр хүн өдөр бүр сүмд ирэгсдээс гүйлга гуйдаг байжээ. Петр, Иохан нарыг сүм уруу очиход тэр тэднээс гүйлга гуйж эхлэв. Петр Иоханы хамт түүн уруу харц тогтоон, -Наашаа хар гэв. Тэднийг ямар нэгэн юм өгөх нь хэмээн горьдон, мөнөөх хүн тэдэн уруу анхаарав. Харин Петр түүнд**

**-Надад алт, мөнгө байхгүй. Харин өөрт байгаагаа л би чамд өгье гээд,**

-Назарын Есүс Христийн нэрээр босоод явагтун хэмээн хэлээд баруун гараас нь барьж өндийлгөсөнд түүний хөл, шагай тэр даруй хүч орж, үсрэн цэх зогсоод алхаж эхлэв. Тэр цовхчин Бурханыг магтан тэдний хамт сүмд явж орлоо.

Бурханыг магтан алхаж буй түүнийг бүх хүмүүс хараад сүмийн Үзэсгэлэнт Дааман хаалганы дэргэд гуйлга гуйхаар суудаг байсан нэгэн болохыг таньж, түүнд юу тохиолдсоныг үзээд гайхаж хоцорсон байлаа. Өнөөх хүн Петр, Иохан нарын хамт байх зуур гайхаж хоцорсон хүмүүс бүгд гүйлдэн Соломоны танхимын орчимд цугларчээ. Харин Петр үүнийг хараад, тэдэнд хариулан -Израильчууд аа! Та нар юунд үнд гайхна вэ? Бид өөрсдийнхөө хүч, эсвэл сүсгээр энэ хүнийг явдаг болгосон мэт ингэлээ юунд биднийг ширтэнэ вэ? Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан, Иаковын Бурхан, бидний эцэг өвгөдийн Бурхан Өөрийн үйлчлэгч Есүсийг алдаршуулжээ. Түүнийг та нар барьж өгсөн. Харин Пилат Түүнийг чөлөөлөхөөр шийдсэн байхад та нар түүний өмнө үгүйсгэсэн шүү дээ. Ариун агаад зөвт Нэгэнийг та нар үгүйсгэсэн атлаа алуурчныг өршөөхийг гуйсан боловч үхэгсдээс Бурханы босгосон амийн Зохиолчийг алуулсан билээ. Үүний гэрч нар нь бид юм.

Түүний нэрд итгэсэн итгэлийн үндсэн дээр, та нарын харж байгаа энэ хүнийг Есүсийн нэр тэнхээтэй болгосон юм. Түүгээр дамжуулан ирдэг итгэл нь түүнийг та бүгдийн өмнө цоо эрүүл болгожээ. Ах дүү нар аа! Захирагчид чинь мэдэхгүйн харгайгаар үйлдсэний адил та нар ч мөн тэгснийг би мэднэ. Өөрийнх нь Христ зовж гарчлах ёстой гэж Бурхан бүх эш үзүүлэгчдийн амаар урьдаас тунхаглуулсан зүйлсээ Тэр тийнхүү хэрэгжүүлэв. Иймээс гэмшигчээ. Нүглүүдээсээ салахын тулд эргэцгээ. Тэгвэл сэргээх цаг Эзэний оршихуйгаас ирэх бөгөөд та нарын төлөө томилогдсон Христ болох Есүсийг Тэр илгээх болно.

Тухайн үеийн шашны удирдагчид Петр, Иохан нарыг баривчлав. Гэхдээ энэ мэдээг сонсоод итгэсэн хүмүүсийн тоо таван мянга гаруй болжээ. Хавчлага, эсэргүүцэл гарсан итгэгчдийн тоо өсөн нэмэгдсээр байв.

Тэд нөгөө хэдийг голдоо зогсоогоод, -Ямар хүч, ямар нэрээр та нар үүнийг үйлдэнэ вэ? хэмээн байцааж эхлэв. Энэ үед Петр Ариун Сүнсээр дүүрч тэдэнд хандаж, -Ахлагчид болон ард түмний захирагчид аа! Хэрэв бид энэ хүн хэрхэн эдгэрсэн талаар уг өвчтэй хүнд сайн үйл хийснийхээ төлөө өнөөдөр байцаагдаж байгаа бол, та нарын цовдолсон, үхэгсдээс Бурханы амилуулсан Назарын Есүс Христийн нэрээр, энэ л нэрээр энэ хүн та нарын өмнө цоо эрүүл болоод зогсож байгааг та бүхэн бас бүх Израиль түмэн мэдтүгэй.

Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдсөнгүй гэв. Эрдэм номгүй, боловсролгүй Петр, Иохан хоёрын ийнхүү зүрх зоригтой байгааг нь тэд хараад гайхашгаан, тэднийг Есүстэй хамт байсныг нь мэдэв. Эдгэрсэн өнөөх хүн тэдний хамт зогсож байгааг хараад тэдэнд хариуд нь хэлэх зүйл юу ч байсангүй.

Эрх мэдэлтнүүд болон шашны удирдагч нар итгэгчдийг дахин Есүсийн нэрээр ярихгүй байхыг хатуу сануулаад сулласан боловч Петр, Иохан нар итгэгч нартай нэгдэн залбирав.

Одоо Эзэн ээ, тэдний заналхийллийг анхаараач. Таны үгийг ярих зүрх зоригийг Өөрийнхөө боолуудад соёрхооч. Таны ариун зарц Есүсийн нэрээр эдгээх гайхамшиг болон тэмдгүүдийг үйлдүүлэхийн тулд Та Өөрийн мутраа сунгаач гэв.

Ийнхүү залбирч байтал тэдний цугларан байсан газар нь доргин чичирхийлэв. Тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, Бурханы үгийг зоригтойгоор ярьж эхлэв. Итгэсэн тэдгээр хүмүүс нэг зүрх, сэтгэлтэй байсан бөгөөд тэдний хэн нь ч өөртөө байгаагаа минийх гэдэггүй, харин тэдний бүх юм нь нийтийнх байв.

Элч нар Эзэн Есүс Христийн амилсныг агуу хүчээр гэрчилж байсан бөгөөд тэдний бүгдийн дээр бялхам их нигүүлсэл байсан болой. Гачигдаж дутагдсан хүн тэдний дунд байсангүй. Учир нь газар, орон байр эзэмшигчид нь цөмөөрөө тэр бүгдээ худалдсан өртгийг нь авчирч, элч нарын хөлд тавихад, тэд хүн бүрд хэрэгцээнийх нь хэрээр хуваарилдаг байлаа.

Есүс Христийг энэ дэлхийд байхад Бурханы Хүч чадлыг илчилж байсан тэр л Ариун Сүнс Есүсийг Тэнгэрт буцсаны дараа итгэгч нараар дамжуулан адилхан зүйлсийг хийлгэж байв.

**Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ байна. Мөн үхэгсдээс Есүсийг амилуулсан Нэгэний Сүнс та нарын үхлийн биест чинь амь өгнө.** Та нарын дотор амьдарч буй тэр л Сүнс Есүс Христийн амьдралыг та нараар дамжуулан илчлэхийг хүсч байна.

Анхны итгэгч нарт байсан зүрх зориг, хайр ба хүч чадал нь Ариун Сүнснээс ирж байсан бөгөөд өнөөдөр ч гэсэн бид нарыг өөрсдийн гэр бүл болон үеийнхэндээ Бурханыг гэрчлэхэд туслах болно.

Жинхэнэ Аз жаргал нь Бурхантай хамтрах явдал мөн. Бид Түүнтэй хамтарснаар Ариун Сүнсний хүч чадлаар Есүс Христийн Сайн Мэдээг бусдад тунхаглах болно. Есүс ч гэсэн Өөрийн Үгээ гайхамшиг,

тэдмгүүдээр батлан бидэнтэй ажилладаг.

Та Бурханд амьдралд тань хүсэл, зорилгоо биелүүлэх боломжийг олговол та үгээр илэрхийлэхийн аргагүй баяр хөөрөөр дүүрч, Жинхэнэ аз жаргалд хүрнэ. Гэхдээ энэхүү Жинхэнэ Аз жаргал нь нэгэн өдөр Есүстэй Тэнгэрт уулзах үеийнхтэй зүйрлэхгүй. Тэр тантай нүүр тулан,

**“Сайн байна, итгэмжит сайн боол минь! Чи цөөн юманд итгэмжтэй байсан тул чамд ихийг хариуцуулъя. Эзнийхээ баяр баясгаланд ор”** гэнэ.

Магадгүй та энэ номыг санамсаргүй уншсан байж болох юм. Харин одоо Есүс Христийн ачаар таны амьдрал ямар агуу, гайхамшигтай байж болох талаар олж мэдлээ. Энэ боломжийг бүү алдаарай, Сатанд таныг хуурах боломжийг бүү өгөөрэй.

Бурханы танд бэлдсэн зүйлийг зуурч ав. Бурханы хүссэн хүн болохын төлөө тэмүүл. Мөнхийн амьдралыг бүрэн утгаар нь эдэлж амьдар. **Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно.**

Энэ номыг дахин дахин уншаарай. Хэрэгтэй бол бидний хаягаар хандаарай. Энэ ном таны гар дээр үнэгүй очсон тул бусдад мөн үнэгүй дамжуулаарай. Есүс хэлэхдээ: Үнэгүйгээр авснаа үнэгүйгээр өг.

Та Бурхантай хамтран үйлчлэх хамтын үйлчлэлд дараах залбирлаар өөрийгөө өргөөрэй.

*Тэнгэрлиг Аав минь ээ,*

*Би Танруу эргэж, Таны Хүүхэд болохын тулд Өөрийн Хүү, Есүсийг миний өмнөөс амиа өгөхийг зөвшөөрсөнд баярлалаа. Таны Хайр ба Хангалт миний амьдралын туршид хангалттай тул талархаж байна. Надад халамж тавьж, миний бүх хэрэгцээг хангасан Танд баярлалаа.*

*Эзэн минь, Та намайг авраад Өөртөө авалгүй харин Ариун Сүнсний хүчээр надаар дамжуулан Өөрийгөө бусдад таниулахыг хүсдэгийг ухаарлаа.*

*Христийн элчин сайд байна гэдэг нь өндөр хариуцлагатай тул зөвхөн Таны Хүчээр энэ үүргийг нэр төртэй өргөж чадна гэсэн итгэлтэйгээр даруухнаар хүлээн авч байна.*

*Тиймд, Таны дуудсан дуудлагыг биелүүлэх хүн болохын тулд надад хэрэгтэй бүхнийг Ариун Сүнсээрээ дүүргэн өгөөч. Миний амьдралын*

*туришд Есүс Христ алдаршиж, Түүнийг бусдад тунхаглах хүчийг авахын тулд Ариун Сүнснийг тань зүрх сэтгэлээ нээн урьжэ байна.*

*Есүс ээ, Та амласныхаа дагуу намайг Ариун Сүнсээр бялхаасанд баярлалаа. Би яг одоо Таны Үгийн дагуу Ариун Сүнснийг итгэлээрээ хүлээн авч, хүчирхэгэжин, Есүс Христийн нэрийг тунхаглаж, энэ нэрээр өвчтэй хүмүүс дээр гар тавин, бузар сүнснүүдийг хөөхөд Та надтай хамт ажиллаж, Өөрийн Үгээ гайхамшигт тэмдгүүдээр батлах тул Танд талархаж байна.*

*Би Сүнс дотор байж, Түүнтэй хөл нийлүүлэн алхахад Ариун Сүнсний үр жимсүүд миний амьдралд бялхан гарч, бусдад хүртээл болно гэдэгт итгэжэ байна.*

*Ариун Сүнс минь, миний амьдралыг Өөрийн хүссэн цагтаа, хүссэн газраа, хүссэнээрээ ашиглаарай. Бурханы дуудлагын дагуу Таны удирдамжийг хайх үед минь Та Өөрийн бэлгүүдийг болон Есүсийн амьдралыг надаар урсгаарай.*

*Есүсийн Нэрээр, Амен!*



## НЭМЭЛТ

Энэ хэсэгт таныг үр жимс арвинтай Христэд итгэгч ба Христийн төлөөлөгч байхад туслах хэд хэдэн сэдвийг хөндөх болно.

Эхний зүйл нь Баптисм буюу усан баталгаа юм. Библийн дагуу бол хүмүүс бүтэн биеэрээ усанд орж, уснаас гарч ирдэг. Үүнийг Есүсийн шавь нартаа өгсөн тушаалын дагуу үйлддэг юм.

**Есүс тэдэнд, -Бүх дэлхийгээр явж, сайн мэдээг бүх бүтээлд тунхаглагтун. Хэн итгэж баптисм хүртэнэ, тэр аврагдах болно. Харин итгээгүй хүн нь яллагдах болно.**

**Есүс ойртон ирээд, тэдэнд, -Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн. Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав.**

Усан баталгаа бол шинэхэн итгэгч болсон хүн Есүс Христийг өөрийн Аврагч, Эзэн болголоо гэдгийг хүмүүст гэрчлэн харуулах үйлдэл мөн. Тухайн хүний дотор болон сүнслэг ертөнцөд аль хэдийн болсон зүйлийг гадаад байдлаараа харуулж байгаа юм.

Дараах ишлэлүүдээс харахад Шинэ Гэрээний үед хүмүүсийг итгэнгүүт усан баталгаа хийдэг нь жирийн үзэгдэл байжээ.

**Петр тэдэнд, -Гэмшигтүн, хүн бүр өөрсдийн нүглийн уучлалын төлөө Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Та нар ч Ариун Сүнсний бэлгийг авах болно. Учир нь уг амлалт нь та нар болон та нарын хүүхдүүдийнх төдийгүй бас алсад суугч бүрийнх бөгөөд манай Бурхан Эзэнээр дуудагдсан болгоных билээ гэв. Тэр өөр олон үгээр гэрчлэн**

**-Энэхүү завхруулагч үеийнхнээс аврагдагтун гэж тэднийг сэнхрүүлж байлаа. Ийнхүү түүний үгийг хүлээн авсан хүмүүс баптисм хүртэцгээв. Тэр өдөр гурван мянга орчим хүн нэмэгджээ.**

**Филип ам нээн тэрхүү Судраас эхлэн Есүсийн тухай түүнд ярьж өгөв. Тэд замаараа явсаар устай газар хүрч иржээ. Тайган хүн -Хараач, ус байна. Баптисм хүртэхэд болохгүй нь юу билээ гэв. Филип -Хэрэв чи бүх зүрхээрээ итгэвэл, болно гэсэнд тэр -Есүс Христ бол Бурханы**

Хүү мөн гэдэгт би итгэж байна хэмээн хариулав. Мөнөөх тайган хүн тэргийг зогсоохыг тушаав. Тэгээд тэд хоёулаа ус уруу орж, Филип түүнд баптисм хүртээжээ.

**-Бидний авсанчлан тийнхүү Ариун Сүнснийг хүлээн авсан энэ хүмүүст баптисм хүртээхэд хэн ч уснаас татгалзаж чадахгүй биз дээ? гэлээ. Тэр тэдэнд Есүс Христийн нэрээр баптисм хүртэхийг тушаав. Дараа нь тэд түүнээс хэд хоног үлдээч гэж гуйлаа.**

**Синагогийн тэргүүн Крисп бүх гэрийнхнийхээ хамт Эзэнд итгэж бас коринтчуудаас олон хүн үгийг сонсоод итгэж, баптисм хүртэцгээж байлаа.**

Итгэгч хүний баптисм нь Эзэн Есүс Христийн төлөөс болсон үхэл, оршуулга, дахин амилалттай адил болж буйгаа харуулж байгаа хэрэг.

**Тиймд Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явахын тулд үхэл уруу баптисм хүртсэнээр Түүнтэй хамт оршуулагдсан юм.**

Тийм учраас та Христийн баптисм хийлгэ гэсэн тушаалыг дагаарай. Энэ бол шинэ амьдралаа бусдад харуулах гайхамшигтай боломж мөн. Танд баптисм хийх сүмийн төлөө залбираарай.

Та бусад итгэгч нартай хамт байх нь маш чухал билээ. Есүс болон Түүний Үгийг хайрладаг бусад итгэгч нартай Нөхөрлөх нь танд болон тэдэнд ч бас тустай. Бурхан таны амьдралд ямар гайхалтай зүйл хийсэн нь бусдад урам зориг өгч, Тэр бусдын амьдралд хийсэн зүйлс нь танд урам хайрлаж, ивээл болно.

Та долдугаар бүлгээс шинээр итгэгч болсон хүмүүс хамтдаа цуглаж, нэг нэгэндээ туслан, хамтдаа Бурханы Үгээс суралцаж, Бурханд магтаалыг өргөн, Есүс Христийн Сайн Мэдээг сонсоогүй байгаа хүмүүст хамтдаа гэрчилдэг болохыг уншсан.

**Бурханыг магтаж, бүх ардын хайр хүндэтгэлийг олж байв. Эзэн тэдэн дээр аврагдагсдын тоог өдрөөс өдөрт нэмэгдүүлж байлаа.**

**Петрийг шоронд хоригдож байхад чуулган Бурханд хандаж түүний төлөө хичээнгүйлэн залбирч байв.**

Итгэгч нар өөр цагт, өөр өөр газар цуглардаг байв. Тэд хаана цуглах нь хамаагүй, харин нэг нэгэндээ туслаж, дорой нэгнээ босгохын тулд байнга хийдэг байсан зүйлс нь чухал байлаа. Бурханаас ивээгдсэн

нэгэн нь хэрэгцээтэй байгаа бусаддаа тусалдаг байжээ.

Өнөө үед байшин барилгыг Сүм гэдэг болж, гэхдээ Библид Есүс Христэд итгэгч бүлэг хүмүүсийг Сүм гэж заажээ. Улмаар Сүм гэдэг нь байшин барилга бус харин хүмүүсийг хэлж байгаа юм.

**Энэ ертөнц болон түүний дотор буй бүхнийг бүтээсэн Бурхан бол тэнгэр, газрын Эзэн бөгөөд хүний гараар барьсан дуганд оршдоггүй.**

Есүс: Учир нь хоёр буюу гурван хүн Миний нэрээр хаана цуглана, тэнд Би тэдний дунд байна гэж айлдав. Бурханыг магтаж, нэг нэгнээ урамшуулж, Эзэн дотор босгохын тулд Есүсийн нэрээр цугларч байвал Бурханы Сүнс тэнд байх болно.

Та бол Ариун Сүнсний орших сүм гэдгээ мартаж болохгүй. Бурхан таны дотор Сүнсээрээ оршихыг хүсдэг юм. Тэр үнэхээр хайрын Бурхан мөн. Таны дотор буй Бурханы Сүнсэнд ганцаар болон бусадтай хамт байхдаа мэдрэмжтэй байгаарай. Бурханыг өөрийн биеэр хүндэл.

**Та нар өөрсдөө Бурханы сүм мөн бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршдог гэдгийг мэддэггүй юм уу?**

Долдугаар бүлэгт, Ариун Сүнс анхны итгэгчдийн дотор оршиж, тэднийг хаана ч явсан хамт байж, гэрчлэлд нь тусалж байв. Тэд өдөр болгон Эзэний нэрээр цугларч, хамтдаа хооллож, байгаа бүхнээ хэрэгцээнийхээ дагуу хуваалцаж, бусдад Есүс Христийн Сайн Мэдээг тунхаглаж байсан юм.

Одоо таны амьдралын зорилго бол Есүсийг өөрийн үг ба үйлдлээр бусдад таниулахад байгаа юм. Та бол Бурханы сонгосон ваар бөгөөд Тэр зөвхөн таны дотор байхаас гадна танаар Өөрийгөө илчлэхийг хүсч байдаг юм. Та бол онцгой хүн бөгөөд Бурхан танаар дамжуулан энэ дэлхийд Өөрийн хүслээ биелүүлхийг хүсч байна.

Та өөрийгөө бүхэлд нь амьд Бурханд өргө. Энэ нь тийм амаргүй ч, шагналтай. Та зарим итгэгч нарын адил хавчлага эдэлж болох авч тур зуурын зовлон нь таны дотор байх алдрын дэргэд өчүүхэн байх болно. Бурханы нэгэн агуу зарцын үгийг харцгаая.

**Ярьдаг хүн нь Бурханы үгийг яаж хэлдэгчлэн яриг. Үйлчилдэг хүн нь Бурханаас тэтгэгддэг хүчээр үйлдэг. Яагаад гэвэл “Харанхуйгаас гэрэл гэрэлтэг” гэж айлдсан Бурхан бол Христийн нүүрэн дэх Бурханы алдрын мэдлэгийн гэрлийг өгөхөөр бидний зүрхэнд гэрэлтсэн Нэгэн мөн. Хүчний давамгайлал нь биднээс биш, харин Бурханых байхын тулд бид энэхүү баялгийг шавар савнуудад тээдэг.**

Бид бүх талаараа зовдог боловч няцардаггүй. Сандардаг боловч цөхөрдөггүй. Хавчигддаг боловч хаягддаггүй, цохигддог боловч мөхдөггүй. Бид биедээ Есүсийн үхлийг үргэлж тээж явдаг. Ингэвэл Есүсийн амь мөн бидний бие дотор илэрхийлэгдэх юм.

“Би итгэсэн. Тиймээс би ярьсан” гэж бичигдсэний дагуу бидэнд ч адилхан итгэлийн сүнс байж, бид ч гэсэн итгэдэг. Тиймээс бид бас ярьдаг юм. Эзэн Есүсийг амилуулсан Нэгэн биднийг ч бас Есүстэй хамт амилуулж, биднийг та нарын хамт Өөрийнхөө өмнө аваачна гэдгийг бид мэддэг.

Учир нь бүх юмс та нарын төлөө байдаг билээ. Энэ нь нигүүлсэл улам олон хүнд нэмэгдэж, Бурханд алдар хийгээд талархлыг бялхсанаар өргөхийн тулд юм. Тиймээс бид зүрх алддаггүй. Хэдийгээр гаднах хүн маань ялзарч байгаа ч доторх хүн маань өдрөөс өдөрт шинэчлэгдэж байна.

Учир нь цаг зуурын ялихгүй зовлон нь бидэнд мөнх алдрыг үлэмж арвинаар бий болгож байна. Бид үзэгдэх юмсыг бус, харин үл үзэгдэх юмсыг хардаг. Учир нь үзэгдэх юмс бол түр зуурынх, харин үл үзэгдэх юмс бол мөнх билээ.

Бид хүнд хэцүү шалгуур сорилтонд орохдоо:

Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч болох Есүс уруу хараагаа чиглүүлье. Тэр Өөрийнх нь өмнө тавигдсан баяр баясгалангийн төлөө гутамшигийг эс тоомсорлон, загалмайг тэвчсэн бөгөөд Бурханы сэнтийн баруун гарт заларсан юм.

Ах дүү нар минь, элдвийн сорилтод орохдоо үүнийг бүрэн баяр хөөр гэж үз. Та нарын итгэлийн сорилт тэсвэр хатуужлыг төрүүлдэг гэдгийг та нар мэдэх билээ. Тэсвэр хатуужил нь төгс үр дүнтэй байг. Тэгвэл та нар юугаар ч дутахгүй төгс, бүрэн бүтэн байна.

Тэвчээр гэдэг бол итгэгч хүний амьдралын чухал хэсэг мөн. Бид энэ зан чанарыг хөгжүүлэхгүй бол бидний итгэл маань шалгагдаж, цэвэр болж чадахгүй.

Сайныг үйлдэхдээ зүрхшээхгүй байцгаая. Учир нь хэрэв бид шантрахгүй байвал цаг нь болохоор хурааж авна.

Итгэл найдвараа бүү орхи, учир нь та цагтаа шагнал авна. Та Бурханы Хүслийг биелүүлж, Түүний амлалсан зүйлийг авахын тулд тэвчих хэрэгтэй.

Бидний амьдралын хэмжүүр бол “хайраар илчлэгдэх итгэл” мөн. Нөхцөл байдал ямар ч хэцүү байхаас үл хамааран та Бурханы Үгэнд итгэх итгэлээ сахиж, хайрын амьдралаар амьдрах ёстой. Та Бурханы амлалтуудаас алдаж болохгүй.

Бурханы Үгэнд итгэх итгэл тань нэг л болохгүй байх үед орхих бус харин ч тэвчих хэрэгтэй гэдгийг харуулж байгаа юм. Өөр хүмүүс танд муу зүйл хийвэл тэднийг хайрлахаа бүү зогсоо, **хорон мууг хорон муугаар бүү хариул, харин мууг сайнаар дийл.**

Эцэст нь Эзэн дотор ба Түүний чадлын агуу хүч дотор бэхжигтүн. Та нар диаволын заль мэхний эсрэг бат зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн хуяг дуулгыг өмс. Учир нь бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчнүүд, тэнгэр дэх бузар муугийн сүнслэг хүчний эсрэг билээ.

Тиймээс бүхнийг хийсний дараа, бузар муу өдөрт эсэргүүцэн бат зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн зэвсгийг ав. Тэгээд бат зогс. Ингэхдээ та нар бэлхүүсээрээ үнэнийг бүсэлж, зөвт байдлын хуягийг өмсөөд, амар тайвны сайн мэдээний бэлэн байдлыг хөлдөө өмс. Энэ бүгд дээр муу нэгний бүх галт сумыг унтрааж чадах итгэлийн амбай, авралын дуулгыг болон Сүнсний сэлэм буюу Бурханы үгийг ав. Сүнс дотор цаг үргэлж аливаа залбирал ба гуйлтаараа залбир. Үүний тулд бүх ариун хүмүүсийн төлөөх цөхрөлтгүй бүх оролдлого, гуйлтаараа сэргэг бай.

Итгэлийн сайн тэмцлээр тэмц. Мөнх амийг барьж ав. Чи мөнх амь уруу дуудагдсан бөгөөд олон гэрч нарын өмнө сайн гэрчлэл хийсэн. Тэгвэл бид эдгээр зүйлийн тухайд юу хэлэх вэ? Хэрэв Бурхан бидний талд юм бол, хэн биднийг эсэргүүцэх вэ? Бяцхан хүүхдүүд ээ, та нар Бурханых бөгөөд тэднийг дийлсэн. Учир нь та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгч нэгнээс аугаа.

Өгөгч бай. Бурханы танд өгсөн болгоноо бусадтай хуваалц. Үнэгүйгээр хүлээн авсан тул үнэгүй өг. Өгөх нь авахаасаа илүү ивээлтэй. Хэрэгцээтэй байгаа хүний хараад бүү гар тат, харин тэдэнд Есүсийн нэрээр тусал.

Есүс удахгүй ирнэ! Тэр энэ дэлхийд байхдаа: Миний Эцэгийн гэрт орон байр олон бий. Хэрэв тийм биш байсан бол Би та нарт хэлэх байсан. Би та нарт орон байр бэлдэхээр явна. Хэрэв Би явж та нарт орон байр бэлдвэл, дахин ирж, та нарыг Өөртөө авна. Би хаана байна, та нар мөн тэнд байх болно. Миний явах газарт очих замыг та нар мэднэ гэж айлдав.

Тиймээс хэрэв та нар Христтэй хамт амилуулагдсан л юм бол дээгүүрх зүйлсийг эрсээр бай. Тэнд Христ Бурханы баруун талд заларч байгаа. Та нар оюун ухаанаа газар дахь зүйлс дээр биш, харин дээгүүрх зүйлс дээр төвлөрүүл. Учир нь та нар үхсэн бөгөөд та нарын амь Христтэй хамт Бурхан дотор нууцлагдсан. Бидний амь болох Христ илчлэгдэх үед та нар ч бас яруу алдар дотор Түүний хамт илчлэгдэх болно.

## Бурханы Үг

Бурханы бичигдсэн Үг болох Библи бол энэ номын үндэс суурь мөн. Энэ номонд бичигдсэн бүхэн Бурханы Үгэнд буй Үнэн дээр суурилагдсан юм. Библи бол Бурханы хүн төрлөхтөнд Өөрийгөө илчилсэн илчлэлт мөн.

Энэ номонд Библиэс маш олон иш татсан байгаа. Тэдгээрийг **тод хар** өнгөөр ялгасан болно. Та дахин уншихдаа Бурханы Үгэнд онцгой анхаарал тавиарай. Библийн тухай гэвэл:

**Бичээсийн ямар эш үзүүлэг эш үзүүлэгчийн өөрийн тайлбараас гэдгийг бүхнийг ойлгож ав. Эш үзүүлэг нь хэзээ ч хүнээс гардаггүй, харин хүмүүс Бурханы өмнөөс Ариун Сүнсээр ярьдаг юм.**

Христ Есүст итгэх итгэлээр дамжуулан авралд хүргэх мэргэн ухааныг чамд өгөх чадалтай Ариун Бичээсүүдийг чи бага наснаасаа мэдэх болсон. Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай. Энэ нь Бурханы хүн аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм.

Бурханы Үгийг хэлж, бичих хүмүүсийг Бурхан сонгосон бөгөөд тэдэнд Өөрийн Үгээ Ариун Сүнсээр амь амьсгал мэт өгөн байдаг. Бурхан хэдий хүнийг ашиглаж Үгээ бичүүлсэн боловч Библи нь хүний үг бус харин Бурханы Үг мөн. Бурхан мөнх байдгийн адил Үг нь мөнх бөгөөд хэзээ ч устахгүй.

**Өө Эзэн, Таны Үг мөнх бөгөөд мөнхөд Тэнгэрт орших болно.**

**Тэнгэр, газар уставч Миний Үг хэзээ ч устахгүй.**

**Өвс хатаж, цэцэг гандана. Харин бидний Бурханы үг мөнхөд тогтоно.**

**Бурханы Үг бүр алдаа мадаггүй, Түүнд хорогдогч бүхэн аюулгүй байх болно.**

Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог бөгөөд зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм.

**Учир нь эрт үед бичигдсэн аливаа зүйлс нь биднийг сургахын тулд бичигдсэн юм. Ингэснээр Судруудын тэвчээр болон урамшуулалтаар дамжуулан бидэнд найдвар байх юм.**

Бурханы Үг бол таны уншвал зохих хамгийн чухал зүйл мөн. Та энэ номыг дахин дахин уншиж, судлахдаа **Тод хараар** бичигдсэн Бичээсээс Үнэний сууриа тавих болно.

Жинхэнэ Аз Жаргал гэсэн энэ ном нь Бурханы үг биш ээ. Гэхдээ энэ номонд олонтаа Библиэс иш татсан байгаа. Та дараагийн хуудсанд буй захиалгын хуудсыг бөглөөд бидэнд илгээгээрэй. Бидэнд энэ ном байвал танд заавал үнэгүй илгээнэ. Хэрэв энэ ном танд тус болсон бол бусдад ч гэсэн Есүсийг таньж мэдэхэд тусална. Та залбирч байгаад хэдэн номыг хэн хэнд өгөхөө шийдээрэй.

Сүүлчийн хоёр хуудсанд Бурханы Авралын төлөвлөгөөг хураангуйлсан байгаа. Та үүнийг Бурхантай эвлэрэн, Есүс Христийг Аврагч ба Эзэн болгох хүсэлтэй хүмүүстэй уулзахдаа ашиглаарай. Хэн нэгнийг Бүтээгч Эзэнтэй нь Хүү Есүс Христээр нь эвлэрүүлэх нь таны итгэлийн амьдралын хамгийн дурсамжтай сайхан мөчүүд байх болно. Та бусдад Жинхэнэ Аз Жаргалд хүрэхэд туслахдаа өөрөө ч гэсэн үнэхээр ерөөгдөх болтугай.



# Захиалга

Огноо: \_\_\_\_\_

Надад ..... ширхэг Жинхэнэ Аз Жаргал номыг илгээнэ үү. Та бидэнтэй дараах хаягаар харилцахдаа буцах хаягаа тодорхой бичээрэй.

Нэр:

Хаяг: \_\_\_\_\_

Харьяа сүм чуулган: \_\_\_\_\_

Утас гэрийн, ажлын , гар: \_\_\_\_\_

Ажил мэргэжил: \_\_\_\_\_ Нас: \_\_\_\_\_

Та тасархай зураасын дагуу ураад, доорх хаягаар илгээнэ үү.

Илгээлт нөхөд  
Шуудангийн хайрцаг 180  
Улаанбаатар 211213

Та арын нүүрэнд энэ номыг хэнээс авсан болон танд хэрхэн нөлөөлсөн тухай товч бичээрэй. Мөн одоо авах гэж байгаа номнуудаа хэн хэнд хэрхэн өгөх гэж байгаагаа бидэнтэй хуваалцаарай.



## Бурханы Аварлын Төлөвлөгөө

Орчлон Ертөнцийг бүтээсэн Бүтээгч Бурхан таныг Түүнтэй дотны харилцаатай байж, жинхэнэ аз жаргалтай байхаар бүтээсэн юм. Гэвч та болон хүн төрлөхтөн Бурханы итгэлийг эвдэж, Түүнээс нүүр буруулан амьдрахыг сонгосон юм.

Диавол буюу Сатан Бурханы жинхэнэ зан чанарын талаар худал хэлж, хүнийг хууран мэхэлж, Бурханд эргэлзэн, Түүний эсрэг нүгэл үйлдэхэд хүргэжээ. Нүгэл, үл итгэл, дуулгаваргүй байдал зэрэг нь Бурханы анхнаасаа хүн болгонд зориулсан Жинхэнэ аз жаргалаас салгасан юм.

Хүн гэмээс болж Бурханаас тусгаарлагдснаар зөвхөн Түүнээс өөр хэн ч орлож чадахгүй зүрх сэтгэлийн хоосон орон зайтай үлдсэн юм. Зуун зууны туршид хүмүүс тэр хоосон орон зайгаа энэ хорвоогийн үй олон шашин шүтлэг, сайн муу бүхий л зүйлсээр дүүргэх гэж оролдсон боловч ганцаардал, хоосрол, айдас, самууралтай хоцорсон.

Бурхан Өөрсдийн төрхөөр бүтээгдсэн хүнийг хайрлахаа хором ч зогсоосонгүй, харин ч бүх хүн төрөлхтнийг Хүү Есүс Христээр дамжин Өөр рүү нь эргэж, аврагдаасай гэж хүссээр байсан юм.

**Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм. Бурхан Өөрийн Хүүгээ ертөнцийг яллахын тулд биш, харин Түүгээр дамжуулан ертөнцийг аврахын тулд ертөнц уруу илгээсэн билээ.**

**Есүс, -Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй.**

**Тэр нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө нүгэл болгосон юм. Тэгснээр бид Түүний дотор Бурханы хүртээх зөвт байдал болох юм.**

**Учир нь Христ ч нэг удаа нүглийн төлөө үхэж, зөвт нь зөвт бусыг орлосон. Энэ бол хамгийн чухал хэрэг байлаа. Судрын дагуу Христ бидний нүглийн төлөө үхсэн бөгөөд оршуулагдан, Судрын дагуу гурав дахь өдөртөө амилуулагджээ.**

Таны бүх нүгэл уучлагдан, Бүтээгч Бурхантайгаа Есүсээр дамжин зөв харилцаатай болж, Жинхэнэ аз жаргалыг амсахын тулд Христ таны төлөө үхжээ.

Есүс,- Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм.

Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарыг амраая. Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь Би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд та нар сэтгэлдээ амралтыг олох болно.

Есүс тэдэнд дахин

-Би бол ертөнцийн гэрэл мөн. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно гэж айлдав.

Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Христ Есүс доторх мөнх амь мөн.

Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв.

Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ.

Эзэний Нэрээр дуудагч хүн бүр аврагдах болно.

Та яг одоо Эзэний нэрийг дуудаж, Есүс Христийн өөрийн Аврагч, Эзэн болгон хүлээж авахыг хүсвэл дараах байдлаар залбираарай.

*Бурхан минь,*

*Есүс миний төлөө үхсэн бөгөөд Та Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт итгэж байна. Өөрийн Хүүгээ миний төлөө өгсөнд баярлалаа. Яг одоо би Эзэний Нэрийг дуудаж, Түүнийг өөрийн зүрх сэтгэлдээ амьдралынхаа Аврагч Эзэн болгож байна. Намайг нүглийн шийтгэлээс чөлөөлж, Өөртэйгөө зөв харилцаатай болгосонд тань талархая. Өдөр бүр Таныг илүү таньж, Танд тааламжит амьдралаар амьдрахад минь туслаарай. Би бүх амьдралаа Танд даатгаж, Таныг дагаж амьдрахыг хүсч байна. Би Танд хайртай!*

*Есүсийн нэрээр, Амен!*

### ***Жинхэнэ аз жаргал таных ч болж болно ...***


Жинхэнэ аз жаргал гэдэг нь бид бүхний хүсэн эрэлхийлж байдаг зүйл юм. Бид бүгдээр яс үндэс, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн байр суурь, оюуны чадамж, итгэл бишрэл болон боловсрол зэргээс үл хамааран бид бүгд жинхэнэ аз жаргалыг амсахыг хүсдэг. Жинхэнэ

аз жаргалыг олж авах гэсэн энэхүү нийтлэг хүсэл эрмэлзэл маань бидний өдөр тутмын амьдралын салшгүй нэгэн хэсэг байх ёстой бөгөөд хүн бүр өөр өөрийн арга замаар өөрсдийгөө зөвтгөн байж үүнийг эрэлхийлдэг.

Энэ ертөнц бидэнд жинхэнэ аз жаргалд хүргэж бүх зүйлсийг өгөх гэж хичээдэг боловч хэрэв бид шударга дүгнэлт гаргах аваас бидний амьдралд ямар нэгэн зүйл өгүүлэгдэн, аз жаргал үгүй байгааг хүлээн зөвшөөрөх буй заа.

Зохиогч бид энэ номыг уншсан хэн ч болов жинхэнэ аз жаргалтай амьдрах хувь тавилантай хүн мөн гэдэгт гүнээ итгэдэг.

***Жинхэнэ аз жаргал таных ч болж болно ...***



## **Жинхэнэ аз жаргал таных ч болж болно**

Жинхэнэ аз жаргал гэдэг нь бид бүхний хүсэн эрэлхийлж байдаг зүйл юм. Бид бүгдээр яс үндэс, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн байр суурь, оюуны чадамж, итгэл бишрэл болон боловсрол зэргээс үл хамааран бид бүгд жинхэнэ аз жаргалыг амсахыг хүсдэг. Жинхэнэ аз жаргалыг олж авах гэсэн энэхүү нийтлэг хүсэл эрмэлзэл маань бидний өдөр тутмын амьдралын салшгүй нэгэн хэсэг байх ёстой бөгөөд хүн бүр өөр өөрийн арга замаар өөрсдийгөө зөвтгөн байж үүнийг эрэлхийлдэг.

Энэ ертөнц бидэнд жинхэнэ аз жаргалд хүргэх бүх зүйлсийг өгөх гэж хичээдэг боловч хэрэв бид шударга дүгнэлт гаргавал бидний амьдралд ямар нэгэн зүйл үргэлж үгүйлэгдэж, аз жаргалгүй байгаагаа хүлээн зөвшөөрөх биз ээ. .

Зохиогч бид энэ номыг уншсан хэн ч бай жинхэнэ аз жаргалтай амьдрах хувь тавилантай хүн болно гэдэгт гүнээ итгэдэг.

Жинхэнэ аз жаргал таных ч болж болно...